

## 2020 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2020 оны 12 дугаар сарын 09

Улаанбаатар хот

### 9.1.1 НЭГДҮГЭЭР БҮЛЭГ “БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН”

Эмнэлгийн Түргэн тусламж үйлчилгээний журмыг Нийслэлийн Эрүүл мэндийн газар болон ЭМЯ-ны Яаралтай тусламжийн мэргэжлийн салбар зөвлөлтэй хамтран боловсруулан Эрүүл мэндийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн А/294 тоот “Түргэн тусламжийн үйлчилгээг зохион байгуулах үлгэрчилсэн журам” батлагдан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн байгууллагын үйл ажиллагааны журмуудыг шинэчлэн гарган мөрдөж байна. Ингэснээр дуудлагын ангилал тогтвортой болж, хүлээгдэл буурч салбар хоорондын уялдаа холбоо сайжирсан.

Стандартчилал хэмжил зүйн Үндэсний төвийн 2018 оны 05 сарын 31-ны 09 тогтоолоор Түргэн тусламжийн үйл ажиллагааны стандарт MNS6717:2018 стандартыг мөрдлөг болгон шаардлагатай орон тоо, эмнэлгийн хэрэгсэл, автомашиныг зохих шатны байгууллагад хандан ажиллаж байгаа болно.

Коронавируст халдвар /Ковид-19/ ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, гийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль болон Эрүүл мэндийн сайдын 2020 оны 269 тоот тушаалыг мөрдөн Цар тахал “Covid-19” үеийн бэлтгэл бэлэн байдлын ханган төлөвлөгөө гарган цаг тухай бүрд нь тодотгож ажилласан

### а/ “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”

Зорилт 2: Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх хүүхдийн эндэгдэл, хоол тэжээлийн дутагдлыг тогтвортой бууруулна.

1. 2020 оны 12 сарын 05-ны байдлаар тус төвийн үйл ажиллагаатай холбоотой эхийн эндэгдэл гараагүй. Эмнэлгийн бус, гэрийн төрөлт 103 тохиолдол гарсан ба 2019 оны мөн үеэс 20 тохиолдлоор нэмэгдсэн. Гэрийн төрөлтөд тусламж үзүүлж, амаржих газар тээвэрлэн гэрийн төрөлттэй холбоотой эмч нарын дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, аргачлал зөвлөмж гарган ажиллаж байна. Шалтгаан нь тулгаж дуудсан, амаржих буцаасан, замын түгжрэл, иргэдийн эрүүл мэндийн боловсролтой хамааралтай байна.
2. 0-5 хүртэлх насны эндэгдэл: 2020 онд 0-5 насны хүүхдийн 34 тохиолдол байсан ба 2019 оны мөн үеэс 8 тохиолдлоор буурсан. Эндэгдлийн шалтгаан нь осол болон өвчлөлийн байна.
3. Нялхсын эндэгдэл 0-28 хоногтой нярайн эндэгдэл 2020 оны жилд 2 гарсан ба өмнөх оны мөн үеэс 4 тохиолдлоор буурсан.

### б/Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого /2017-2026 он/


Засгийн газрын 2016 оны 261 дүгээр тогтоолд тусгагдсан зорилго

1. Эмнэлгийн яаралтай тусламжийн төвлөрлийг сааруулах, түргэн тусламжийн дуудлагын хугацааг багасгах, алслагдсан болон газар зүйн саад бэрхшээлтэй нутагт оршин сууж байгаа иргэдэд үзүүлэх яаралтай тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд:

ТТТөвийн 2020 оны жилийн үндсэн үйл ажиллагааг  
өмнөх оны мөн үетэй харьцуулсан үзүүлэлт


Д/Д	Үндсэн үзүүлэлт	2019 он		2020 он		Харьцуулалт	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
A	<b>Нийт дуудлага</b>	<b>312146</b>	<b>100%</b>	<b>288891</b>	<b>100%</b>	<b>-23255</b>	<b>-8.0%</b>
Үүнээс	Насанд хүрэгчдийн дуудлага	271429	87.0%	261446	90.5%	-9983	5.3%
	Хүүхдийн дуудлага	40717	13.0%	27445	9.5%	-13272	-3.5%
Насанд хүрэгчдийн дуудлага	Үр дүнгүй дуудлага	13300	4.9%	13585	5.2%	-285	3.0%
	Төрөх	18728	6.9%	17733	6.8%	-995	-0.1%
	Осол гэмтэл	52018	19.2%	54423	20.8%	2405	1.6%
	Өвчлөл	187383	69.0%	175705	67.2%	-11678	-8.1%
B	<b>Яаралтай дуудлага</b>	<b>216313</b>	<b>79.7%</b>	<b>217792</b>	<b>83.3%</b>	<b>1479</b>	<b>3.6%</b>
<b>20 минутын очилт</b>		<b>184941</b>	<b>85.5%</b>	<b>195581</b>	<b>89.8%</b>	<b>10640</b>	<b>4.3%</b>
C	Гэрийн төрөлт	83	04%	103	0.6%	20	0.2%
D	Нас баралт /нийт/	2928	1.1%	3337	1.3%	409	0.2%
Зүрхний шигдээс		2902	1.1%	3006	1.1%	-104	0.0%
Тархины цус харвах		320	0.1%	290	0.1%	-30	0.0%
Даралт ихдэх		31932	11.8%	29613	11.3%	-2319	-0.5%
Хоол шингээх эрхтний бусад		5601	2.1%	3202	1.2%	-2399	-0.9%
Умайн цус алдалт		176	0.1%	199	0.1%	23	0.0%
Амьсгалын замын цочмог халдвар		12740	4.7%	10216	3.9%	-2524	-0.8%
Бөөр шээсний замын бусад		8608	3.2%	7543	2.9%	-1065	-0.3%
Халдварт өвчин		546	0.2%	315	0.1%	-231	-0.1%
Хорт хавдар		5769	2.1%	5126	2.0%	-643	-0.1%
Сэтгэцийн өвчлөл		1079	0.4%	807	0.3%	-272	-0.1%
Бусад		117710	43.4%	115388	44.1%	-2322	0.7%

Дүгнэлт: 2020 онд нийт дуудлага 8.0%-иар буурсан нь коронавирусийн бүх нийтийн бэлэн байдлын хатуу хөл хорио болон иргэдэд шаардлагагүй дуудлагад зөвлөгөө өгөх, ажиглах үйл ажиллагаа явуулсантай холбоотой. Хүүхдийн дуудлага өмнөх оноос 3.5%-иар, насанд хүрэгчдийн дуудлага мөн адил 3,5%-иар тус тус буурсан нь томуугийн өвчлөл, сургууль цэцэрлэгийн үйл ажиллагаа хаагдсантай холбоотой.





Дүгнэлт: Гэрийн төрөлтөмнөх оноос 0,2%-иар, нас баралт 0,2%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.





Яаралтай дуудлагын тоо өмнөх үеэс 3,6%-иар нэмэгдэж 20 минутын очилт 4,3%-иар өссөн байгаа нь 19-Covid үеийн хөл хориотой холбоотой замын түгжрэл буурснаар дуудлаганд хурдан шуурхай очиж эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.

Дүгнэлт: Хүүхдийн дуудлага өмнөх оны мөн үеэс -13327 буюу -48.5%-иар буурсан. Явж үзсэн дуудлага 13271, амбулаториор ирж үзүүлэгсэд 56-аар буурсан. Өвчлөлөөр задалж үзэхэд нярайн эмгэг -2.2%, мэдрэлийн эмгэг -1.6%, амьсгалын замын эмгэг -2.8%-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

*ТТТөвийн 2020 оны хагас жилийн хүүхдийн дуудлагыг өмнөх оны мөн үетэй харьцуулсан үзүүлэлт*


д/д	Үндсэн үзүүлэлт	2019 он		2020 он		Харьцуулалт	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
<b>A</b>	<b>Салбаруудын нийт хүүхдийн дуудлага</b>	<b>40789</b>	<b>100%</b>	<b>27462</b>	<b>100%</b>	<b>-13327</b>	<b>-48.5%</b>
Үүнээс	Явж үзсэн дуудлага	40717	99.8%	27446	99.9%	-13271	-48.3%
	Амбулатор	72	0.2%	16	0.1%	-56	-0.2%
	Утсаар зөвлөгөө өгсөн	223890		232890		9000	
	Яаралтай дуудлага	6809	16.7%	5921	21.5%	-888	4.8%
	20 минутын очилт	6409	94.1%	5765	97.3%	-644	3.2%

<b>В</b>	<b>Өвчлөл</b>	<b>40694</b>	<b>91.8%</b>	<b>25179</b>	<b>96.0%</b>	<b>-15515</b>	<b>4.2%</b>
Үүнээс	Нярайн эмгэг	1761	4.3%	1625	6.5%	-136	-2.2%
	Мэдрэлийн эмгэг	3331	8.2%	2478	9.8%	-853	-1.6%
	Амьсгалын замын эмгэг	22504	55.3%	13216	52.5%	-9288	-2.8%
	Хоол боловсруулах замын эмгэг	4512	11.1%	3248	12.9%	-1264	8.1%
	Мэс заслын эмгэг	428	1.1%	319	1.3%	-109	0.2%
	Халдварт өвчин	389	1.0%	150	0.6%	-239	-0.4%
	Бусад өвчин	7769	19.1%	4143	16.5%	-3626	-2.6%



Дүгнэлт: Яаралтай дуудлага өмнөх оны мөн үеэс 4,8%-иар буурч, яаралтай дуудлагын 20 минутын очилт 3,2%-иар өссөн үзүүлэлттэй байна.

## Хүүхдийн өвчлөл




### ТТТөвийн 2020 оны хагас жилийн эмнэлгийн тусламж үйлчилгээ ний өмнөх онтой харьцуулсан үзүүлэлт

Эмнэлгийн тусламж үйлчилгээ		2019 он		2020 он		Харьцуулалт	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Нийт дуудлага		312146	100%	230128	100%	-82018	-35.6%
<b>A</b>	<b>Осол гэмтлийн дуудлага</b>	<b>52018</b>	<b>16.7%</b>	<b>54423</b>	<b>23.6%</b>	<b>2405</b>	<b>6.9%</b>
Шархны ан ны цэгцэлгээ		4213	8.1%	4236	7.8%	23	-0.3%
Боолт		5084	9.8%	4961	9.1%	-123	-0.7%
Чиг		828	1.6%	735	1.4%	-93	-0.2%
Новокайны хориг		210	0.4%	127	0.2%	-83	-0.2%
<b>B</b>	<b>Зүрх судас болон мэдрэлийн хурц эмгэг</b>	<b>35154</b>	<b>11.3%</b>	<b>33840</b>	<b>14.7%</b>	<b>-1314</b>	<b>3.4%</b>
ЭКГ		106	0.3%	22	0.1%	-84	-0.2%
ЗСА сэхээн амьдруулалт		142	0.4%	145	0.1%	-84	0.2%
Хүчилтөрөгч өгсөн		4236	12.0%	3978	11.8%	-258	-0.2%
Шингэн залгасан		730	2.1%	784	2.3%	54	0.2%
<b>C</b>	<b>Бусад өвчлөл</b>	<b>224974</b>	<b>72.1%</b>	<b>141865</b>	<b>61.6%</b>	<b>-83109</b>	<b>-10.5%</b>
Судас тариа		20938	9.3%	22500	15.9%	1562	6.6%
Бус д тариа		24853	11.0%	25989	18.3%	1136	7.3%
Эмнэлэгт хүргэсэн		47244	21.0%	39213	27.6%	-8031	-6.6%
Бусад хэлбэрийн		208153	92.5%	202905	143.0%	-5248	50.5%

Эмнэлгийн тусламж үйлчилгээний үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад осол гэмтлийн үед үзүүлэх тусламж 6.9%, зүрх судас болон мэдрэлийн хурц эмгэгийн үед үзүүлэх тусламж 3,4%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.


### Осол гэмтлийн үеийн тусламж

■ 2019 он ■ 2020 он




### Зүрх судас болон мэдрэлийн хурц эмгэгийн үеийн тусламж

■ 2019 он ■ 2020 он




### Бусад хэлбэрийн тусламж

■ 2020 он ■ 2019 он



**ТТТөвийн дуудлагын хүлээгдэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулсан үзүүлэлт**

Үзүүлэлт		2019 он		2020 он		Харьцуулалт	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
<b>Нийт дуудлага</b>		<b>308788</b>	<b>100%</b>	<b>321899</b>	<b>100%</b>	<b>13111</b>	<b>9,4%</b>
Хүлээгдэлийн минут	0-20 минут	108987	35,3%	147695	45,9%	38708	10,6%
	21-40 минут	103419	33,5%	101494	31,5%	1925	-2,0%
	41-60 минут	54265	17,6%	43196	13,4%	11069	-4,2%
	61-с дээш минут	42117	13,6%	29514	9,2%	12603	-4,4%



*Дүгнэлт: Дуудлагын 0-20 минутын хүлээгдэл 10,6%-иар өсч, 21-с дээш минутын хүлээгдэл 3,5%-иар буурсан үзүүлэлттэй байна.*


**в/ Нийгэм эдийн засгийн зорилтууд**

- 4.2.12. Дүүргийн түргэн тусламжийн төвүүдийн үйл ажиллагааг бэхжүүлэн, автомашины парк шинэчлэлт хийж, дуудлагын 20 минутын доторхочилтыгнэмэгдүүлнэ.
- 4.4.3. “Улаанбаатар Марафон” олон улсын гүйлтийн тэмцээн, Нийслэлийн иргэдийн спортын наадмыг олон төрлөөр жил бүр өргөн хүрээнд зохион байгуулах
- 4.2.7.Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлнэ.
- 4.1.16.Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг мэргэжил боловсролоо дээшлүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажил зохион байгуулах
- 4.4.5. Идэвхтэй хөдөлгөөнд суурилсан олон талт арга хэмжээнүүд зохион байгуулах
- 2.4.23. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ болон төлөвлөгөөнд тодотгол хийх
- 3.3. Хот тохижилт ногоон байгууламжийн талаар

г/Эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан үйл ажиллагаанд тусгагдсан:

Нийслэлийн эдийн засаг нийгмийн 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл 4.2.12 дах заалтыг үндэслэн 2019 оны 12 сарын 18-ны өдрөөс эхлэн Чингэлтэй салбар үйл ажиллагаагаа явуулсан. Тус салбар нь Чингэлтэй дүүргийн 14-р хороо Хайлаастын 14-р гудамжинд төмөр карказан цутгамал хийцтэй 3 давхар барилгад төвлөрсөн усан болон цахилгаан хангамжид холбогдон үйл ажиллагаагаа явуулж байна.

Чингэлтэй салбарын үйлчлэх хүрээ нь Чингэлтэй дүүргийн 7-19 дүгээр хороод буюу 13 хороо, Сүхбаатар дүүргийн 12-20 дүгээр хороод буюу 8 хороог хамардаг бөгөөд эмнэлгийн яаралтай тусламжийг 24 цагийн турш тасралтгүй үзүүлдэг мэргэшсэн баг хамт олон ажиллаж байна. Салбарын хэмжээнд албан тоогоор 160.000 гаруй мянган хүн амд үйлчилдэг бөгөөд хамгийн алслагдсан цэг нь салбарын байршлаас 20 км-т оршдог





## Статистик үзүүлэлт

Д/д	Үзүүлэлт	Эхний Хагас жил		Сүүлийн хагас жил		Жилийн эцэс	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
<b>Салбарыннийтдуудлага</b>		<b>17037</b>	<b>100%</b>	<b>17228</b>	<b>100%</b>	<b>34265</b>	<b>100%</b>
<b><i>Насандхүрэгчид</i></b>		<b>15832</b>	<b>73,1%</b>	<b>15689</b>	<b>91%</b>	<b>31521</b>	<b>85,2%</b>
Үүнээс	Үрдүнгүй	49	0,03%	15	0,01%	64	0,02%
	Төрөх	769	4,65%	659	4,2%	1428	4,4%
	Осолгэмтэл	3538	22,4%	2580	16,4%	6118	19,4%
	Өвчлөл	11476	70,65%	12435	79,3%	23914	74,9%
Гэрийнтөрөлт		3	0,01%	5	0,03%	8	0,02%
Давтандуудлага		17	0,08%	25	0,2%	42	0,14%
Яаралтайдуудлага		13259	84,4%	13342	85%	26601	84,7%
20 мин-ыночилт		11433	86,6%	11421	85,6%	22854	86,1%
<b><i>Хүүхдийннийтдуудлага</i></b>		<b>1205</b>	<b>6,9%</b>	<b>1539</b>	<b>9%</b>	<b>2744</b>	<b>7,9%</b>
Үүнээс	Явжүзсэндүүдлага	1205	100%	1539	100%	2744	100%
	Амбулаторийнүзлэг	0	0%	0	0%	0	0%
	Утсаарзөвөлгөөөгсөн	15950	100%	12380	100%	28330	100%

**Дүгнэлт:** 2020 оны жилийн эцэсийн статистик үзүүлэлтийн 20 минутын очилт 86,1 хувь үзүүлэлттэй байна.

Өдөр бүр дуудлага хүлээн авах үйл ажиллагааг хянаж, ширээний хүлээгдэл, айлд очсон хугацаанд хяналт тавьж ээлжийн ахлагч болон дуудлагын эмч нартай биечлэн уулзаж шалтгааныг олж арилгах тал дээр ажиллаж ирлээ. Үүний үр дүнд ширээний хүлээгдэл болон айлд очих хугацаанд эерэг өөрчлөлт гарсан. Өглөө бүр урьд өдрийн мэдээгээ хянаж дүн бүртгэлд мэдээлж ирлээ. Ээлжийн зохицуулагч нартаа болон хүүхдийн дуудлагын оператор эмч нартай мэдээ тайлан гаргалтад харилцан ярилцаж алдаа зөрчлийг тухай бүр нь засаж арилгуулж ирлээ. Өглөө бүр ээлжийн зохицуулагч болон хүүхдийн дуудлагын оператор эмч нарт дуудлагын хуудас бичилтийг шалгаж гүйцэтгүүлэх талаар үүрэг даалгавар өгч ажилласнаар дуудлагын хуудас бичилт 100хувь буюу сайн үр дүнд хүрлээ. Эмнэлэг хүртэлх болон газар дээрх тусламж үйлчилгээнд хяналт тавьж алдаа зөрчлийг цаг тухайд нь арилгуулж ажилласан. Албадан саатуулах төв дээр дуудлагын тоо нийт дуудлагын 10 орчим хувийн эзэлж байсан тул нийслэлийн

цагдаагийн газарт судалгаатай бичиг хүргүүлснээр шаардлагагүй дуудлагын тоо буурч өдөрт нийт дуудлагын 1 орчим хувийг эзлэх болсон.

Нийт 15 эмчийн насанд хүрэгчдийн картанд тогтмол шалгалт хийхэд Карт бичилт 100 хувь, оношийн зөрөө 10 хувь гарсан ба зөрчлийг цаг тухайд нь арилгуулсан.

Хүүхдийн картанд их эмч Л.Энхтуяа, Н.Хулан, З.Дамдинсүрэн нар ижил мэргэжилтний үзлэгийг нийт 258 хуудсанд хийсэн.

#### Дүгнэлт:

1. Дуудлагын эмч нар нь хүнд хүүхдийг болон хэвтэх шаардлагатай хүүхдүүдийг өөрсдийн унаагаар явуулахгүйгээр эмнэлэгт хүргэж, хүлээлгэж өгөх
2. ХӨЦМ-ийн дагуу дуудлагын хуудсыг бөглөх
3. Өвчтөнийг бүрэн, зөв үнэлж, оношоо бүрэн гүйцэт бичих
4. Эмчилгээ, зөвлөгөөг оноштой тохируулж тодорхой бичих
5. Картыг гүйцэт бөглөх зөвлөмжийг өгч алдаа зөрчилийг арилгуулсан.

2020 оны 03 сарын 04 ны өдрийн дотоод хяналтаар илэрсэн зөрчил:

- “Элемент” ХХК-ийн ТХХ тээвэрлэлтийн бүртгэл хөтлөлт 2020 он эхэлснээс хойш зөвхөн 1 удаа хийгдсэн.Тухайн өдрийн “Элемент” ХХК-ийн тээвэрлэлт хийсэн тамга тэмдэг дарагдсан. Энэхүү тэмдэглэл хөтлөгдсөн тээвэрлэлт нь 2020 оны 01 сарын 09-ний өдөр хийгдсэн. Тусгай хог хаягдлын тээвэрлэлт 7 хоногт 1 удаа Лхагва гариг бүр хийгддэг.

- Аюулгүй хайрцаг дээрх тэмдэглэгээг огт хийдэггүй. Нэр болон нээсэн огноо огт бичигдээгүй байсан зөрчлийг арилгуулж “Элемент” ХХК-аар тэмдэглэгээг тогтмол хийлгүүлж, аюулгүй хайрцгийн нэр огноог тэмдэглүүлж хэвшсэн



Эмийн сангийн үйл ажиллагаанд хяналт 2 удаа хийсэн.

Өгсөн үүрэг даалгавар:

- Хугацаат эм, эмнэлгийн хэрэгслийг сар бүрийн 20 гэхэд авсан байх.
- Хугацаат эмийн самбарыг үнэн зөв хөтлөх.
- Ажлын цаг ашиглалтыг сайжруулах, ажлын цагаар ажлын байран дээр байх.
- Эмч бүрийн цүнхний дугаар, нэрийг бичиж тавиур дээр ил байршуулах.
- Ариутгалын материалын хугацаанд хяналт тавих.
- Салбарт хийсэн дотоод хяналтаа дэвтэр гарган хөтөлж эмч тус бүрд танилцуулж гарын үсэг зуруулж баталгаажуулах




Удирдах байгууллагууд болон байгууллагын удирдлагаас ирсэн тушаал, журам зөвлөмжүүдийг цаг тухайд нь эмч ажилчиддаа танилцуулж гарын үсэг зуруулж баталгаажуулсан.

1. Өглөө, өдөр оройн хоолны дараа эмч ажилчидыг амыг содын уусмалаар уусмалаар зайлуулж хэвшсэн.



2. Эмч нарын карт бичилтийн өрөөнд халдвар хамгаалалын хувцас өмсөх тайлах самбар хийж байршуулсан.
3. 2020 оны 5 сарын 7 ны өдөр зохион байгуулагдсан цар тахалын үеийн арга хэмжээ сэдэвт дадлага сургуулилалтын үед бэлэн байдалаа ханган ажиллаж их эмч Э.Наранбадрах жолооч Ганхөлөг нар сургуулилтанд оролцсон.
4. ЭМС-ын А/537 тушаалын 1-р хавсралтын дагуу Эмч ажилчидын гар угаах, халдваргүйлэх мэдлэг дадлыг үнэлэх хуудсаар үнэлсэн.



5. Халдвар хамгааллын хувцасыг бүх эмч нар зөв дарааллын дагуу дадлагыг давхардсан тоогоор 78 удаа хийсэн ба ХӨСҮТ-ын захирлын А/34 тоот тушаалын хоёрдугаар хавсралтын хяналтын хуудсаар шалгаж бүртгэл хөтлөн баталгаажуулсан.



6. ”Томуу, томуу тест өвчнөөс урьдчилан сэргийлэх” сэдвийн хүрээнд зохицуулагч эмч Н.Ууганцэцэг, их эмч Б.Болдбаатар, Н.Золжаргал, Г.Чанцалдулам, Н.Хулан, Э.Наранбадрах болон оператор эмч: Л.Энхтуяа, сувилагч Д.Алдармаа нар нь 2020.11.10-нд Чингэлтэй дүүргийн 9 хорооны 43-р цэцэрлэгийн 2-5 нас хүртэлх нийт 164 хүүхэд урьдчилсан сэргийлэх үзлэг хийж зөвлөгөө өгөх болон витаминжуулалт

хийж гүйцэтгэв. Үүнд: 2 насны 16 хүүхэд, 3 насны 53 хүүхэд, 4 насны 47 хүүхэд, 5 насны 48 хүүхдүүд үзлэгт хамрагдсан.



7. Эмч, мэргэжилтэнүүдийн нийтлэг гаргадаг харилцаа хандлагын алдааны тохиолдолд суурилсан 4 асуулттай сэтгэл ханамжийн видео судалгааг хийж байгууллагад танилцуулсан.



Судалгааны асуумж:

1. Та 103-т дуудлага өгч байсан уу?
2. Ямар шалтгаанаар дуудлага өгч байсан бэ?
3. 103-ын үйлчилгээнд сэтгэл ханамж хэр байдаг вэ?
4. Сэтгэл ханамжийг сайжруулах талаар таны бодол?

Судалгааны дүгнэлт:

Иргэдээс түүврийн аргаар 100 хүн сонгон авч видео судалгааг хийхэд:

103 утсанд огт хандаж байгаагүй 29%

Үлдсэн 71% дуудлага өгч байсан

103 тоот утсанд хандаж байсан иргэдийн 58% нь үйлчилгээнд сэтгэл хангалуун байсан бол үлдсэн 42% нь сэтгэл ханамж тааруу байсан.

Сэтгэл ханамжгүй иргэдийн

1. 60% нь хүлээгдэл
2. 20% нь харилцаа хандлага
3. 10% нь мэдлэг чадвар
4. 10% нь машин тоног төхөөрөмж хангалтгүй гэсэн үнэлгээг өгч байсан

Байгууллагын гадна дотно орчны аюулгүй байдалд эрсдэлийн үнэлгээ хийж дараах арга хэмжээг авсан.

1. Давхар бүрт галын хор байрлуулж галын буланг стандартын дагуу байршуулсан.



2. Мөн гадна талбайн гэрэл болон камерын бүрэн бүтэн байдлыг шалгаж дутагдлыг зассан. 4 камер ажиллаж байсан ба нэмэлтээр карт бичилтийн өрөө болон зохицуулагчийн өрөөнд 2 камер байрлуулсан.
3. Цахилгаан түгээх төв болон ус сувгийн удирдах газруудтай шинээр гэрээ байгуулсан.
4. Салбарын мэдээллийн самбар хийж байршуулсан
5. Сургалтын өрөөнд эмчийн тангараг сувилагчийн тангарагтай самбар байршуулсан
6. Салбарын сургалтын өрөөнд вебкамер, спикер нотебүүк проектор байрлуулж эмч ажилчидын онлайн сургалт, онлайн хуралд хамрагдах нөхцөл бололцоог хангасан



7. Салбарын гадна талд цэцэгийн мандал хийсэн.



8. Салбарын 18 цонхонд ялаа шумуулын тор хийсэн.



**Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр хийсэн бүтээлч шинэлэг ажлууд:**



Ээлжийн эмийн санч нар эмч нарын эмийн орлого зарлагын дэвтэр болон бусад анхан шатны маягт хөтлөх дэвтрүүдийг нээсэн.



Эмч нарын карт бичилтийн өрөөнд глазго комын үнэлгээний самбар хийж байршуулсан.  
Дуудлага авах дэвтэрийг санаачлан хэвлүүлж бүх салбаруудад тараасан



Нийслэлийн засаг даргын А/168 тоот захирамжийн дагуу хийсэн ажил:

1. Хог хаягдлын тухай хуулийн 10.2.10-д заасны дагуу Чингэлтэй салбарын орчны 50м хүртэлх газрын цас, мөс, хог, хаягдлыг 15 хоног тутамд цэвэрлэж хогийн цэгт төвлөрүүлэн ТҮК-д ачуулсан



2. Байгууллагын гадна талбайд стандартын дагуу хогийн савыг байршуулсан.
3. Байгууллагын дотор орчныг 2 цаг тутамд чийгтэй цэвэрлэгээ хийж, байгууллагын грашыг хуваарийн дагуу цэвэрлэсэн.



4. Эрүүл ахуйн тухай хуулийн 7.5-д заасны дагуу ариун цэврийн өрөөг иргэнд чөлөөтэй, үнэ төлбөргүйгээр ашиглуулах заалтын дагуу салбарын ариун цэврийн өрөөг 2 цаг тутамд цэвэрлэж иргэдэд нээлттэй ажиллуулж байна.  
д/Нийгэм эдийн засаг, нийгмийн хөгжүүлэх үндсэн чиглэлийн дагуу сарын төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.

4.2.12. Дүүргийн түргэн тусламжийн төвүүдийн үйл ажиллагааг бэхжүүлэн, автомашины парк шинэчлэлт хийж, дуудлагын 20 минутын дотор хочилтыг нэмэгдүүлнэ.

- Дуудлагын тоо, өвчлөлтэй уялдан дуудлагын эмч, автомашины тоог нэмэгдүүлэх, салбар хооронд уялдаатай ажилласнаар яаралтай дуудлагын 20 минутын очилт 3.8 хувиар нэмэгдсэн.

Автомашины нөхөн хангалтын талаар холбогдох байгууллагад санал хүргүүлэххүрээнд автомашины нөхөн хангалт, түргэн тусламжийн зориулалтын автомашины судалгааг гарган зохих шатны байгууллагад хүргүүлсэн.

### COVID-19-ийн үед ажиллах сөрөг даралтат автомашин.



Нийслэлийн Түргэн тусламжийн төвд “COVID-19”-ийн үед ашиглах "Сөрөг даралтат яаралтай тусламж"-ийн нэн шаардлагатай тоноглогдсон эмнэлгийн автомашин хүлээлгэн өглөө.

БНХАУ, ӨМӨЗО-ны засгийн ордон, Монголын Улаан загалмайн нийгэмлэг нь Нийслэлийн Түргэн тусламжийн төвд коронавирусийн цар тахлын үед

ашиглах нэн шаардлагатай эмнэлгийн зориулалттай “Сөрөг даралтат түргэн тусламжийн автомашин”-ыг гардуулан өглөө.

Энэхүү автомашин нь коронавирусийн цар тахлын халдварын дэгдэлтийн үед ашиглахад зориулагдсан бөгөөд энгийн түргэн тусламжийн автомашинтай харьцуулахад өөр, COVID-19-ийн халдвартай өвчтөнийг зөөж тээвэрлэх болон машины доторх орчныг бүрэн халдваргүйжүүлэх зориулалттай, амьсгалын аппарат, бусад тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон сөрөг даралтат яаралтай тусламжийн автомашин юм.




Тус автомашин гардуулах арга хэмжээнд Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд, МУЗН-ийн ерөнхийлөгч Н.Энхболд, Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл, БНХАУ-аас Монгол улсад суух бүрэн эрхт элчин сайд Шин Хаймин, Нийслэлийн Засаг даргын Хүний хөгжил, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч Ш.Анхмаа, Монголын Улаан загалмайн нийгэмлэгийн ерөнхий нарийн бичгийн дарга

Н.Болормаа, НТТТ-ийн захирал Ц.Пүрэвдаш болон бусад албаны хүмүүс оролцлоо.

**Парк ашиглалтын коэффициент,  
Техникийн бэлэн байдлын коэффициент:**

Эмнэлэг үйлчилгээнд 124 жолооч 107 автомашинтайгаар эмнэлэг үйлчилгээний байнгын бэлэн байдлыг ханган ажиллаж байна. Өдөрт 40 автомашин эмнэлэг үйлчилгээнд ажиллаж, Парк ашиглалтын коэффициент 59 хувь, Техникийн бэлэн байдлын коэффициент 98 хувьтай байна.



Парк ашиглалтын коэффициент өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 хувиар өсөж, техникийн бэлэн байдлын коэффициент 7 хувиар өссөн нь автомашины засвар үйлчилгээ хийлгэх, сул зогсолтын цагийг түргэн шуурхай чанартай гүйцэтгэж, эмнэлэг үйлчилгээнд үйлчлэх автомашины байнгын бэлэн байдлыг ханган ажилласантай холбоотой.



Тус төвд БНХАУ, ӨМӨЗО-ны засгийн ордон, Монголын Улаан загалмайн нийгэмлэг коронавирусийн цар тахалын үед ашиглах нэн шаардлагатай эмнэлгийн

зориулалттай “Сөрөг даралтат түргэн тусламжийн автомашин”-аар нөхөн хангалт хийгдлээ.

Нанжинг маркийн автомашиныг хүлээн авч, техникийн тодорхойлолтонд орсон үндсэн үзүүлэлтүүдээр нь дэлгэрэнгүй бүртгэж, хувийн хэргийг шинээр нээж, автомашин эзэмшигчид хүлээлгэн өгсөн. Автомашины гэрчилгээ болон эзэмшигч жолооч нарын жолооны үнэмлэх, мэргэшсэн үнэмлэх зэргээр хувийн хэргийн баяжуулалт хийсэн. Мөн нийслэлийнхөрөнгө оруулалтаар Ниссан Урбан маркийн 23 автомашины нөхөн хангалт хийгдсэн.

Дээрхи автомашинд дөрвөн төрлийн 48.500.000 төгрөгийн эмнэлэгийн тоног төхөөрөмж болон зургаан нэр төрлийн 4.380.000 төгрөгийн бага үнэтэй түргэн элэгдэх эмнэлгийн хэрэгслээр тоноглогдсон.



Багануур, Налайх дүүргүүдийн түргэн тусламжийн төвийн жолооч нарт 5 сарын 19-22-ны өдрүүдэд нийт 16 цагийн онол, арга зүйн зааварчилгаа өгсөн.



Тус төвийн автобааз 2020 оны Автотээврийн хэрэгслийн улсын үзлэг тооллогод эмнэлэг үйлчилгээнд үйлчилдэг 80 орчим автомашиныг бүрэн хамруулж, хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг хүчин зүйлсийн зөвшөөрөгдөх хэмжээний түвшин, тээвэрлэлтийн болон техникийн ашиглалтын шаардлага хангасан байдалд техникийн хяналтын үзлэг хийлгэж, хангалттай үнэлгээ авлаа.





Тус төвийн эмнэлэг үйлчилгээнд үйлчлэх 30 автомашины дуут болон гэрлэн дохионы тусгай зөвшөөрлийн хугацаа дууссаныг нэг жилээр сунгуулан, хэвийн ажиллаж байна. 2020 онд шинээр солих дугуй, аккумулятор, техник үйлчилгээний хуваариудын гүйлт нормыг нь харгалзан гаргаж батлуулан ажилласнаар жолооч нар автомашины техник үйлчилгээг цаг алдалгүй хийж хэвшихэд нөлөөлсөн. Автомашины шатах тослох материал, сэлбэг хэрэгсэл нийлүүлэх нээлттэй тендер шалгаруулалтыг зохион байгуулахтай холбогдуулан тендер шалгаруулалтын үнэлгээний хороо сэлбэг хэрэгсэл худалдан авах төсөвт өртөгт багтаан шаардлагатай сэлбэгийн жагсаалт гарган, техникийн тодорхойлолт бэлтгэн ажилласан.

Нийслэлийн Засаг даргын 2020 оны 5 сарын 14-ний А/654 тоот тээврийн хэрэгслийг балансаас балансад шилжүүлэх захирамжийн дагуу Зоонозын өвчин судлалын үндэсний төвд бүртгэлтэй Камаз 4326-15 маркийн 57-95 УБЛ улсын дугаартай автомашиныг 9 хүний комисс гаргаж хүлээлцэн ажилласан.




Автомашинд суурилагдсан эмнэлгийн тоног төхөөрөмжийн сургалтыг тоног төхөөрөмжийн инженер М.Мөнхбаатар, техникч С.Нарантуяа нар амьсгалын аппарат, хяналтын монитор, сорох аппарат, дефибриллятор зэрэг аппаратуудаар 81 жолоочид 6 цагийн сургалтанд хамруулсан.



Автотээврийн үндэсний төвөөс зохион байгуулсан өвөлжилтийн бэлэн байдлын өдөрлөгт тус төвийн эмч, жолооч, техникийн ажилтнууд оролцож, хот хоорондын тээрийн жолооч нарт амилуулах сургалт, автомашины эмнэлгийн тоног төхөөрөмжийн сургалтыг зохион байгуулсан.



Нийслэлийн онцгой байдлын аврах 105-р ангид 2020 оны 09 сарын 22-ны өдөр Нийслэлийн эрүүл мэндийн газрын мэргэжилтэн Ш.Тэгшжаргал, дэд захирал С.Ариунболд, шалгах механик В.Түвшиндэлгэр нарын бүрэлдэхүүнтэй сайн туршлага нэвтрүүлэн ажилласан.



Цагдаагийн ерөнхий газрын харьяа замын цагдаагийн албанаас замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хэрхэн хангах хөдөлгөөнд оролцох, тусгай дуут дохио ашиглах журам, зөрчлийн тухай хуулийн талаар нийт 123 жолоочид 6 цагийн сургалтанд хамруулсан.



Ковид-19 вируст халдварын нөхцөл байдлын үед гадна орчинд мананцар үүсгэж халдваргүйтгэл хийх Fogger маркийн төхөөрөмжийг 1.300.000 төгрөгөөр авч, халдваргүйтгэлийг салбар бүрээр долоо хоногт 1 удаа хийн ажиллаж байна.



г/ 2020 онд эрүүл мэндийн чанарын тусламж үйлчилгээг сайжруулах 7 чиглэлээр 22 ажил төлөвлөж, 95% -тай биелэгдэж байна.

#### 1. Чанарын аян, өдөрлөг-9

- “Чанарын өдөрлөг”-ийг 1-р улиралд Монгол улсын шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтран гаргасан 2019 оны А/565, А/565 тоот тушаалыг Төв салбар, Хан-Уул, Сонгинохайрхан, Баянзүрх салбар, автобаазын чанарын багууд эмч нарт танилцуулсан. Ингэснээр шинэ тушаалын талаар ЭМТҮЧАБ-ын албаны чиг үүрэг, зорилго, ойлголт, мэдлэг, идэвх сайжирсан. Мөн 2019 онд хийсэн чанарын албаны хисэн ажлыг тайлагнаж, 2020 оны ЭМТҮЧАБ-ын албаны бүтэц зохион байгуулалт, төлөвлөгөөний чиглэлийг гаргаж танилцуулсан.
- “Менингококкт халдвараас урьдчилан сэргийлье, ТТТӨ-өөс урьдчилан сэргийлье” аянаар 4 дүүргийн 5 цэцэрлэг, 2 сургууль, асрах төвийн хүүхэд, багш асран хамгаалагч нарт 8 удаа сургалт мэдээлэл зааж, тараах материал 550 ширхэг өгч, витаминжуулалт хийсэн.

- “Хүүхдийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлье, томуу, томуу төст өвчнөөс хамтдаа сэргийлье” аянаар 45 эмчийн 150 дуудлагын хуудас үнэлгээ хийсэн. Ингэснээр Хүүхдийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, газар дээрх болон эмнэлэг хүртэлх хүүхдийн тусламжүйлчилгээг сайжруулах, дуудлага хүлээн авах болон дуудлагын хуудас бичилт сайжирсан.
- “Сэтгэц нөлөөт эмийн зохистой хэрэглээ” аянаар 2 удаагийн сургалт, жор хөтлөлтөөр 35 эмч хамрагдан, сэтгэц нөлөөт мансууруулах эмийн хэрэглээний заалт, хөтлөлт сайжирсан. Тавигдах хяналт сайжирсан.
- Эрүүл мэндийн сайдын 2019 оны 406 тоот тушаалаар батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм”, ёс зүй хэм хэмжээг сайжруулах “Аз жаргалтай ажлын байр” 3 сарын аян 7-10-р сард зохиогдсон. НТТТөвийн Ёс зүйн хорооны гишүүдийг шинэчилэн зохион байгуулах
- “Харилцааны ур чадварыг сайжруулья” асуудал дэвшүүлсэн сургалт
- “Ёс зүйгээртэргүүлэгчхамтолон”, Ёс зүйн хорооны цомыг салбаруудад 14 хоног аялуулах
- “Аз жаргалтай ажлын байр” дуудлагын эмч нарын ажлын байрны таатай эрүүл орчинг бүрдүүлье олон талт ажлыг хийсэн.
- “Халдвар хамгааллын хувцас өмсөх тайлах дарааллын зурган самбарыг 5 салбарт байршуулсан. “Ковид -19 үеийн бэлэн байдлыг хангаж хамгаалах хувцас хэрэгслийг зөв өмсөх, зөв тайлж сурцгаая” аян, челлинж зохион байгуулж, 126 эмч нар өмсөж, дадал ажлыг зохион байгуулсан.
- “Дархлаажуулалт”өдөрлөгийг улирал бүр ҮЭХороо болон салбарууд хамтран зохион байгуулж, нийт 980 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдаж, амин дэм 5 төрлийг уухаар нийт ажилтанд тараасан.Цусан дахь сахар, биеийн жинг үзэж тодорхойлсон.



Амны хаалт, ревит, салимон, нүүрний хаалт зэргийг тарааснаар, тэдний, ажиллах урам сайжирсан.

- “Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын дэлхийн өдөр” 2 өдрийн аянаар 192 эмч, 21 сувилагч 118 жолооч хамрагдан идэвхтэй оролцон, машины улбар, шар өнгийн гэрэлээ асаан, дүрмийг баримтлан ажиллаж, ёс зүйн хэм хэмжээ, халдвар хамгааллын дэглэмийг сахин, үйлчлүүлэгчид сэтгэлтэй хандан ажилласан.Үйлчлүүлэгч болон эрүүл мэндийн ажилтны аюулгүй байдлын мэдлэг хандлага сайжирч, Засгийн газрын 11-11 төвөөс 9-р сарын 17-нд 7 талархал ирсэн.


## 2. Эмнэл зүйн сургалт-8

- Эмнэл зүйн 2 тохиолдолд суурилсан “Этанолын цочмог хордлого, түүнд үзүүлэх яаралтай тусламж, авах арга хэмжээ” сэдвээр 1 дүгээр сарын 9-10-ны өдрүүдэд сүүлийн 2 жилд ажилд шинээр орсон 73 их эмч хамрагдан суусан.
- “Этанолын цочмог хордлого”, “Архины цочмог хордлого, нойр булчирхайн цочмог үрэвсэл” сэдвээр цахим 3 цагийн сургалтыг 5-р сарын 20-22-ны өдрүүдэд орж, нийт 117 эмч хамрагдан суусан. Үр дүнд нь шинэ эмч нарын мэдлэг ур чадвар, ялган оношилгооны чадвар сайжирсан.



- ЭХЭМҮТ-ээс зохион байгуулсан ХӨЦМ-19-ийн сургагч багш бэлдэх 40 цагийн эмнэл зүйн сургалтад хүүхдийн эмч Ч.Анхтуяаг сургаж бэлдсэн. ХӨЦМ-ийн сургагч багшийн тоо 1-ээр нэмэгдсэн.
  - Ажилд шинээр орсон 45 эмчид ХӨЦМ-19 эмнэл зүйн сургалтыг онлайнаар зохион байгуулсан. Сургалтад хэрэглэх сурах бичгийг Монос эм ханган нийлүүлэх ХХК-аас гарган, ХӨЦМ-ийн хүснэгтэн том товхимлыг 5 салбарт эмч нарын өрөөнд байршуулан ажил үйлчилгээндээ хэрэглэж байна. Хүүхдийн тусламж үйлчилгээ сайжирсан.
  - ЭХЭМҮТ-ийн зохион байгуулсан “Шинэ коронавируст халдварын үгдрэн даамжрах зүй тогтол, оношилгоо эмчилгээний зарчим, зонхилон тохиолдох хүндрэлүүд, тэдгээрийн менежмент”-ийн талаар онол, дадлага хосолсон /хүүхдийн/ 56 цагийн сургалтад 1 хүүхдийн эмч, 1 тусгай мэргэжилтэн нарыг сургаж бэлдсэн. Ингэснээр шинэ болон сэргэж буй халдварт өвчний үед ажиллах эмч, мэргэжилтний нөөц хангагдаж, тусламж үйлчилгээний чанар сайжирсан.
  - Гэрийн төрөлтийн эмнэл зүйн бодит тохиолдолд суурилсан хэлэлцүүлэг сургалт, зөвлөмжийг 2 удаа, нийт 16 цагийн сургалтад 64 их эмч хамрагдсан. Ингэснээр шинэ эмч нарын төрөх, эмэгтэйчүүдийн талаас мэдлэг ур чадвар, ялган оношилгооны чадвар сайжирсан.
  - Эмнэл зүйн конференц-3 удаа Баянгол, Баянзүрх дүүргүүдийн эхийн эндэгдэл, хүүхдийн эндэгдлийн хуралд материал бэлдэж 4 их эмч оролцож, мэдлэг мэргэжлээ дээшлүүлсэн.
  - Томуу томуу төст өвчний эмнэл зүйн удирдамжаар салбаруудад 6 удаа сургалт зохион байгуулагдаж, нийт 95 эмч хамрагдсан.
3. Хэлэлцүүлэг-6, Клиник разборын тоо-15 удаа, сургалт зэрэг 5 чиглэлээр, 887 эмч, мэргэжилтэн давхардсан тоо/ хамрагдсан.
- ЭМТҮЧАБАлбанаас 2020 оны 01 дүгээр сарын 17-нд байгууллагын чанарын албан болон албан бус гишүүдэд Монгол улсын шадар сайд, эрүүл мэндийн сайдын хамтарсан 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/565, А/566 тоот тушаал “Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын алба”-ны чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт сэдвээр болон 2019 онд чанарын албанаас хийсэн ажлын тайлан, 2020 онд хийх ажлын төлөвлөгөөг танилцуулан, ярилцаж хэлэлцүүлэг зохион байгуулсан.
  - Нийслэлийн эрүүл мэндийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 16-ны 2/52 тоот 2019 оны эмгэг судлалын эмнэл зүйн тайлангийн 7 удаагийн хуралд чанарын менежер, салбарын эрхлэгч нар 7 удаа сууж хамрагдсан.

- НЭМГ-аас чанарын болон мэргэжлийн чиглэлээр зохион байгуулж байгаа “Пүрэв” гаригийн цахим сургалтад давхардсан тоогоор 789 эмч, мэргэжилтэн, чанарын баг, чанарын албан бус гишүүд хамрагдан оролцсон. Зарим сэдвүүд:
- Монгол улсын шадар сайд, эрүүл мэндийн сайдын хамтарсан 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/565, А/566 тоот тушаал “Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын алба”-ны чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, төлөвлөгөө, тайлангийн загварын журам.
- ЭМТҮ-тэй холбоотой үүссэн тохиолдлыг бүртгэх, хариу арга хэмжээ авах, мэдээлэх, журам.
- Эмнэлгийн бус нөхцөлд эндсэн хүүхдэд үзлэг хийх нь, ураг нярай, хүүхдийн эндэгдэл, түүний оношилгоо. Цогцост гарах эрт үеийн өөрчлөлт болон цогцсын эрт үеийн өөрчлөлтөөр үхлийн шалтгааны баримжаалан тогтоох.
- ЭМТҮ-ний эрсдэлийг бүртгэх, хариу арга хэмжээ авах заавар.
- Сэтгэц, мансууруулах эм ба, жорын хяналт, эм зүйн чанар аюулгүй байдал. Сэтгэц нөлөөт, мансууруулах эмийн хэрэглээний талаар, шалгуур хуудас хэрэглэх заавар, зөвлөмж.
- Тархины судасны тромбоз. /Жирэмсний тохиолдолд суурилсан/
- Эпилекси, приэкламси, ялган оношилгоо, үзүүлэх тусламж.



- “Хүүхдийн эрэмбэлэн ангилал, яаралтай тусламж” Төв салбар, Хан-Уул салбар, Сонгинохайрхан салбарын эмч Г.Буянтогтох, Р.Адхүү, Н.Амарбаяр нар ээлжийн 49 эмч, сувилагч нарт заасан.
- Үйлчлүүлэгч, ар гэртэй харьцах харьцаа, харилцан ярьж өөрийн үзүүлж байгаа тусламжийн талаар мэдээлэл өгч сурах чадвараар 2-р ээлжийн эмч Б.Насанхишиг, А.Сувд нар сургалт зохион байгуулсан.
- Автомашиныг хоёр хувингийн аргаар ариутгаж, халдваргүйжүүлэх үзүүлэх 2 хувингийн аргаар 465 удаа автомашины ариутгал халдваргүйтгэлийг хийж гүйцэтгэсэн байна.
- Авто баазын тусламж үйлчилгээний чанарын баг дотоод хяналтыг 37 удаа автомашинуудад шалгах хуудсаар хийж, гарсан алдааг засуулахаар, хугацаат үүрэг өгөн арилгуулж ажилласан.
- Эмнэлэг үйлчилгээнд үйлчилж буй жолооч нар Хөдөлмөрийн тухай хууль, Автотээврийн тухай хууль, Байгууллагын дотоод журам, Замын хөдөлгөөний дүрэм, Аюулгүй ажиллагааны журам, байгууллагад өдөр тутамд хэрэглэгддэг нийт 11 журмуудыг мөрдлөг болгон ажиллаж, дүрмийн хэрэгжилт 100% байна.



- Эмнэлгийн 83 автомашинд суурилагдсан 4-н төрлийн 157 тоног төхөөрөмж болон 5 салбарт суурилагдсан 25 тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг ханган улиралд 8 удаагийн урьдчилан шалгалт, хяналтыг тогтмолжуулан ажилласан. Ингэснээр газар дээрх тусламж үйлчилгээний бэлэн байдал сайжирсан.
- Зам тээврийн ослыг бууруулах чиглэлээр замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар сургалтыг Замын цагдаагийн газрын дэд хурандаа Н.Ганболд 6 цагийн сургалтад 97 жолооч хамруулан зохион байгуулсан.
- Чанарыг сайжруулах зорилгоор жолооч нарт харилцан туршлага солилцох ажлыг тогтмол зохион “Амилуулах суурь тусламж”, “Автомашинд суурилагдсан эмнэлгийн тоног төхөөрөмжийн ариутгал, халдваргүйтгэл” сэдэвт сургалтыг зохион байгуулж, давтагдсан тоогоор 80 жолооч хамрагдсан. Шинэ коронавирусээр үүсгэгдсэн Ковид-19 халдварын цар тахал гарсантай холбогдуулан ариутгал, цэвэрлэгээг тогтмол сайн хийх талаар өдөр бүр анхааруулга өгч, хүн бүр хамгаалах хувцас өмсөх тайлах дадлагыг ажилд гарахын өмнө хийж ажилласан байна.
- Ковид-19-ийн үед ажиллах бэлтгэгдсэн 10 багийн эмч, жолооч нар тоноглогдсон автомашинаар гадаад улсаас Монгол улсад ирж буй өөрийн орны иргэдийг иж бүрэн халдвар хамгааллын хувцас, хувийн хамгаалах хэрэгсэлтэйгээр шаардлагатай эмнэлэгт хүргэж өгч байна. Тээвэрлэлтийн дараах түргэн тусламжийн автомашиныг тогтмол ариутгал, халдваргүйтгэлийн журмын дагуу ариутгаж халдваргүйжүүлэн ажиллаж байна.
- Дээрх сургалтуудын үр дүнд эмч, сувилагч, дагалдан эмч нарын мэдлэг, ур чадвар дээшлэн, тус төвд дуудлага өгсөн иргэд үйлчлүүлэгчдэд газар дээр үзүүлэх яаралтай тусламж үйлчилгээний чанар, хүртээмж дээшилсэн. Мөн жолооч нарын мэдлэг ур, чадвар, халдвар хамгааллын дэглэм сайжирсан.



7. Ур чадварын үнэлгээ: 2020 онд ажилд шинээр орсон 52 эмч нараас мэргэжлийн ур чадварын үнэлгээг 7 удаа амилуулах суурь тусламж, эх барих, хүүхдийн эрэмбэлэн ангилалт, яаралтай тусламж, дотор, мэдрэл, автомашины тоног төхөөрөмжийн ажиллуулах чадвар, түгээмэл үйлдлийн стандарт, яаралтай эм тарианы болон халдвар хамгааллын чиглэлээр онол болон гардан үйлдэл, эмнэл зүйн тохиолдолд суурилсан үнэлгээг хийсэн. Үнэлгээг 70 онооноос доош өгсөн тохиолдолд тодорхой хугацааны дараа бэлдүүлж, давтан үнэлгээ хийсэн байна. Ингэснээр газар дээрх болон эмнэлэг хүртэлх тусламж үйлчилгээний чанар сайжирсан.

8. ЭМТҮЧАБ-ын албанаас “MGL-Дэлхийн Монголчуудын радио fm 88.3”-д 7 хоног тутам, иргэдэд хүргэсэн мэдээлэл зөвлөмж өгсөн байдал

Д/д	Сар өдөр	Мэдээллийн сэдэв
1	2019 оны 12-16-нд	Хүүхдийн бэлгийн сонголт, сахарын агууламж, насанд хүрэгчдийн баяр ёслолын үеэр архи хоол ундыг хэтрүүлэн хэрэглэхээс сэргийлэх
2	12-23-нд	“Малгай өмсө” өвлийн улиралд малгайгүй явснаас эрүүл мэндийн сөрөг нөлөө, эрсдэлийн талаар мэдээлэл

3	12-30-нд	ТТӨ-өөс сэргийлэх талаар мэдээ мэдээлэл, зөв зохистой хооллох, малгайгаа өмсөх, дулаан хувцаслах, гараа угаах, хоолой амаа зайлах, агаарын сэлгэцэл зөв хийх сэдвээр мэдээлэл
2020 он		
4	1-06-нд	“Халууралт, түүнд үзүүлэх аргууд, авах арга хэмжээ”, “Парацетамол эмийн хор уршиг”, эм хоол биш сэдвээр мэдээлэл
5	01-13-нд	“Шалтгаан тодорхойгүй уушгины хатгалгаа” өвчний талаар сэрэмжлүүлэг, НЭМГ, ЭМЯ-аас гаргасан иргэдэд хүргэх зөвлөмж, мэдээллийг хүргэсэн.
6	01-20-нд	Дархлааг дэмжих аргууд, хэрхэн амьсгалын замын өвчнөөс сэргийлж болох энгийн аргуудыг иргэдэд зөвлөсөн.
7	01-27-нд	<ul style="list-style-type: none"> <li>- ТТӨ-ний хүндрэл, илрэх шинж тэмдэг, хэзээ яаралтай эргэж үзүүлэх</li> <li>- Коронавирусийн халдварын талаар дэлгэрэнгүй шууд мэдээ мэдээлэл иргэдэд хүргэсэн.</li> <li>- Амны хаалтыг хэрэглэх арга дархлааг хэрхэн дэмжих талаар мэдээлэл хүргэсэн.</li> </ul>
8	02-03-нд	Коронавирусийн халдвараас сэргийлэх ДЭМБ-аас гаргасан 10 зөвлөмжийг танилцуулсан.
9	02-10-нд	ТТӨ, шинэ Коронавирусийн халдвараас болон менингококкт халдвараас сэргийлэх аргуудаас мэдээлэл хүргэсэн.
10	02-17-нд	Гадаад дотоод агаарын солилцоо, ариутгал халдваргүйтгэл хийх арга, заавар зөвлөмж
11	02-24-нд	ТТӨ, шинэ Коронавирусийн халдвараас болон менингококкт халдвараас сэргийлэх аргуудаас мэдээлэл хүргэсэн.
12	03-02-нд	ТТӨ, шинэ Коронавирусийн халдвараас болон менингококкт халдвараас сэргийлэх аргуудаас мэдээлэл хүргэсэн.
13	03-09-нд	Коронавирусийн халдвараас сэргийлэх ДЭМБ, ЭМЯ, НЭМГ-аас гаргасан зөвлөмжийг танилцуулсан.
14	03-16-нд	“Хүүхэд эрхэм хэрэглэгч-үндэсний өдөр” осол гэмтэл, унахаас сэргийлэх, гэр орондоо аюулгүй байдлыг хангах, үүн дотроос халдварт өвчнөөс сэргийлэх-Covid-19-ийн зөвлөмжийг өдөр тутамдаа хэрэгжүүлэх талаар
15	03-23-нд	ТТӨ болон Covid-19-ийн үед “хоолой амыг зайлах аргуудаас иргэдэд өгөх зөвлөмж”, “Угаарын хийн хордлогоос сэргийлэх аргууд”
16	03-30-нд	ТТӨ болон Covid-19-ийн үед “Гэртээ гэрийн дэглэм сахиж байгаа иргэдэд өгөх зөвлөмж”
17	04-06-нд	ТТӨ болон Covid-19-ийн үед “Ахмад настай архаг хууч өвчтэй хүнийг анхаарах зүйлүүд, мөн хоол хүнс бэлтгэхэд баримтлах 5 зарчим, зөвлөмж”
18	04-13-нд	<ul style="list-style-type: none"> <li>- Covid-19-ийн үеийн зөвлөмж,</li> <li>- Хачигт халдвараас сэргийлэх анхаарах зөвлөмж</li> </ul>
19	04-20-нд	<ul style="list-style-type: none"> <li>- Стрессийн тухай, стрессийг даван туулах нь, амьсгалын дасгал хийх энгийн 2 аргаас (цар тахал, гамшгийн үеийн)</li> </ul>
20	04-27-нд	<ul style="list-style-type: none"> <li>- Хавдраас сэргийлэх аргууд, эрсдэлт хүчин зүйл, таргалалт, архи тамхины хэрэглээ, биеийн жингийн индекс үзэх, эрүүл хооллолт, идэвхтэй хөдөлгөөн хийх аргууд</li> <li>- Онцын шаардлагагүй бол эмнэлгийн байгууллагад очихгүй байх, 103 дуудахгүй байх</li> </ul>
21	05-04-нд	Амны хаалтыг хэрхэн зөв зүүж, зөв тайлж хэрэглэх, ач холбогдлын талаар мэдээлэл
22	05-11-нд	Ундны усны савны стандарт, хэрэглээ
23	05-18-нд	<ul style="list-style-type: none"> <li>- Хариуцлагатай аав ээж байцгаая, үр хүүхдээ аюулгүй орчинд байлгах, эрүүл хоол хүнс хэрэглэх, тоглоомын талбайн аюулгүй байдал, автомашинд хэрхэн хүүхдийг аюулгүй суулгах, суудлын</li> </ul>

		бүс хэрэглэх зэрэг - Дархлаа гэж юу вэ, дарлаагаа хэрхэн дэмжих, авах арга хэмжээний талаар зөвлөмж
24	05-25-нд	- Тархины цус харвалт, түүнээс сэргийлэх аргууд - Коронагаас сэргийлэх гараа угаах, амны хаалт зүүх, гэртээ байх
25	06-2-нд	- Нурууны өвдөлт, буруу суухын хор нөлөөний талаар зөвлөмж
26	06-08-нд	- Цусны даралт ихдэх өвчнөөс сэргийлэх - Онцын шаардлагагүй бол 103 болон эмнэлэгт хандахгүй байхыг зөвлөсөн.
27	06-15-нд	- Төрсний дараах сэтгэл гутралын ерөнхий шинжүүд, авах арга хэмжээ
28	06-22-нд	Архи согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэхгүй байх, түүний хор нөлөө
29	06-29-нд	- Үер усны аюулаас болгоомжлох - Үерийн үед гарын ариун цэврийг хэрхэн сахих талаар зөвлөмж
30	07-06-нд	-Тарваган тахлаас сэргийлэх, Хачигт халдвараас сэргийлэх
31	08-10-нд	Хөдөлгөөн, алхалтын ач холбогдол
32	08-17-нд	Хэт халуунаас наршилтаас сэргийлэх авах арга хэмжээ
33	08-24-нд	ТТТӨ-өөс сэргийлэх
34	08-31-нд	Амны хаалтаа тогтмол зүүцгээе уриалгатай зөвлөмж
35	09-7-нд	Тулай өвчин, түүнээс сэргийлэх талаар
36	09-14-нд	Зүрх судасны өвчлөлөөс сэргийлэх арга замууд дадал хэвшил өөрчлөх
37	10-05-нд	Залуусын сэтгэл зүйн эрүүл мэнд
38	10-12-нд	Угаар хийн хордлогоос сэргийлье
39	10-19-нд	“Дэлхийн гар угаах өдөр”, ТТТӨ-ний мэдээ мэдээлэл
40	10-26-нд	ТТТӨ-ний талаар томуугийн вакцины ач холбогдол, 1800-0119 тоот дугаарт холбогдох
41	11-02-нд	“Алхалт таны эрүүл мэндэд” тустай, гараа угааж, ТТТӨ-өөс сэргийлэх зөвлөмж
42	11-09-нд	“Хүүхдийн халууралт”-ын үед авах арга эмийн болон механик арга хэмжээ, халуун бууруулах гэрийн зөвлөмж
43	11-17-нд	Ковид-ын үеийн халдвар хамгаалал, сэтгэл зүйн талын зөвлөмж
44	11-23-нд	Амны хаалт зөв зүүх, зөв тайлж хаях арга, зөвлөмж, гэрийн аюулгүй байдлын дүрэм, хөл хорионы үеийн сэтгэл зүйн асуудал”
45	11-30-нд	Гараа хэзээ угаах вэ, гэрт болон орчинд хамгийн их бохирддог зүйлийг хэрхэн угааж, ариутгах, амны хаалтыг хэзээ зүүх, хэзээ хэрхэн хаях, хувийн ариун цэврийг хэрхэн сахих, ТТТӨ, Ковид-с ялгах шинж тэмдгүүд, хөл хорионы үед гэрийн аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар зөвлөмж

- Чанарын дотоод хяналтыг 12 чиглэлээр жилийн төлөвлөгөө гарган хяналт хийсэн. Үүнд: Эмнэл зүйн стандарт удирдамжийн хэрэгжилт, халдвар хамгаалал, эмийн сангийн үйл ажиллагаа, авто машины бэлэн байдал, түгээмэл үйлдлийн стандарт, цахим дуудлагын хуудас бичилт, зохицуулагчийн яаралтай дуудлагын гаргалт, дуудлагын хүлээгдэл зэрэгт тогтмол хяналт хийж ажилласан.

- Захирлын тушаалаар батлагдсан 17 чек листээр 98 удаа хяналт хийсэн.
- Түүврийн аргаар 6 дүүргийн нийт 1554 хүүхдийн дуудлагын хуудсыг оператор эмч нар шалгасан.
- Айлд очсон цаг, буцсан цаг, зарцуулсан цагийн дутуу буруу бичсэн 37.1%
- Зовуурь өвчний түүх бичилт дутуу огт бичигдээгүй 37.0%
- Бодит үзлэг оношны үндэслэл нийцэхгүй 50.8%
- Онош товчлох үг үсгийн алдаатай 33.3%
- Status localus бичигдээгүй 70.3%
- Өвчтөнд авсан арга хэмжээ эмчилгээ дутуу бичигдсэн 33.5%
- Хэзээ яаралтай эргэж үзүүлэхийг зөвлөөгүй 26.4%
- Дуудлагын үр дүн тэмдэглэл хийгдээгүй 23.7%



- Дуудлагад очсон эмч жолоочийн нэр болон ээлжийн ахлагчийн нэр бичигдээгүй 23.7%
- ХӨЦМ-ийн ангилал буруу байх, оношын үндэслэл дутуу, эмчилгээ зөвлөгөө тавьсан онош тохирохгүй зэрэг тохиолдлууд илэрсэн.

Дүгнэхэд: Эмч нарын дуудлагыг хуудсыг шалгаж зовиур, өвчний түүх хангалтгүй авч байгааг анхаарах нь зүйтэй байна. Бодит үзлэг оношны үндэслэл буруугаас авсан арга хэмжээ бичсэн эмчилгээ нийцэхгүй нийтлэг алдаа гаргаж байна.

- Яаралтай болон яаралтай бус дуудлагын тэмдэглэл бичээгүй 16 буюу 17.7%
- Паспортын хэсгийн асуулт бүрийг тэмдэглээгүй дутуу тэмдэглэсэн 41 буюу 45%
- Цаашид хүүхдийн дуудлагын хуудасны бичилтийг бүртгэлийн хэсгийг сайжруулах шаардлагатай байна.
- Томуугийн идэвхжил дэгдэлтийн бэлэн байдлыг хангах, салбаруудад хяналт үнэлгээний хуудсаар үнэлгээ 3 удаа хийсэн. Хангалттай 70-75 оноо авсан. Ковидын үеийн бэлэн байдал хэрхэн хангагдсан байдлаар үнэлгээ хийсэн.
- Дотоод хяналтыг мэргэжлийн хяналтын шалгах 21 хуудсаар шалгаж, гарсан зөрчлүүдэд хугацаат үүрэг өгөн арилгуулж ажилласан. Гарсан зөрчлийн хувьд: дэвтэр хөтлөлт хангалтгүй, ариун цэвэр, өнгө үзэмж сайжруулах, энгэрийн тэмдэг зүүж хэвших, эмнэлгийн тоног төхөөрөмжийн цэнэглэлт, хадгалалт, хамгаалалт зэрэг зөрчлүүд гарсан.
- Дотоод хяналтыг сайжруулах үүднээс Сонгинохайрхан салбарт өөр хооронд нь үнэлгээ хяналтын хуудас ажиллуулсан. Үүнд:
  - Эмч нарын цагийн бүртгэл, тэмдэглэл хөтлөлт хийх
  - Эмч нарын дуудлагын хуудас шалгалт, гараа болгон шалгах
  - Ээлжийн давтан дуудлагын судалгаа, бүртгэл
  - Талархал, гомдол бүртгэл хөтлөх
  - Хүүхдийн дуудлагын хуудас шалгах
  - Татгалзах хуудас
  - Нас баралт
  - Халдвар хамгаалал
  - Хорт эм, тусламж үйлчилгээний тайлан
  - Гэрийн төрөлт
- Дуудлагын автомашины тоног төхөөрөмжийн бэлэн байдал, ариун цэвэр шалгах
- Дуудлагын хуудас бичилт 2020 оны эхний хагаст 85% байсан, 2 дугаар хагаст тогтмол хяналт хийснээр 95% болж сайжирсан.
- Сувилахуйн тусламж үйлчилгээнд 2019 онд чанарын баг нь дотоод хяналтыг доорх чиглэлүүдээр хийсэн. Үүнд:
  - Түгээмэл үйлдлийн стандартын хэрэгжилтийн гүйцэтгэлд 7 удаа, дотоод хяналтыг 60 удаа, Хэлэлцүүлэг 1 удаа хийсэн. Мөн зөвлөмжийг 25 удаа гаргасан байна. Үүний үр дүнд сувилахуйн тусламж үйлчилгээний чанар сайжирсан.
- Эмийн сангийн чанарын багийн хийсэн дотоод хяналт.

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм"-ийн 2019 онд хураан авсан тун шилийг нэг жилийн хугацаатай хадгалж, Элемент хог хаягдлын газарт устгалд оруулж, устгалын актыг үйлдсэн.

- “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм”-ийн хэрэглээнд хяналт тавих журмыг шинэчлэн гаргаж, эмч нарын бага тунгаар хэрэглэсэн хорт эмийн үлдэгдэл устгах картыг шинээр хийж өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.
- Нийт 5 салбарын 127 дуудлагын эмчийн цүнх, эмийн орлого зарлагын дэвтэр, хорт эмийн зарцуулалтад эмийн санч нартай хамтран нийт 10 удаа дотоод хяналт хийсэн. Дотоод хяналтаар дуудлагын эмч нарын 33% нь эмийн зарцуулалтын дэвтрийг буруу хөтөлж, 7.5% нь хорт эм болон дусал тарианы бичилт хийгдээгүй байсныг эмч бүрд анхааруулан 10 хоногийн үүрэг даалгавар өгч хугацаанд нь шалгахад эмч нарын алдаа арилсан. Эмч болон эмийн санч нар харилцан туслалцан ажиллаж алдаа зөрчлийг дор бүр нь илрүүлэн засаж ноцтой алдаа зөрчилгүй ажиллаж байна.

- Авто баазын чанарын багийн хийсэн дотоод хяналтыг сар бүр өөрийн ээлжийн автомашинуудад хяналтын шалгах хуудсаар шалгаж, гарсан зөрчлүүдэд хугацаат үүрэг өгөн арилгуулж ажилласан. Гарсан зөрчлийн хувьд: дэвтэр хөтлөлт хангалтгүй, ариун цэвэр, өнгө үзэмж сайжруулах, энгэрийн тэмдэг зүүж хэвших, эмнэлгийн тоног төхөөрөмжийн цэнэглэлт, хадгалалт, хамгаалалт зэрэг зөрчлүүд гарсан.
- Дотоод хяналтыг сар бүр хийснээр эмнэлэг үйлчилгээнд үйлчилж буй өнгө үзэмж сайжирч, жолооч нарын ажилдаа хандах хандлага, хариуцлага нэмэгдэж байна.
- Халдвар хяналтын албанаас дотоод хяналтыг 4 удаа хийсэн. Хяналтыг эмийн сангийн ариутгал халдваргүйтэлд хяналт тавьснаар илэрсэн зөрчлийг арилгуулсан. Гарын эрүүл ахуй, хог хаягдлын хяналтын нийт 12 удаа хийсэн.
- Дотоод хяналтыг сар бүр хийснээр эмнэлэг үйлчилгээнд үйлчилж буй өнгө үзэмж сайжирч, жолооч нарын ажилдаа хандах хандлага, хариуцлага нэмэгдэж байна.
- Байгууллагын хэмжээнд чанар сайжруулах талаар хэрэгжүүлж буй бүх арга хэмжээг бүртгэн, мэдээллийн сан байгуулж олсон ололт амжилтыг байгууллагынхаа бүх тасаг/нэгжүүдэд дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулж урамшуулан ажиллана.
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд бүтээлч, оновчтой, санал, санаачилга, тэргүүн туршлагыг нэвтрүүлэх, түгээн дэлгэрүүлэх зорилготой Нийслэлийн эрүүл мэндийн газраас зохион байгуулж буй “Сайн туршлага-2020” арга хэмжээний шалгаруулалт оролцох бүтээлийг 2020 оны 10 дугаар сарын 23-нд 5 салбар, автобаазтай хамтран онлайн аргаар хэлэлцэж 6 бүтээлээс 4 бүтээл, сайн туршлагыг арга хэмжээнд оролцуулахаар болсон. Үүнд:
  1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээг хөнгөвчлөх, хүртээмж сайжруулах номинацит ирүүлсэн бүтээлд “Сөрөг даралтат түргэн тусламжийн автомашин”
    - Сөрөг даралтат түргэн тусламжийн машины онцлог нь машин доторх агаарын даралтыг гадаах агаарын даралтаас бага байлгадаг бөгөөд машин доторх агаар чөлөөтэй урсах үед уг агаар гадагш гарахгүй, зөвхөн гаднаас агаар нэвтрэн ордог. Сөрөг даралт нь машин доторх агаарыг нарийн шүүлтүүрээр шүүх ба халдвартай хүнээс гарах нарийн ширхэгт бичил организмыг халдваргүйжүүлсний дараа машинаас үлээн гаргадаг. Ингэснээр хүнд халдвар дамжихаас сэргийлнэ.
    - Халдварт өвчтэй хүнийг тээвэрлэж байгаа үед эмч болон эмнэлгийн ажилтанд халдвар дамжих эрсдэлийг бууруулдаг онцлогтой. Уг машин дотор эмнэлгийн яаралтай анхны тусламжийн багаж тоног төхөөрөмжийг суурилуулж өгсөн.
  2. Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах бүтээл, сайн туршлагад: Ковид-19 дэгдэлтийн үед амны хаалтыг анхдагчаар санаачлан оёсон.
    - “Шинэ корона вирус”-ын дэгдэлтийн үед Эрүүл мэндийн сайдын 2020 оны 01 дүгээр сарын 24 ны өдрийн А/32 тоот тушаал, Нийслэлийн засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 27 ны өдрийн А/108 тоот захирамж, Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 31 ны өдрийн 01 тоот албан даалгаварын дагуу байгууллагын нэг удаагийн амны хаалтны нөөц дуусах нөхцөл байдлыг харгалзан, бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд нийт эмч, сувилагч, жолооч, эмнэлгийн ажилчдын амны хаалтын хэрэгцээг нэмэлтээр хангах, амны хаалтны хомсдолоос урьдчилан сэргийлэх, халдвараас хамгаалах зорилгоор амны хаалт оёж эмнэлгийн ажилчдын аюулгүй байдлыг ханган ажилласан. Дотоод нөөц бололцоогоо ашиглан амны хаалт оёх үйл ажиллагаанд ажлын ачааллыг харгалзан үзээд зөвхөн эмийн сангийн эмийн санч, сувилагч нийт 15 ажилтанг ажлын цагаар нэмэлтээр ажилуулсан. Нөөц дуусах нөхцөл байдлыг харгалзан үзээд болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хэрэгцээг нэмэлтээр хангах, амны хаалтны



хомсдолоос урьдчилан сэргийлэх, халдвараас хамгаалах зорилгоор эмнэлгийн байгууллуудаас анхлан санаачилж, нийт 1450 амны хаалт оёж эмнэлгийн ажилчдын аюулгүй байдлыг ханган ажилласан.

- Дотоод нөөц бололцоогоо ашиглан амны хаалт оёх үйл ажиллагаанд ажлын ачааллыг харгалзан үзээд зөвхөн эмийн сангийн эмийн санч, сувилагч нийт 15 ажилтанг ажлын цагаар нэмэлтээр ажилуулсан.
- Материалын нийт өртөг 426,900₮, нэг маск бүрийн үнэ 295₮ болсон.

Энэ үйл ажиллагааг дэмжиж ирж танилцсан байгууллагууд: “Өргөө” амаржих газар, Наркологийн эмнэлэг, АӨСҮТ, МИАТ, Эмийн холбоо ТББ, “Дөрвөн бэрх” ТББ /Солонгост амьдарч буй Монгол иргэд/

Үйл ажиллагааг сурталчилсан байгууллагууд:

- НТТТ вэб сайт, НЭМГ вэб сайт, Facebook - Эрүүл мэндийн ажилтнуудын нэгдсэн групп, МNC телевиз, “Global Press Journal” олон улсын мэдээллийн сайт
3. Шинээр нэвтрүүлсэн үйлчилгээний технологийн чиглэлээр “Эмч, сувилагч, жолооч нарт мэргэжлийн ур чадварын үнэлгээ хийх удирдамж, шалгуур үзүүлэлт” бүтээл:

- Эмнэлгийн тусламж үйлчилгээг стандарт, удирдамжийн дагуу чанар хүртээмжтэй үзүүлэх, ур чадварыг сайжруулах, багаар ажиллах чадавхийг дээшлүүлэх зорилгоор өртөөчилсөн шалгалтыг жил бүр зохион байгуулж ирсэн.



- Эмнэлгийн тусламж үйлчилгээг стандарт, удирдамжийн дагуу чанар хүртээмжтэй үзүүлэх, ур чадварыг сайжруулах, багаар ажиллах чадавхийг дээшлүүлэх зорилгоор өртөөчилсөн шалгалтыг жил бүр зохион байгуулж ирсэн.

- Эмнэл зүйн өртөө нь эмчилгээ оношлогооны стандарт болон эмнэлэг үйлчилгээний удирдамжийн дагуу оношлох, эмчлэх, эмнэлэг хүртэлх тусламжийг хэрхэн үзүүлж байгаад үнэлгээ өгөх

- Хүүхдийн яаралтай тусламж үйлчилгээний өртөө нь ХӨЦМ-2015, хүүхдийн зонхилон тохиолдох өвчин эмгэг, хүүхдийн эрэмбэлэн ангилалт яаралтай тусламжаар хүүхдийг үнэлж, оношлох, эмчлэх, эмнэлэг хүртэлх тусламжийг үзүүлж байгаад үнэлгээ өгөх

- Осол гэмтэл, амилуулах суурь тусламжийн өртөө нь газар дээрх яаралтай тусламж болон эмнэлэг хүртэлх тусламжийг стандарт, удирдамжийн дагуу үзүүлж байгаа эсэх

- Түгээмэл үйлдлийн өртөө нь гардан үйлдлийг MNS4621:2008 стандартын дагуу хийж гүйцэтгэж байгаа эсэх



- Яаралтай тусламжийн эм тарианы өртөө нь ЭМСайдын 297 дугаар тушаалын дагуу эм тарианы үйлдэл, хэрэглээ, гаж нөлөө, жор бичилтэд үнэлгээ өгөх


- Тоног төхөөрөмжийн өртөө нь дуудлагын автомашинд байрласан эмнэлгийн тоног төхөөрөмжийг хэрэглэх заавар зааварчилгааг эзэмшиж судалсан байх, яаралтай тусламж үзүүлэх үед ашиглаж ажиллуулж байгаа эсэх

- Халдвар хамгааллын өртөө нь ЭМС-ийн 186, 187 тушаалын хавсралт 169-ийн дагуу гар угаах, гарыг халдваргүйжүүлэх шалгуур хуудсын дагуу авсан.



- Ур чадварын үнэлгээнд шинээр ажилд орсон болон 2 хүртэлх жил ажиллаж байгаа эмч, сувилагч, жолооч нарыг 100% хамруулдаг.

Ур чадварын үнэлгээгээр гарсан дүгнэлтийг үндэслэн зөвлөмж боловсруулан гаргаж нийт эмч, сувилагч жолооч нарт танилцуулдаг.

Мэргэжлийн ур чадварын үнэлгээг жил бүр тогтмол явуулснаар дуудлагын их эмч, сувилагч, жолооч нарын газар дээрх болон эмнэлэг хүртэлх тусламж үйлчилгээний стандарт удирдамжийн хэрэгжилт чанар сайжирсан.



Ур чадварын үнэлгээгээр гарсан алдаа тохиолдол дээр суурилсан мэргэжлийн сургалтыг чиглэл, чиглэлээр нь зохион байгуулж ажилласнаар жил ирэх тусам байгууллага болон иргэдээс ирэх гомдлын тоо буурч, талархалын тоо нэмэгдсэн үзүүлэлт гарсан.



4. Шинээр боловсруулсан ном товхимол, удирдамж, гарын авлага чиглэлээр- Сэтгэл ханамжийн судалгаа Теле-Контент бүтээл:
- Тус төвийн эмнэлгийн тусламж үйлчилгээний Сэтгэл ханамжийн судалгааг нас, хүйс, мэргэжил харгалзахгүйгээр 100 иргэнээс санамсаргүй аргаар 3 төрлийн 4 асуултад багтаан шууд ярилцлагын хэлбэрээр авсан. Үүнд:

1. Та 103-т хандаж байсан уу?
2. Ямар шалтгаанаар дуудаж байсан бэ?
3. Үйлчилгээнд сэтгэл ханамж хэр байгаа вэ?
4. Сэтгэл ханамжийг сайжруулах талаар таны бодол юу вэ?

- Газар дээр нь цаг хугацаа, цаас хэмнэсэн, шууд асуумжаар авахад зардал өртөг шаардахгүй, чирэгдэлгүй Хэрэглэгч нарыг сэтгэл ханамжтай байлгах, сэтгэл ханамж үнэн бодиттой гарч, үйлчилгээгээ хөгжүүлэх, сайжруулахад чухал ач холбогдолтой.




5. “Сайн туршлага-2019”-д оролцож “Яаралтай тусламжийн ампултай эм тарианы цүнх” дэлгэрүүлсэн бүтээл

- Сонгодог эрсдэлт эм, ижил харагддаг эм, тариаг өнгөөр ялгаж өгснөөр эм тариа андуурагдах эрсдэлээс хамгаалж чадсан.
- Яаралтай тусламж үзүүлэх үед авч хэрэглэхэд хялбар гарын дор, эрж хайхгүй чухал ач холбогдолтой.
- Шинээр хийж үйл ажиллагаанд хэрэгжүүлснээр газар дээрх болон эмнэлэг хүртэлх эмнэлгийн тусламжийг яаралтай үзүүлэх үеийн ажлыг хөнгөвчилсэн эмх цэгц сайжирсан. Тус төвөөс дараах байгууллагууд судалж, захиалж хэрэгжүүлсэн.

1. НТТТ-ийн дуудлагын 165 эмчийн цүнхэнд 15 дүүргийн эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төв, бусад төрийн бус байгууллагууд тус тус захиалан хийлгэж үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна.

Сайн туршлагыг нэвтрүүлсэн байгууллагын тоо-15

“Сайн туршлага-2020” арга хэмжээнд 2020 оны 10 дугаар сарын 29-нд ТТАХНЭ-т зохион байгуулагдсан.



Байгууллагаас оролцож байгаа бүтээлийн танилцуулгыг өнгөтөөр гарын авлага хийж, 50 ширхгийг тараасан.

Нийслэлийн эрүүл мэндийн 29 байгууллагаас 300 гаруй бүтээл, сайн туршлага оролцсоноос, шилдэг 22 бүтээлд НЭМГ гэрчилгээ олгосон. Үүнд:

- Шинээр нэвтрүүлсэн үйлчилгээний технологийн чиглэлээр “Нийслэлийн түргэн тусламжийн төвийн Эмч, сувилагч, жолооч нарт мэргэжлийн ур чадварын үнэлгээ хийх удирдамж” бүтээлээр шилдэг бүтээлээр шалгарч, сайн туршлагын санд бүртгэж, гэрчилгээ олгосон.
- “Нийслэлийн түргэн тусламжийн төвийн Яаралтай тусламжийн эм, тарианы цүнх” бүтээлээр шилдэг бүтээлээр шалгарч, сайн туршлагын санд бүртгэж, гэрчилгээ олгож, амжилттай оролцож, НЭМГ-ын “Сайн туршлага-2020” номд бүтээлийн хэвлэлтэд орсон.

#### Албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдол

2020 онд эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой өргөдөл гомдол, санал хүсэлт 416 бүртгэгдсэн. 2019 онд гомдол 13, талархал 149 байсан нь 2019 онд ирсэн зарим гомдлыг дотоод хяналтад бүртгэж байсантай холбоотой. Харин талархал 2.5 дахин буюу 254% өссөн сайн үзүүлэлттэй байна.

Үүнийг ангилахад:

1. Ирсэн хэлбэрээр нь:
  - ЗГ-ын 11-11 төвөөс-339 (81.4%)
  - 1800-1200 тусгай дугаарын утсаар-26 (6.25%)
  - НЗДТГ-ын Нийтлэг үйлчилгээний нэгдсэн төвөөс-11 (2.64%)
  - ЭМЯ, НЭМГ-аас-8 (1.92%)
  - Утсаар болон биеэр ирсэн-32 (7.69%)
2. Төрлөөр нь:
  - Гомдол-47 (11.2%)
  - Хүсэлт -5 (1.2%)
  - Санал-1 (0.24%)
  - Талархал-363 (87.2%)
3. Шийдвэрлэсэн байдлаар нь:
  - Хуулийн хүрээнд хугацаанд нь шийдвэрлэсэн- 416 /100%/ буюу өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хугацаа 1 хоног 02 цаг 02 минут байна.
4. Хариуг өгсөн хэлбэрээр нь:
  - Иргэнд утсаар программ+мессежээр хариуг өгсөн- 383
  - Иргэнд утсаар болон биеэр ирэхэд хариуг өгсөн- 32
5. Гомдол/ санал, хүсэлтийг хэлбэрээр нь:
  - Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой алдаа, тохиолдол-21 (52.5%)
  - Үндэслэлгүй-3 (0.72%)
  - эмнэлгийн тусламж үйлчилгээний дагуу үйлчилсэн-6 (1.44%)
  - Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ёс зүй, утсан харилцааны алдаа, харьцаа, хандлагын алдаатай холбоотой-19 (45.6%) байснаас 5-ыг байгууллагын ёс зүйн хороонд шилжүүлсэн.
6. Гомдлын дагуу хэрэгжүүлсэн ажил:
  - Хурлын протоколоор сануулсан-30
  - Удирдлагын зөвлөлийн хурлаар-3
  - Эмч нарын ярианд анхааруулсан-94 удаа
  - Гомдлын шалтгаанд дүн шинжилгээ хийж, ЭМТҮЧАБ-ын албаны болон салбар төвийн багийн хурлыг тохиолдол бүрд хийж, тохиолдлыг бүртгэн, дахин алдахаас сэргийлж эмнэл зүйн тохиолдолд суурилсан персентэйшн бэлдүүлж, сургалт зохион байгуулах замаар мэдлэг мэргэжлийг нь дээшлүүлж ажилласан.
  - Ёс зүй, хэм хэмжээг сайжруулах 3 сарын аян зохион байгуулж ажилласан байна.
  - ЭМТҮЧАБ-ын албаны байгууллагын журам, хүүхдийн дуудлага хүлээн авах үйл ажиллагаатай холбоотой журмыг шинэчлэн боловсруулж ажилласан.
  - Бүртгэгдсэн гомдол, саналыг тохиолдлын бүртгэлд бүртгэн, эмч нарт тухай бүрт танилцуулж, мэдээлж, анхааруулсан.
  - Хүүхдийн тусламж үйлчилгээг нэмэгдүүлж сарын аян зохион байгуулсан.
  - Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын өдөрлөгийг зохион байгуулсан.
  - Стандарт, удирдамжийн дагуу дуудлагын хуудсанд ижил мэргэжилтний үзлэг, дуудлагын хуудас тогтмол шалгасан.

- Шинээр ажилд орсон 57 эмч нарт амилуулах суурь тусламжийн сургалт явуулж, түгээмэл үйлдлийн стандарт, жор бичилт, тоног төхөөрөмж, ХӨЦМ, хүүхдийн эрэмбэлэн ангилалт яаралтай тусламж болон насанд хүрэгчдийн өвчлөлийн эмнэл зүйн тохиолдлуудаар ур чадварын үнэлгээг онолын, гардан үйлдлээр 2-3 дахин давтан шалгалт авч ажилд орсон.
- Өргөдөл гомдлын тайлан мэдээ, хийсэн ажлын тайланг 14 хоног, улирал, хагас жилээр гарган, удирдлагад танилцуулан, талархлыг эмч, эмнэлгийн ажилчдын дунд алдаршуулан, улирлын урамшуулалд хамруулснаар, талархлын тоо урьд онтой харьцуулахад 2.5 дахин өссөн. Мөн иргэдээс ирж байгаа өргөдөл гомдлын 87.2%-ыг талархал эзэлж байна.
- Гомдол/хүсэлтийг барагдуулсны дараах үр дүн:

Нийт гомдлыг ар гэр болон гомдол гаргагчтай утсаар, биеэр харилцан ярилцаж, зөвлөгөө зөвлөмж болон мэдээлэл солилцож гомдол/хүсэлт 100% эергээр шийдэгдсэн. Гомдлын тоо буурч, талархал нэмэгдсэн.

#### 7. Талархал-363 буюу 87.2%

- Харин талархлыг 387 эмч, 19 сувилагч, 321 жолоочид түргэн шуурхай ирж тусламж үзүүлж, эмнэлэг хүргэсэнд, үйлчлүүлэгчийн амь насыг аварсанд, угаарын хийн хордлогын үед цаг алдалгүй тусламж үзүүлсэнд, хүүхдийн амь нас аварсанд, гэрт нь хүндрэлгүй эх барьж авсан зэрэгт талархсан талархлууд байна.

Д/д	Талархлын ирсэн хэлбэр	Тоо	Хувь
1	Засгийн газрын 11-11 төвөөс	329	90.6%
2	1800-1200 оператораас	6	1.6%
3	НЗДТГ-ын Нийтлэг үйлчилгээний нэгдсэн төвөөс	11	3.03%
4	Утсаар болон биеэр ирсэн	17	4.6%
		363	100%

#### Дотоод хяналт, шалгалт үнэлгээгээр илэрсэн алдаа зөрчил 15 удаагийн 25 алдаа, тохиолдол бүртгэгдсэн.

- 2020 онд ЭМТҮЧАБ-ын алба, эмнэлгийн тусламж үйлчилгээнд дотоод хяналтыг хийх журмыг шинэчлэн гаргасан. Мөн чанарын албанаас дотоод хяналтыг захирлын тушаалаар батлагдсан 8 чек листээр 12 удаа графикайн дагуу 11 чиглэлээр хийх хуваарь гаргаж ажилласан. Доорх чиглэлээр дотоод хяналтыг ЭМТҮЧАБ-ын алба, бусад алба, салбарын чанарын багуудтай хамтран явуулсан. Үүнд:
  - Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар сайжруулах чиглэлээр хийсэн ажилд хяналт хийсэн.
  - Эмнэлэг үйлчилгээний стандарт, удирдамжийн хэрэгжилтэд хяналт хийх
  - Зохицуулагчийн дуудлага гаргалт, эмчилгээ үйлчилгээний мэдээллийн хуудсанд хяналт хийх
  - Дуудлагын эмч, сувилагч, жолооч нарын бэлэн байдалд хяналт хийх
  - Дуудлагын автомашины халдваргүйтгэл, цэвэрлэгээ, үйлчилгээнд хяналт хийх
  - Дуудлагын автомашины тоног төхөөрөмжийн бэлэн байдалд хяналт хийх
  - Эмийн сангийн эм хангамж, хугацаат эм, бусад эм, тариа, хэрэглэгдэхүүнд хяналт хийх
  - Дуудлагын эмч нарын гар ариутгал, нэг удаагийн бусад хэрэгслийн зарцуулалтад хяналт хийх
  - Дуудлагын эмч нарын жор бичилтийн стандарт, жорын хуудас, тамга бүрэн эсэх
  - Дуудлагын оператор эмч, сувилагч нарын ажлын гүйцэтгэл, харьцаа хандлага, зөвлөгөө өгөхөд хяналт хийж чиглэлүүдээр ажилласан.

2020 онд чанарын хяналтыг салбар төвүүдэд чанарын багууд хийсний үр дүнд чанарын талаарх мэдлэг, алдаа, тохиолдлыг илрүүлж арилгах зэрэг үр дүнтэй ажил болсон.


- Эмнэлэг үйлчилгээнд илэрсэн алдаа зөрчлийг дотоод хяналтаар илрүүлж, тухай бүрд нь алдаа засаж, бусдад анхааруулга, сануулах, зөвлөмж зэргийг гаргаж ажилласан.
- Гарсан алдааны хувьд: дэвтэр хөтлөлт хангалтгүй, ариун цэвэр, өнгө үзэмж сайжруулах, энгэрийн тэмдэг зүүж хэвших, эмнэлгийн тоног төхөөрөмжийн цэнэглэлт, хадгалалт, хамгаалалт зэрэг зөрчлүүд гарсан.
- Авто бааз дээр дотоод хяналтыг сар бүр хийснээр эмнэлэг үйлчилгээнд үйлчилж буй машины өнгө үзэмж сайжирч, жолооч нарын ажилдаа хандах хандлага, хариуцлага нэмэгдэж байна.
- Тохиолдлын дүгнэлтийг үндэслэн магадлан хэлэлцэж, нотолгоонд суурилсан аргачлал зөвлөмж 9-ыг боловсруулан гаргасан. Гаргасан зөвлөмжийг нийт эмч нарт танилцуулан судлуулсан.
- Дотоод хяналтын үр дүн, тохиолдолд суурилсан 11 зөвлөмж гаргаж, дуудлагын эмч, оператор эмч, сувилагч нарын үйл ажиллагаанд хэрэгжүүлж анхаарч ажилласан. Үүнд:
  - 0-5 насны хүүхдийн эндэгдлийн тохиолдлын хэлэлцүүлгээс гарсан зөвлөмж
  - Хүүхдийн менингококкт халдварын өвчлөлийн үеийн зөвлөмж
  - Томуугийн өвчлөлийн үед ажиллах зөвлөмж
  - Гэрийн төрөлтийн дуудлагын хуудсанд хийсэн хэлэлцүүлгийн зөвлөмж
  - Гэрийн төрөлтийн үед эх барих, нярайд үзүүлэх эмнэлгийн тусламж хэлэлцүүлгийн зөвлөмж
  - Энэрэл эмнэлэгт хүлээлгэн өгсөн өвчтөнүүдийн яаралтай тусламжийн хуудсанд хийсэн хяналтаас зөвлөмж гаргасан.
  - ЭХЭМҮТ-өөс эхийн эндэгдлийн тохиолдлуудын хийсэн хэлэлцүүлгийн зөвлөмж
  - Эмнэлгийн хүлээн авахад нас барсан тохиолдлуудад хийсэн хяналтаас гарсан зөвлөмж
  - Хүүхдийн дуудлага хүлээн авах зөвлөмж
  - Хүүхдийн утсан харилцааны алдаанаас гарсан зөвлөмж
  - Халдвар хамгааллын дэглэм баримтлах зөвлөмж зэргийг гаргаж үйл ажиллагаандаа хэрэглэж байна.

Сэтгэл ханамжийн судалгаа:

Эрүүл Мэндийн Сайдын 2014 оны 01 сарын 13-ны өдрийн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааны аргачлал батлах тухай 13 тоот тушаалын дагуу Нийслэлийн Түргэн тусламжийн төвөөр үйлчлүүлсэн 300 үйлчлүүлэгчдийг байгууллагын соёл, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёл, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, тэгш байдал, ашиг сонирхол гэсэн 4 бүлэг 21 асуултаар судалгаа авсан.

Үйлчлүүлэгчээс авсан сэтгэл ханамж:

- Байгууллагын ажилтны нэгдсэн загвар бүхий хувцаслалт, энгэрийн тэмдэг гэсэн асуултад энэ онд 94%-ийн сайн гэж хариулсан нь байгууллагын ажилтны хувцасны өнгө үзэмж сайн байгааг харуулж байна. Судалгаанд оролцсон нийт үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж манай байгууллагын үйлчилгээний талаар хангалттай эерэг үнэлгээ өгсөн байна.




- Дуудлагад шуурхай ирдэг эсэх гэсэн асуултад энэ онд 98.4% өгсөн нь өмнөх оноос 2%-р өссөн сайн үзүүлэлттэй байна. Иргэдийн замын хөдөлгөөний соёл, гэр хорооллын хаягжилт болон НТТТөвийн жолооч нарын ур чадвар сайн байгааг харуулж байна.



- Байгууллагын эмч нарын үзлэг оношилгоо хийж тусламж хүргэх ур чадвар, хандлага 95.2% өндөр үзүүлэлттэй байна.




- Судалгаанд оролцсон нийт үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж манай байгууллагын үйлчилгээний талаар хангалттай эерэг үнэлгээ буюу 97% өгсөн байна.




- Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёлыг судалгаанд хамрагдсан нийт үйлчлүүлэгчид дараах үзүүлэлтээр хангалттай эерэг үзүүлэлтээр үнэлсэн байгаа нь байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, жолооч нарт улирал бүр “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харьцаа хандлага” сэдэвт сургалт, аяныг зохион байгуулагдаж бөгөөд сургалтын үр дүн харагдаж байна.







- Тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг судалгаанд 2020 онд хамрагдсан нийт үйлчлүүлэгчдийн 90% нь эмч эмнэлгийн мэргэжилтний ажлын хариуцлага, шуурхай байдлыг сайн хангалттай гэж үнэлсэн байна. Эмчилгээний чанар хүртээмж 89.2% хангалттай сайн гэж үнэлсэн байна.
- Энэ нь ажилд шинээр орсон эмч нарыг дагалдуулж, дадлагажуулж ур чадварын үнэлгээ авдаг нь эмчилгээний чанар хүртээмж сайн байгааг харуулж байна.



- Тэгш байдал, ашиг сонирхлын судалгаанд тусламж үйлчилгээ авах, хүлээгдлийг багасгах, үйлчилгээг шуурхай болгохын тулд шан харамж, албан бус төлбөр өгөх шаардлага гардаг уу? гэсэн судалгаанд 94.% үгүй гэсэн бөгөөд 5.9% мэдэхгүй гэсэн үнэлгээ өгсөн нь шаардлага гардаггүй гэж байгаа нь түргэн тусламж төлбөрт үйлчилгээ байдаггүйтэй холбоотой эерэг үзүүлэлт юм.



- Байгууллагын ерөнхий сэтгэл ханамж сайн 84% сайн гэсэн үнэлгээтэй үнэлэгдсэн байгаа нь иргэдийн сэтгэл ханамж эерэг сайн байгааг харуулж байна.




2. Эмч, эмнэлгийн ажиллагсдын сэтгэл ханамжийн судалгаа:


Эмч, эмнэлгийн ажиллагсдын сэтгэл ханамжийн судалгаанд сувилагч 17, эмч 115, жолооч 85, бусад ажилчид 43, нийт 260 хүн хамрагдсан.

Дэмжлэгт удирдлага, хүний нөөцийн хөгжих боломж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёл, байгууллагын соёл, тусламж үйлчилгээний чанар, ажлын аюулгүй байдал, дэмжлэгт орчин гэсэн 6 бүлэг 62 асуултаар судалгаа авсан.


- Дэмжлэгт удирдлага гэсэн бүлэгт 2019 онд байгууллагын дарга нарын удирдах арга барил 88.4%, ёс зүй 86.4% сайн гэсэн эерэг үзүүлэлттэй байсан бол 2020 онд байгууллагын дарга нарын удирдах арга барил 88.1%, ёс зүй 86.5 % сайн гэсэн эерэг үзүүлэлттэй хэвээр байна.



- Байгууллагын санхүүгийн ил тод байдал 42.8-43% дунд үнэлгээг өгсөн байгаа нь эмч, ажиллагсад вэб сайтад орох мэдээлэл авах, шилэн данс шалгаж мэддэггүй байгаа нь үзүүлэлт дунд байгааг харуулж байна.




- Ажлын гүйцэтгэлийн үнэлгээ 2019 онд 89.2% байсан бол 2020 онд 90.7% болж 1.5%-р өссөн үзүүлэлт харагдаж байна.




- Удирдлагадаа санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломж 86% чөлөөтэй илэрхийлдэг үзүүлэлт нь хамт олонтой нээлттэй санал бодлыг сонсох өдөр гаргаж буй нь харагдаж байна.
- Харин эмч, эмнэлгийн ажилтны эрүүл мэндийг хамгаалах ажилд 88.4% хангалттай үнэлгээтэй авсан.



- Хүний нөөцийн хөгжих боломж мэдлэг мэргэшлээ дээшлүүлэх, ашиглах гэсэн үнэлгээнд 81.8% сайн гэж хариулсан нь урьд онтой харьцуулахад 2.4%-иар илүү буурсан үзүүлэлттэй байна.



- Судалгаанд хамрагдсан нийт эмч, ажиллагсдын хүний нөөцийн сонгон шалгаруулалтын ил тод байдал 93.3%-тай ажилд шинээр орж байгаа эмч, ажилчдын сонгон шалгаруулалт ил тод байгааг харуулж байна.




- Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг 24 цагаар хамтдаа ажилладаг зохицуулагч жолооч, эмч, сувилагч гэж асуултыг гаргасан бөгөөд тус судалгаагаар ёс зүй 70-аас


дээш хувьтай байгаа нь багаар ажиллах, нэг нэгнээ хүндэтгэх, мэндлэх, найрсаг харилцаа сайн байгааг харуулж байна.

2019 он


2020 он



- Байгууллагын соёл гэдэг бүлэгт байгууллагын дотоод орчны соёл, тав тух гэсэн судалгаанд оролцогсдын 93.4% сайн гэж үнэлсэн байгаа нь өмнөх онтой харьцуулахад 1.4%-аар өссөн байна. Энэ нь байгууллагын гадаад, дотоод орчны тохижилт, засварыг салбар төвүүд байгууллагын түүхт 90 жилийн хүрээнд байгууллага болон өөрсдийн хүч санаачилгаар хийж ажиллах орчин сайжирснаар харагдаж байна.




- Байгууллагаараа бахархах сэтгэл 96.8% эзэлж байгаа нь 2019 онтой харьцуулахад 3.5%-аар өссөн эерэг үзүүлэлт гарсан байгаа нь хамт олны уур амьсгал, ажиллах урам зоригтой болоод байгууллагын үйл ажиллагаа ажилчдын төлөө ажиллаж байгаа нь харагдаж байна.




- Тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдалд судалгаанд оролцогсдын 54.4% сайн гэж үнэлсэн байна. Өмнөх онтой харьцуулахад 1.7 %-аар өссөн эерэг үзүүлэлттэй байгаа нь эмч, жолооч нарын ажлын ур чадвар сайн байгааг харуулж байгаа ч сайжруулах шаардлагатай байна.
- Салбар ээлжүүдэд тусламж үйлчилгээний стандартыг мөрдүүлж ажиллах, сургалт явуулах хэрэгтэй харагдаж байна. Ажлын хариуцлага, шуурхай байдал 63.6% буюу өмнөх оноос 0.4%-р өссөн байгаа ч өмнөх онд муу үнэлгээг нийт судалгаанд хамрагсдын 4.3 % өгч байсан бол энэ онд 1.6% хувь болж буурсан нь сайн үзүүлэлт билээ.


Тусламж үйлчилгээний стандартын мөрдөж ажиллах боломж 2019 он




Тусламж үйлчилгээний стандартын мөрдөж ажиллах 2018 он



2018 он



2019 он




**Ажлын байрны аюулгүй байдал, дэмжлэгт орчин:**


Энэ бүлэгт өмнөх оноос үзүүлэлт эмнэлгийн халдвар хамгаалал 2.6% -аар буурсан , Ажлын байрны тав тух, агааржуулалт, тохижилт 5%-аар буурсан буюу 37.6%-ын сайн үнэлгээг өгсөн.

Ажиллагсдын хоолны газрын эрүүл ахуй, тохижилт 48.4%, ажлын байрны чийрэгжилт, алжаал тайлах нөхцөл 21.2% муу үнэлгээ өгсөн, алжаал тайлах нөхцөл 32.8 % сайн гэж үнэлж өмнөх оноос 6%-аар буурсан. Ерөнхий сэтгэл ханамж 48.8% тай гарсан байна.


Эмнэлгийн эрүүл ахуй, халдвар хамгаалал





Эмнэлгийн эрүүл ахуй, халдвар хамгаалал 2019 он



Ерөнхий сэтгэл ханамж 2019 он




Ажлын байрны чийрэгжилт, алжаал тайлах нөхцөл 2019 он





1. ЭрүүлМэндийнСайдын 2014 оны 01 сарын 13-ны өдрийн үйлчлүүлэгчийн сэтгэлханамжийнсудалгааныаргачлалбатлахтухай 13 тооттушаалындагуутус төвөөр үйлчлүүлсэн 150 үйлчлүүлэгчийг хамруулансэтгэлханамжийнсудалгаа хийсэн.

- Тус төв нь 18-75 насны 150 үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг Төв, Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул салбараар үйлчлүүлж буй 6 дүүргийн 150 үйлчлүүлэгчдээс байгууллагын соёл, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёл, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, тэгш байдал, ашиг сонирхол гэсэн 4 бүлэг 21 асуултаар судалгаа авсан.
- Байгууллагын ерөнхий сэтгэл ханамж сайн 66.6% сайн үнэлгээтэй үнэлэгдсэн байгаа нь иргэдийн сэтгэл ханамж эерэг сайн байгааг харуулж байна.



**Ажлын байрны сургалтын цагийг өмнөх онтой харьцуулахад:**

202 онд тус төвийн нийт 410 ажилчдад 12 удаагийн 12 цагийн мэргэжлийн сургалт эмч, сувилагч нарт зохион байгуулсан.

Эмч, сувилагч нарт дараах сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд:

- Хууль эрх зүй, ёс зүйн сургалт 1 удаагийн 1.5 цагийн сургалт зохион байгуулсан. Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлага сэдэвт сургалт удаа 1 цагийн сургалт давхардсан тоогоор 187 захиргааны ажилтан, эмч, сувилагч, дагалдан эмч, жолооч нар хамрагдсан.
- Зүрх судасны өвчин, харвалтаар 5 удаагийн 5 цагийн сургалт 131 эмч, сувилагч, дагалдан эмч нар хамрагдсан. /УКТЭ зүрх судасны тасгийн эмч Б.Бум-эрдэнэ ШУГТЭ Харвалтын тасгийн их эмч П.Бурмаа,
- Халдварт өвчнүүдээр 7 удаагийн 7 цагийн сургалт 128 эмч, сувилагч, дагалдан эмч нар хамрагдсан. /ХӨСҮТ-н эмч С.Ундармаа /

- Тус төвийн гамшгийн үеийн бэлэн байдал, гамшгийн үед хэрхэн ажиллах, амилуулах тусламжийн эрэмбэлэн ангилалт, байгууллагын гамшгийн төлөвлөгөөний бүтэц, зохион байгуулалт сэдвээр дэд захирал С.Ариунболд 2 удаагийн тус бүр 2 цагийн онлайн сургалт эмч, болон гамшгийн штабын ажилтнуудад зохион байгуулсан.

2020 онд COVID-19 холбоотой 1 дүгээр сарын 25-ний өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдөр хүртэл танхимын сургалтын төлөвлөгөөний дагуу ороогүй бөгөөд Онлайн сургалт 05 сарын 01-ний өдрөөс эхлэн салбар төвүүдэд зохион байгуулсан. Сургалтын 80 орчим хувь Корона вирустэй холбоотой сургуултуудыг зохион байгуулсан.

ДЭМБ дэмжлэгтэй халдварт өвчин судлалын бага 60 эмч,ажилтанд Корона вирусн оношилгоо, халдвар хамгаалал талаар сургалт зохтон байгуулсан.

2020 оны 06 дугаар сарын 13-ний өдөр 10 эмчийн Коронавирусийн өвчний сургагч багшийн сургалтад хамруулсан.

#### **Нийгмийн асуудал шийдвэрлэсэн байдал:**

Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх олон талт арга хэмжээ зохион байгуулах, ажилчдын ажиллах урам зоргыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд:

- Нийт 4 улиралд 421 орон тооны дунджаар 78 хувь 320-оод ажиллагсад цалингийн 60 хүртэлх хувиарбууу 442.764.000 төгрөгөөр үр дүнгийн урамшуулсан.
- “Ковид-19” цар тахлын халдвараар сайн ажилласан давхардсан тоогоор 2 удаа 113 ажилтанд олгосон /УОК-оос 11 сая төгрөг/
- Байгууллагын жилийн эцсийн үр дүнгийн гэрээний үнэлэлтээр 26 хариуцлагатай ажилтныг урамшуулсан.
- Аудитын зөрчилгүй ажилласан 12 ажилтны 1-2 сарын цалингаар урамшуулсан.
- Санхүүгийн ажилчдын эхний хагас жилийн тайлан, мэдээ дүгнэлтээр 8 ажилтныг 2 сарын цалингаар урамшуулсан.
- Статистик, архив бичиг хэргийн хөтлөлтийн үзлэг шалгалт, үнэлгээгээр 9 ажилтныг урамшуулсан.
- Нийт 421 ажилтнаас ур чадварын нэмэгдэл 193, зэргийн нэмэгдэл 14, төрийн алба хаасан нэмэгдэл 147, нууцын нэмэгдэл 2, мэргэшсэн жолоочийн нэмэгдэл 105 жолоочид нийт 465.827.600 төгрөгийн нэмэгдэл олгосон.
- 421 ажилтанд Өдөрт 2 удаа нэг хоёрдугаар хоол өгдөг. Унааны мөнгө ажилдаа ирж буцах 1400 төгрөг нийт 443.177.900 төгрөг олгосон.

2020 онд нийт 356 ажилчдад 32 удаагийн 63 цагийн сургалт зохион байгуулахаар төлөвлөгөө гарган ажилласан.

- Эмч, сувилагч нарт 31 удаа сургалт зохион байгуулсан. Үүнд: Хууль эрх зүй, ёс зүй, харьцаа хандлагатай холбоотой 6 цаг, Ковид-19 халвар болон шинэ болон дахин сэргэж байгаа өвчлөл, халдвар хамгаалалын хувцас өмсөх, тайлах талаар 15 цаг, осол гэмтэл, хордлого 2 цаг, амьсгалын замын өвчин 3 цаг, артерийн гипертензи, зүрх судасны өвчлөлтэй холбоотой 2 цаг, эх барих эмэгтэйчүүд 2 цаг гэх мэт сургалт зохион байгуулсан.


- Нийт 172 эмч, сувилагч нарыг дээрх сургалтад хамруулсан. Эмч, сувилагч нарыг тус сургалтад хамруулснаар газар дээрх болон эмнэлэг хүртэлх тусламж үзүүлэх мэдлэг чадвар дээшилж, улмаар эмнэлэг үйлчилгээ, харьцаа хандлагатай холбоотой алдаа зөрчил гарахаас сэргийлж, эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай, олон улсын түвшинд үзүүлсэн.

- Жолооч, техникийн алба, инженерүүдэд 3 удаагийн 4 цагийн хөдөлмөр хамгаалал, хууль эрх зүй, авто машины тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа, замын хөдөлгөөний дүрэм, Халдвар хамгаалалын хувцас өмсөх, тайлах талаар онол дадлагын сургалтуудыг зохион байгуулсан.

- 2020 онд нийт 7 их эмч яаралтай тусламжийн чиглэлээр ахлах зэрэг хамгаалсан.

- 2020 онд Эрүүлийг хамгаалах гавьяат ажилтан-1, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон 2, Алтан гадас 3, Хөдөлмөрийн хүндэт 1, Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан 20, Эрүүл мэндийн яамны жуух 14, Автотээврийн тэргүүний ажилтан 6, Зам, тээврийн хөгжлийн яамны хүндэт жуух 1, НИТХ-ын хүндэт тэмдэг 3, НИТХ-ын хүндэт өргөмжлөл 4, НИТХ-ын хүндэт үнэмлэх 3, Нийслэлийн тэргүүний ажилтан 3, Улаанбаатар хотын хүндэт тэмдэг 3, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн жуух бичиг 4, НЭМ-ийн тэргүүний ажилтан 15, НЭМГ-ын өргөмжлөл 5, Монголын мастер тогоочдын холбооны тэргүүний ажилтан 2, Монголын мастер тогоочдын холбооны шилдэг залуу ажилтан 1, Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн баярын бичиг 3, АШУҮИС-ийн Эрдмийн очир 2, ТББ-ын Хөгжлийн эзэн 1, нийт 97 ажилчдад шагнал гардуулсан.

Ажилчдын нийгмийн асуудал шийдвэрлэсэн мөнгөн дүнг 2019 оны жилийн эцэстэй харьцуулахад:



### Гадаад дотоодын ижил төст байгууллагуудтай хамтран ажиллах хүрээнд

1. ХБНГУ-ын Эссэн хот, Монгол улсын Улаанбаатар хотын хамтын ажиллагааны хэлэлцээрийн дагуу Эссэн хотын Аврах гал унтраах анги, Их сургуулийн нэгдсэн эмнэлэг, Улаанбаатар хотын Нийслэлийн Түргэн тусламжийн төв 4 үндсэн чиглэлээр хамтран ажилладаг.

1. Эмнэлгийн туслах ажилтан парамедикбэлтгэх
2. Халдваргүйтгэл, ариутгал, автомашиныг 2 хувингийн аргаар ариутгаж цэвэрлэх
3. Гепатит В вакцинд хамрагдах
4. Сургалт 2020 онд тус чиглэлээр хийгдэх байсан сургалт, хамтын ажиллагаа түр хойшилсон.

2. Япон улс

➤ АМДАолон улсын байгууллага:

- Олныг хамарсан гамшиг ослын үед харилцан туслалцах
- Яаралтай тусламжийн чиглэлээр харилцан туршлага солилцох
- Яаралтай тусламжийн сургагч багш бэлтгэх сургалтад хамруулах

Дэлхий даяар тархаад байгаа коронавирус /Covid-19/-тэй холбоотой 2020 оны эхний хагас жилийн байдлаар Нийслэлийн Түргэн тусламжийн төвд хэрэгжиж буй төсөл, гадаад хамтын ажиллагаа хөтөлбөр байхгүй.





### Хот тохижилт ногоон байгууламжийн талаар:

Нийслэлийн Түргэн тусламжийн төв нь Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Уриалга гаргах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай” А/168 тоот захирамжийн дагуу өөрийн өмч, эзэмшил, ашиглалтад байгаа газар болон орчны 50 метр хүртэлх газрын хог хаягдлыг цэвэрлэх, зайлуулах, ногоон байгууламж арчилгааг хийх заалтуудын дагуу төв болон 5 салбар тус бүрдээ өөрийн эзэмшлийн орчны 50 м талбайд хог хаягдлын цэвэрлэгээ болон дотооддоо их цэвэрлэгээг 14 хоног тутамдаа тогтмол хийж, тайлан мэдээг НЭМГ-т цахим хэлбэрээр хүргүүлэн ажиллаж байна.



- Монгол Улсын Еерөнхийлөгчийн зарлигаар жил бүрийн тав болон аравдугаар сарын хоёр дахь долоо хоногийн бямба гаригийг "Бүх нийтийн мод тарих үндэсний өдөр" хэмээн зарласан билээ.

Энэхүү ажлын хүрээнд НТТТ-н I ээлжийн хамт олон Чингэлтэй салбартаа 2 нэр төрлийн мод тарьж, зүлэг суулгалаа.

Үүнд

- ✓ Шинэстэй 6 ширхэг
- ✓ Хайлаас 12 ширхэг



Мөн Сонгинохайрхан салбар зөв өсөлт хөгжилтийг дэмжин ургалтыг сайжруулах зорилгоор салбарын модонд таналт тайралт хийсэн. Үүний үр дүнд мод хэлбэржиж, ургалт сайжирч байна.



## **9.1.2. ХОЁРДУГААР БҮЛЭГ ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН**

МУ-ын Шадар сайдын тушаал -1

1. 30-“Хөрөнгө гаргах тухай”

НЗДаргын захирамж - 8

1. А/108 “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”

2. А/168 “Уриалга гаргах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай”

3. А/191 “Өндөржүүлсэн бэлэн байдалд шинжин ажиллах тухай”

4. А/307 “Эрсдэлийн үнэлгээ хийх тухай”

5. А/567 “Журам батлах тухай”

6. А/654 “Тээврийн хэрэгсэл балансаас балансад шилжүүлэх тухай”

7. А/655 “Тээврийн хэрэгсэл балансаас балансад шилжүүлэх тухай”

8. А/747 “Шагнаж урамшуулах тухай”

Эрүүл мэндийн сайдын тушаал -5

1. А/32 “Эмнэл зүйн зөвлөх багийн ажиллах журам, чиглэл батлах тухай”

2. А/99 “Эмнэлгийн тусламж үйлчилгээг зохицуулах тухай”

3. А/101 “Covid-19 үед эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх зураглал батлах тухай”

4. А/122 “Тоног төхөөрөмжийг хуваарилах, үндсэн хөрөнгөд бүртгэх тухай”

5. А/126 “Хариуцлагатай жижүүр томилон ажиллах тухай”

Эрүүл мэндийн сайдын албан даалгавар -2

1. 19 –“Коронавирусийн бэлэн байдлыг хангах тухай”

2. 23- “Батлагдсан төсвийг зохистой зарцуулах тухай”

НЭМГ-ын даргын тушаал-14

1. А/03 “Цалин хөлсийг шинэчлэн тогтоох тухай”

2. А/13 “Төлөвлөгөө батлах тухай”

3. А/18 “Эмнэлгийн тусламж үйлчилгээг зохицуулах тухай”

4. А/19 “ХЭМБ дарга нарын үр дүнгийн болон түншлэлийн гэрээ дүгнэсэн тухай”

5. А/215 “Covid-19 эрсдэлийг бууруулах зарим арга хэмжээний тухай”

6. А/22 “ХЭМБ-ын 2019 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлсэн тухай”

7. А/15 “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай”

8. А/32 “Хүүхдийн эндэгдлийн талаар авах зарим арга хэмжээний тухай”

9. А/51 “Хачгаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай”

10. А/41 “Сувилахуй, эх барихуй чиглэлээр хэрэгжүүлэх нэгдсэн арга хэмжээний тухай”

11. А/42 “Урамшуулал олгох тухай”

12. А/47 “Дадлага сургуульд оролцох тухай”

13. А/52 “Дэд штаб байгуулах тухай”

14. А/62 “Урамшуулал олгох тухай”

НЭМГ-ын даргын албан даалгавар-1

1. 01- “Шинэ корона вирусийн халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах тухай”

НӨАУГ-ын даргын тушаал-1

1. А/94 “Угаарын хий хэмжигч төхөөрөмж бүртгэх”

**Шадар сайдын тушаал -1**

**НЗД-ын захирамж -8**

**НЭМГД-ын тушаал -14, Албан даалгавар -1**

**ЭМС-ын тушаал -5, Албан даалгавар-2**

**НӨАУГ-ын даргын тушаал – 1, нийт 32 тушаал, шийдвэрийг биелүүлэн ажилласан.**

### 9.1.3.ГУРАВДУГААР БҮЛЭГ: БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

#### Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 01 албан даалгаврын хүрээнд.

1. Гамшгаас хамгаалах тодотгол хийж, хүч хэрэгслийн судалгааг шинэчлэн болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээ, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах:

- Хэсэгчилсэн өндөржүүлсэн бэлэн байдлын үеэр болзошгүй урьдчилан сэргийлэн, түргэн тусламжийн тусламж, үйлчилгээ хариу арга хэмжээний бэлэн байдлыг хэрхэн хангаж буйг нягтлах зорилгоор 4 удаагийн ADRA түргэн цугларалтын арга хэмжээг зарлан ажиллалаа. Энэ цугларалтын үеэр ажилчдын бэлэн байдал 100 хувь хангагдан ажиллалаа.
- “Covid-19 “ вирусийн одоогийн нөхцөл байдлын үед хэсэгчилсэн өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбоотойгоор төв автобааз салбарын ажилчдын хурал, болон мэдээ мэдээллийг өдөр тутам цахим хурал хийж, ажилчдыг олноор цугларч халдвар тархах эрсдэлээс урьдчилан сэргийлэн ажиллаж байна.



Цахим хурлаараа түргэн тусламжийн төвд ирсэн дуудлагын тоо, угаарын хийн хордлого, жирэмсэн болон хүүхдийн яаралтай дуудлага, коронавирусийн сэжигтэй дуудлагын талаар салбар тус бүрээс мэдээлэл авч ажиллаж байна. Цахим хуралд НТТТ-ийн төв, авто бааз болон Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй, Хан-уул дүүрэг дэх салбарууд бүрэн хамрагдаж байна.



➤ 2020 оны 5 сарын 6-8-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Ковид-19” халдварт цар тахлын үеийн харилцан ажиллагаа, хариу арга хэмжээ” арга хэмжээнд тус төвийн Гамшгийн штаб цар тахалын мэдээ, цагийн байдалын мэдээнд шуурхай хариу мэдэгдэж, хэрэгжүүлсэн арга хэмжээ, саналуудаа нэгтгэн Нийслэлийн Онцгой комисс болон Эрүүл мэндийн нэгдсэн системд цаг тутамд хүргүүлэн, шатбын баг бүрэн бүрэлдэхүүнээрээ амжилттай ажиллалаа.

- “Ковид-19” халдварт цар тахлын үеийн харилцан ажиллагаа, хариу арга хэмжээ” дадлага сургуулилт:

2020 оны 05 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулагдсан Covid-19 халдварт цар тахалтай тэмцэх бэлэн байдлын дадлага сургуулилт “Яармаг-100” эмнэлэгт сэжигтэй тохиолдол болон халдварын эрсдэлтэй иргэдийг тээвэрлэх дадлага сургуулилтад тус төвийн 4 их эмч, жолооч нар нийт 8 хүн оролцож, дэд захирал С.Ариунболдоос ажлын зааварчилгаа авч 2020.05.07-ны өдрийн 07:30 минутад бэлэн байдалд цугласан.

1. Их эмч Б.Батзул, жолооч Б.Баяраа –автомашины дугаар УБУ 25-60
  2. Их эмч Б.Баттөр, жолооч А.Болбаатар - автомашины дугаар УБН 83-60
  3. Их эмч Б.Болдсайхан, жолооч Энхбаяр - автомашины дугаар УАЕ 20-60
  4. Их эмч Ц.Эрхэмбаяр, жолооч Анхныбаяр - автомашины дугаар УАЕ 20-90
- 08:05 Буянт ухаа спорт цогцолбор “Яармаг-300” эмнэлэг дээрээс тус төвийн захирал Ц.Пүрэвдашаас зааварчилгаа авсан.
  - 11:30 минутад Ерөнхий сайд У.Хүрэлсүх, Эрүүл мэндийн сайдын Д.Сарангэрэл, Нийслэлийн Засаг дарга С.Амарсайхан нар ирж дадлага сургуулилт эхэлсэн.
  - 11:45 минутад “Яармаг-300” эмнэлэгт 1 иргэнийг тээвэрлэн хүргэв.
  - 12:05 минутад “Яармаг-100” эмнэлэгт 1 иргэнийг /биеийн байдал хүнд/ зөөврийн ороор тээвэрлэн хүлээлгэн өгсөн.



Тус сургуулилт амжилттай оролцож 18:00 цаг хүртэл өндөржүүлсэн бэлэн байдалд ажилласан.

2. Тус төв нь 2020 оны 3 сараас эхлэн Улсын онцгой комиссын шийдвэрийн дагуу 73 удаагийн тусгай үүргийн онгоц тосон бэлэн байдлыг ханган ажилласан. Энэхүү тусгай үүргийн онгоцоор нийт 272 иргэнийг хүлээн авч, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Цэргийн төв эмнэлэг болон тусгаарлах байрнуудад хүргэн өгч ажилласан байна. Тусгай үүргийн онгоц тоссоны дараа машины халдваргүйтгэлийг заавар журмын дагуу халдваргүйжүүлэн ажиллаж байна.



Тусгай үүргийн онгоц тоссон нэгтгэлийг хавсралтаар хавсаргасан болно.

2020 оны 11 сарын 12-ны өдрөөс Covid 19-н сэжигтэй иргэдийг 4 удаагийн 27 тээврийн хэсэгслээр 126 том хүн, 32 хүүхдийг цэргийн төв эмнэлэг, Дреам зочид буудал, ХӨСҮТ, Тайж зочид буудалд хүргэж тээвэрлэсэн.



3. Тус төвийн тандалтын баг одоогийн байдлаар Covid19-н тандалтыг ХӨСҮТ-н баг болон НЭМГ-тай хамтран нийт 5 удаагийн тандалтын үйл ажиллагаанд оролцож, 377 иргэнээс PCR болон түргэвчилсэн оношлуураар шинжилгээ авч сорьцоо ХӨСҮТ болон ЗӨСҮТ-д хүргэн ажиллалаа.

Нийт 377 шинжилгээний:

- Дангаараа PCR шинжилгээ 151
- PCR + Covid19 ag test 207
- Дангаараа Covid19 ag test 19

Тандалтын багийн бүрэлдхүүн:

- Ахлагч: Б.Сарантуяа
- Сувилагч: Н.Отгонбаатар
- Ариутгагч: Б.Уранчимэг
- Жолооч: В.Гантөмөр



Тандалт хийсэн өдрүүдийн байршил:



- 11 сарын 16-ны өдөр хавьтлын судалгаа – БЗД, СБД, СХД нутаг дэвсгэрээс нийт 48 хүнээс PCR шинжилгээ авч, 27 хүнийг тусгаарлах байранд хүргэсэн. Сорьцыг ХӨСҮТ –д хүргэсэн. /Хавьтлын судалгаа/
- 11 сарын 19-ний өдөр СХД –н тэнэмэл, гудамжны согтуу нийт 29 иргэнээс PCR болон түргэвчилсэн оношлуураар шинжилгээ авч, сорьцоо ЗӨСҮТ-д хүргэн ажиллалаа. /Эмзэг бүлгийн иргэдээс Covid 19-н илрүүлэг шинжилгээ авах/
- 11 сарын 21-ний өдөр Баруун туруун болон 22 товчооноос нийт 100 иргэнээс PCR болон түргэвчилсэн оношлуураар шинжилгээ авч, сорьцоо ХӨСҮТ-д хүргэн ажиллалаа
- 11 сарын 21-ний өдөр Баруун турууны товчооноос 2 удаагийн давтамжтай нийт 17 иргэнээс PCR болон түргэвчилсэн оношлуураар шинжилгээ авч, сорьцоо ХӨСҮТ-д хүргэн ажиллалаа.
- 12 сарын 04-ний өдөр I автобус баазын ажилчдаас түргэвчилсэн оношлуур болон PCR шинжилгээгээр нийт 134 хүнээс хамар залгиураас арчдас авч, шинжилгээний сорьцыг ЗӨСҮТ-т хүргэлээ.



Энэ хугацаанд PCR болон түргэвчилсэн оношлуураар авсан шинжилгээний хариу бүгд сөрөг гарсан байна.

Мөн 2020 оны 11 сарын 23-аас 12 дугаар сарын 04-ний хооронд төвийнхөө нийт 442 ажилтан албан хаагчдаас PCR болон түргэвчилсэн оношлуураар шинжилгээ авч, сорьцыг ХӨСҮТ-н лабораторит шинжлүүлсэн. Ажилчдын шинжилгээг 2 баг гарган салбар нэгжүүдэд очиж, халдвар хамгааллын дэглэмийг сахин, заавар зөвлөмжийн дагуу шинжилгээг авч ажиллалаа.

4. Амны хаалт – “Бидний аюулгүйн баталгаа” уриатайгаар зохион байгуулагдаж байгаа “АМНЫ ХААЛТАА ЗҮҮЦГЭЭ” нэгдүгээр аянд нэгдэж, аяны дагуу 9 зүйл бүхий төлөвлөгөө боловсруулан төлөвлөгөөний дагуу коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, болзошгүй эрсдэлээс хамгаалах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хариуцлагыг дээшлүүлэх, халдвараас сэргийлэх, эрүүл ахуйн зөв дадал, хэвшлийг төлөвшүүлэх зорилготойгоор байгууллагын сайт (<http://103.ub.gov.mn/>) болон facebook хуудсанд (Нийслэлийн Түргэн Тусламжийн Төв) тогтмол байршуулж, ард иргэдийг цахим мэдээ, мэдээллээр ханган ажилласан тухайн аяны дагуу хийсэн ажлын тайланг цаг хугацаанд нь НЭМГ-т хүргүүлсэн.



Улсын онцгой комиссын 2020 оны Коронавируст цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд “Маскаа зүүцгээе, гараа угаая” 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрөөс 12 дугаар сарын 31-ний хооронд зохион байгуулагдаж буй хоёрдугаар аянд тус төв нэгдэж, 5 зүйлийн 13 төрлийн ажил бүхий төлөвлөгөөг боловсруулан баталж, төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг эхлүүлэн ажиллаж байна.



Төлөвлөгөөний дагуу хийсэн ажлын тайланг долоо хоног бүрийн Пүрэв гараг бүр НЭМГ рүү дараах цахим хаягаар хүргүүлэн ажиллаж байна. Цахим хаяг: [ubhealth2020@gmail.com](mailto:ubhealth2020@gmail.com)

4. Covid 19-н сургалтыг ХӨСҮТ болон НЭМГ-тай хамтран зохион байгууллаа. Үүнд:

2020.05.26 болон 2020.06.03-ний өдрүүдэд ХӨСҮТ-н эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын тасгийн эрхлэгч Ж.Нямсүрэн, эмч Б. Соёлмаа нар ирж “Коронавируст халдвар (covid-19)-ын сэргийлэлт, хяналт ба эмнэл зүйн менежмент” сэдэвт сургалт хийлээ. Тус сургалтанд Covid-19 үед дайчлагдан ажиллах эмч болон салбар нэгжийн зохицуулагчид эмч, сувилагч нийт 75 эмнэлгийн ажилчид хамрагдлаа.

Сургалтанд хамрагдсан эмч ажилчдад 1 кредит цагийн гэрчилгээ олгов.

Сургалтын агуулга:

- Covid 19 тархвар зүй, дамжих зам
- Тусгаарлан сэргийлэлт
- Эрүүл мэндийн ажилтны эрүүл мэнд, хэрхэн өөрийгөө хамгаалах
- Гарын эрүүл ахуй, ариун цэвэр – Black box ашиглан дүгнэлт хийлээ.
- Хамгаалах хувцас хэрэглэл өмсөх болон тайлахыг бодитоор үзүүлэн, хамгаалах хувцас хэрэглэлийн ач холбогдлыг тайлбарлан таниулсан.



2020 оны 6 сарын 12-ны өдөр Нийслэлийн эрүүл мэндийн газраас зохион байгуулсан “Коронавируст халдвар (Covid 19)-ын халдварын сэргийлэлт, ба хяналт эмнэл зүйн менежмент” сэдэвт сургагч багшийн сургалтад тус төвийн 10 эмч хамрагдсан. Сургалтад хамрагдсан эмч нарт гарын авлага, сургалтын хичээлүүдийг олгосон.

Сургалтын агуулга:

- Бодлого эрх зүйн орчин, салбар дундын хамтын ажиллагаа, олон нийтийн оролцоо, хяналт үнэлгээ

- Халдварын сэргийлэлт хяналт, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар, эрүүл мэндийн ажилтныг хамгаалах нь
- Хувийн хамгаалах хувцас хэрэгслийн зөв хэрэглээ
- Гарын эрүүл ахуй
- Коронавируст халдварын үеийн эмнэлзүй болон оношилгоо
- Жирэмсэн төрөх үеийн эмчилгээ оношилгоо
- Хүүхдийн тусламж үйлчилгээ



Тус сургалтад хамрагдсан эмч нар цаашид төв болон салбар нэгжүүдийн эмч, эмнэлгийн ажилчдад сургалт зохион байгуулан мэдлэг, чадварыг нэмэгдүүлэн ажиллана.

2020 оны 04 сарын 28-ны өдөр НЭМГ болон Баянгол дүүргийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран зохион байгуулсан ЭМС-н А/188 тоот тушаалын дагуу зохион байгуулсан “Коронавирусын (Covid 19)-н халдварын үед хийх халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаа” сэдэвт сургалтанд хамрагдлаа.

Сургалтанд:

Тархвар судлаач Б.Сарантуяа, Мөнхбат, Амгаланбаатар нар хамрагдаж, сургалтын дагуу халдваргүйжүүлэлтийг үйл ажиллагаандаа хийж, ажиллалаа.

Covid19-н үеийн дотоодын сургалт:

- 2020.02.20 болон 21-ний өдрүүдэд “Хамгаалах хувцас, хэрэглэл өмсөх болон тайлах” талаар сургалт хийлээ. Тус сургалтанд Covid-19 үед дайчлагдан ажиллах, эмч ажилчид хамрагдлаа.

Сургалтаар :

- Гар угаах
- Бээлий өмсөх, тайлах
- Малгай өмсөх, тайлах
- Нэг удаагийн өмсгөл өмсөх
- Амны хаалт ( шүүлтүүртэй болон энгийн)
- Хамгаалах хувцас хэрэглэл өмсөх болон тайлах талаар теле-мэдээлэл хийж, хамгаалах хувцас хэрэглэлийн ач холбогдлыг тайлбарлан таниулсан.



- Коронавируст халдварын үед ажиллах багийн бэлэн байдлыг хангах, мэргэжил арга зүйн дэмжлэгээр хангаж ажиллах зорилгоор 2020 оны 3 дугаар сард дараах 2 сэдвээр сургалт зохион байгууллаа.

Хичээлийн сэдэв

I.Covid 19 – Халдварын Сэргийлэлт Хяналт

II.Covid 19 үед хийх халдваргүйтгэлийн үйл ажиллагаа





Сургалтанд нийт 125 эмч ажилчид хамрагдлаа. Төвийн автобааз дээр дээрхи сургалтын 2020 оны 3 сарын 26; 27; 31-ний өдрүүдэд хийж, 3 ээлжийн жолооч нарыг хамрууллаа. Сургалтанд 3 ээлжийн нийт 87 жолооч хамрагдлаа.


- 2020 оны 10 сараас эхлэн ажилчдын гар хэрхэн зөв халдваргүйжүүлэх болон хамгаалах хувцас хэрэгсэл өмсөх тайлах дарааллыг зөв хийж байгаад сургалтын ажилтан Б.Эрхэмболд дотоодын хяналт үнэлгээг хийж, зөвлөгөө зөвлөмжөөр ханган ажиллаж байна. Мөн усны гутал, нүдний шилийг хэрхэн халдваргүйжүүлэх талаар зөвлөгөө зөвлөмж өгч ажиллаж байна.



Covid 19 вирустэй холбоотойгоор шинээр гарч буй тушаал, шийдвэр, удирдамж, заавар, мэдээ мэдээлэл, бүх төрлийн зөвлөмжийг байгууллагын сайт (<http://103.ub.gov.mn/>) болон facebook хуудсанд (Нийслэлийн Түргэн Тусламжийн Төв) тогтмол байршуулж, ард иргэдийг цахим мэдээ, мэдээллээр ханган ажиллаж байна.

5. Ажлын байрны халдвар хамгаалал, аюулгүй ажиллагааны байдлыг хянах, заавар зөвлөмжөөр хангах зорилгоор :

Ажлын байрны халдвар хамгаалал, аюулгүй ажиллагааны байдлыг хангаж ажиллах зорилгоор “Гар угаах 5 мөч” болон “Гар угаах болон халдваргүйжүүлэх” тухай ЭМЯ болон ДЭМБ-аас гаргасан зөвлөмж мэдээллийг төв болон бүх салбарын угаалтуурт нэгдсэн журмаар гарган жигдрүүлэн байршуулав. Мөн гар халдваргүйжүүлэгч тогтоогч нэмэлтээр нийт 35 ширхэгийг шинээр салбар нэгжүүдэд суурилуулсан.



ЭМС-н “Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах заавар батлах тухай” 505 тоот тушаалын хэрэгжилтийг хангаж, хог хаягдлын тэмдэг тэмдэглэгээг байршуулан, ангилан ялгалтыг зөв хийж ажиллаж байна. Төв болон салбар нэгжийн хэмжээнд хог хаягдлын тэмдэг тэмдэглэгээг хар 100 ш, улаан 20 ш, шар 45 ширхэгийг шинээр хийж, хог хаягдлын тэмдэг тэмдэглэгээг байршуулан, ангилан ялгалтыг зөв хийж, тушаалын биелэлтийг ханган ажиллаж байна.




Хувийн хамгаалах хувцас хэрэглэл өмсөх болон тайлах дараалал бүхий самбарыг шинээр хийлгэж, бүх салбар нэгжүүдэд байршуулсан. Тус самбарыг салбар нэгжүүд өөрсдийн үйл ажиллагаандаа тогтмол ашиглаж, мэдээ мэдээлэл авч ажиллаж байна. Мөн хамгааах хувцас хэрэглэлийг зөв өмсөж, тайлж буйг хянах хяналтын хуудсыг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

6. Шавж мэрэгчгүйтгэлийг мэргэжлийн байгууллагаар гэрээний дагуу хийж гүйцэтгүүлэх:

Ариутгал халдваргүйтгэлийн “САН ХИМИ ” ХХК нь төвийн болон 5 салбарын нийт 6965 м2 талбайд гаргасан хуваарийн дагуу ариутгал хардваргүйтгэлийг 2020 оны 2 дугаар сарын 22 болон 23-ны өдрүүдэд бүх түргэн тусламжийн төвүүдийн нийт 6965 м2 талбайд клорсепт 0,03% уусмалаар агаарт шүрших байдлаар ариутгал ариутгал халдваргүйтгэлийг хийж гүйцэтгэсэн болно.

Ариутгал халдваргүйтгэлийн “САН ХИМИ” ХХК нь Covid 19 хардвараас сэргийлэх арга хэмжээний энэ үед сар бүр нийгмийн хариуцлагын хүрээнд хардваргүйтгэл хийхээр харилцан тохиролцсоны дагуу төвийн болон 5 салбарын нийт 6185 м2 талбайд гаргасан хуваарийн дагуу ариутгал хардваргүйтгэлийг 2020 оны 3 дугаар сарын 14 болон 15-ны өдрүүдэд бүх түргэн тусламжийн төвүүдийн нийт 6185 м2 талбайд клорсепт 0,03% уусмалаар агаарт шүрших байдлаар халдваргүйтгэлийг хийж гүйцэтгэсэн болно.



Ариутгал халдваргүйтгэлийн “БААТАР ВАН ” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 2020 оны 4 сарын 29 –ний өдөр мэрэгч устгалыг бромадиолон бодисоор, шавж устгалыг лямбда-цигалотрин бодисоор төв болон бусад салбар нэгжүүдэд шавж болон мэрэгч устгалыг хийж гүйцэтгэсэн болно.

7. Ариутгал, халдваргүйтгэлд хэрэглэгдэж буй бодисын чанар, хэрэглээнд хяналт тавих:

Улсын бүртгэлд бүртгэгдсэн, дүгнэлттэй чанарын шаардлага хангасан халдваргүйтгэлийн бодисыг “Гүн тэнгэрийн наран” ХХК, болон “Medclean” ХХК -тай харилцан тохиролцон хийсэн гэрээний дагуу захиалан авч үйлдвэрлэгчийн зааврын дагуу хэрэглэдэг. Эмнэлэгт ашиглагдаж буй ариутгал, халдваргүйтгэлийн бодисын хадгалалт болон хугацаанд тогтмол хяналт тавьж ажиллаж байна.

Ариутгалын үйл ажиллагаандаа физик, хими, биологийн индикаторуудыг ашиглан дотоод хяналтыг тогтмол хийж ажилладаг. Мөн уурын автоклавд зориулсан 4 болон 6 зэрэглэлийн индикатороор хяналт хийдэг. Ариутгалд ашиглаж буй автоклавдаа биологийн индикатор ашиглан хөндлөнгийн хяналтыг хийж, Medclean ХХК-аар дүгнэлт гаргуулсан.

Байгууллагын ариутгалын бодисын болон нэг удаагийн хамгаалах хувцас хэрэглэл, амны хаалт, бээлий, гар халдваргүйжүүлэлтийн бодис бусад шаардлагатай зүйлсийн нөөцийн судалгааг сар бүр тогтмол нэгтгэн гаргаж, Covid 19 одоогийн нөхцөл байдалтай уялдуулан шаардлагатай зүйлсийн нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна.

8. Нийт ажилчдыг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах, дархлаажуулалтанд хамруулах, эрүүлжүүлэх арга хэмжээг авах:

Төвийн ажилчдыг гепатит В вирусийн эсрэг дархлаажуулалтанд хамруулах ажлыг хуваарь гарган зохион байгуулж, 2020 оны байдлаар төвийн нийт 112 эмч, эмнэлгийн ажилтанг ГВВ-н 3 тунгийн дархлаажуулалтанд хамруулан ажиллалаа.



Нийслэлийн Эрүүл мэндийн газраас 2020 оны 4 дүгээр сард хандиваар өгсөн витамин Е, витамин В комплекс, төмрийн бэлдмэлийг эмнэлгийн эмч, ажилчдын дархлааг сайжруулах зорилгоор тэгш хүртээмжтэй хувиарлан өглөө.


Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, ажилчдын дархлааг дэмжих зорилгоор ҮЭ-ээс төвийн нийт ажилчиддаа зориулан Ундевит витамин, амны хаалт болон дархлаа сайжруулагч цэнэг бүтээгдэхүүнүүдийг өгсөн.



Сүхбаатар Дүүргийн Эрүүл Мэндийн төвтэй хамтран 2020 оны 07 сарын 06-аас 07-ны өдрүүдэд 130 их эмч эмнэлгийн ажилчдыг, 07 дугаар сарын 21 өдрөөс 07 дугаар сарын 23-ны өдрүүдэд 112 эмч эмнэлгийн ажилчдаа тарваган тахлын нэмэлт дархлаажуулалтад хамруулсан. 2020 оны байдлаар нийт 242 эмнэлгийн эмч ажилчдаа уг дархлаажуулалтад хамруулсан байна. Дархлаажуулалтанд хамрагдсан ажилчдаас дархлаажуулалтын дараах урвал хүндрэл илрээгүй болно.



Төвийн ажилчдыг томуугийн дархлаажуулалтанд хамруулах ажлыг зохион байгуулж, нийт 360 ажилчдыг томуугийн дархлаажуулалтанд хамруулсан болно. Дархлаажуулалтыг хийхдээ 2020 оны 10 сарын 05 болон 06-ны өдрүүдэд 290 хүн тунг, 2020 оны 10 сарын 09-ний шинээр орсон болон дадлагажигч эмч, өмнөх дархлаажуулалтаас үлдсэн эмч 70 их эмч, ажилтныг тус тус хамруулсан болно. Нийт вакцинд хамрагдсан ажилчдад дархлаажуулалтын дараах хариу урвал илрээгүй. Дархлаажуулалтын хамрагдалтын мэдээ тайланг ХӨСҮТ-н дархлаажуулалтын алба болон томуугийн тандалт судалгааны албанд мэдээлсэн болно.



Ажилчдын эрүүл мэнд дархлааг сайжруулах зорилгоор халуун чацаргана аарцыг тэгш хүртээмжтэйгээр хуваарлан, витаминжуулалтыг хийж ажиллаж байна.

Мөн 2020 оны 11 сарын 13- ны өдөр байгууллагын үйлдвэрчний эвлэлийн хорооноос ажилчдын дархлааг дэмжин эрүүлжүүлэх зорилгоор Салимон болон Ревит витаминьг төвийн нийт ажилтан албан хаагчид олгосон.



2020 оны 11 сарын 23-ны өдрөөс 12 сарын 04-ний хооронд төвийнхөө нийт 442 ажилтан албан хаагчдаас PCR болон түргэвчилсэн оношлуураар шинжилгээ авч, сорьцыг ХӨСҮТ-н лабораторит шинжлүүлсэн. Ажилчдын шинжилгээг 2 баг гарган салбар нэгжүүдэд очиж, халдвар хамгааллын дэглэмийг сахин, заавар зөвлөмжийн дагуу шинжилгээг авч ажиллалаа. Ажилчдаас авсан PCR болон түргэвчилсэн оношлуураар авсан шинжилгээний хариу бүгд сөрөг гарсан байна

9. Халдвар хяналтын чиглэлээр байгууллагын ажиллагсдад ажлын байран дээрх байнгын сургалтыг тасралтгүй зохион байгуулах:

- 2020.03.12-ны өдөр халдвар судлаач Б.Сарантуяа “Эрүүл мэндийн байгууллагын цэвэрлэгээ үйлчилгээ” сэдвээр төвийн болон салбарын үйлчлэгч, угаагч, гал тогооны ажигчдад online-цахим сургалт явууллаа. Сургалтаар доорхи сэдвүүдийн хамрууллаа. Үүнд:

- Цэвэрлэгээний ерөнхий зарчим
- Халдварын эрсдлийн бүс, бүсийн ангилал
- Халдваргүйжүүлэх ажлын уусмал хэрхэн найруулан бэлтгэх зааварчилгаа



- 2020 оны 4 сарын 20; 21; 22-ны өдрүүдэд халдвар судлаач Б.Сарантуяа төв салбарт танхимын бусад салбар нэгжүүдэд цахим хэлбэрээр “Хачигт халдвар” сэдэвт сургалтыг амжилттай зохион байгуулан явууллаа. Сургалтанд нийт 168 эмч, ажилчид хамрагдлаа.

Сургалтын агуулга:

- Хачигт халдвар гэж юу вэ?
- Хачигт халдварын тархвар зүй
- Ангилал, оношийн код
- Хачгийг биеэс хэрхэн салгах
- Урьдчилан сэргийлэлт
- Дархлаажуулалт

- “Дэлхийн гарын эрүүл ахуй өдөр”-г тохиолдуулан халдвар судлаач Б.Сарантуяа 2020 оны 5-р сарын 4; 5; 6-ны өдрүүдэд “Гарын эрүүл ахуй, ариун цэвэр” сэдэвт сургалтыг танхимын болон цахим хэлбэрээр амжилттай зохион байгуулан явууллаа. Сургалтанд нийт 154 эмч, ажилчид хамрагдлаа. Сургалтын агуулга:


- Дагаж мөрдөгдөх журам, дүрэм, шалгуур хуудас
- Гар халдваргүйжүүлэлтийн түүх
- Бохир гараар дамжих халдвар, сонирхолтой тоо таримт
- Хяналтын хуудсанд гарын эрүүл ахуйн үзүүлэлтийг хэрхэн дүгнэдэг
- Гарын ариун цэвэр сахих 5 мөч, цэвэр гарын ач холбогдол



- ЭМС-ийн №А/505 тоот тушаал “Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах заавар батлах тухай” дагуу эмнэлгийн нийт эмч, ажилчдад мэдлэг олгох сургалтыг тархвар судлаач Б.Сарантуяа 2020 оны 6 сарын 23; 25; 26-ны өдрүүдэд төвийн болон бусад салбар нэгждээ танхимын болон цахим хэлбэрээр зохион байгуулан явуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Сургалтын агуулга:

- Хууль эрх зүйн орчин
  - Хог хаягдлын төрөл, ангилан ялгалт
  - Хог хаягдлын тэмдэг, тэмдэглэгээ
  - Хог хаягдлын цэг болон байр түүний ялгаа
  - Цаашид анхаарах зүйл
- 2020 оны 7 дугаар сарын 8 болон 9-ний өдрүүдэд Зоонозын өвчин судлалын үндэсний төвтэй хамтран нийт эмч нартаа “Тарваган тахал өвчний тархвар судлал, хариу арга хэмжээ” “Тарваган тахал өвчний эмнэлзүй, оношилгоо, эмчилгээ” сэдэвт сургалтыг танхим болон цахим хосолсон хэлбэрээр 2 удаа амжилттай зохион байгууллаа. Сургалтыг ЗӨСҮТ-ийн тархвар судлагч Л.Роломжав, эмнэл зүйч эмч Б.Дэлгэрмаа заалаа.



- Хоол хүнсээр дамжих халдвар, хоолны хордлогын дэгдэлт, халдварын сэжигтэй тохиолдол гарч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2020 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Халдварт Өвчин Судлалын Үндэсний төвтэй хамтран “Суулгалт өвчнүүдийн ялган оношлогоо”, “Цусан суулга” сэдэвт сургалтыг танхим болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгууллаа. Тус сургалтанд тус төвийн 5 салбарын эмч ажилчид хамрагдлаа. Сургалтыг ХӨСҮТ-н эмч Б.Бурмаа заалаа.

Тус сургалтаар

- Сальмонелоз
- Цусан суулга
- Урвах тахал
- Хоолны хордлого
- Эшерихиоз
- Ротавирусын халдвар
- Гэдэсний иерсиниоз
- Балнад



зэрэг суулгалт бүхий өвчнүүдийн эхэн болон ид үед илрэх шинж тэмдэг, суулгалтын онцлог баасны байдал, өнгөөр хэрхэн ялган оношлох, тархвар зүйн асуумжийг хэрхэн асууж тэмдэглэх, эмчилгээг хэрхэн зөвлөх талаар дэлгэрэнгүй мэдээлэл өглөө.

2020 оны 10 сарын 12;13;14-ний өдрүүдэд “Амьсгалсын замын цочмог вируссын халдвар” сэдэвт сургалтыг танхим болон цахим хосолсон хэлбэрээр төвийн болон бусад салбарын их эмч, эмнэлгийн ажилчиддаа зохион байгууллаа. Сургалтыг АУ-ны магистр, Клиникийн профессор, Тэргүүлэх зэргийн эмч Ц.Батцэнгэл заалаа. Тус томуугийн сургалтанд нийт 110 их эмч, сувилагчид хамрагдлаа

г/.**Нийслэлийн Түргэн тусламжийн төв нь ажилчид болон иргэдээс ирсэн өргөдөл**

Албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлын шийдвэрлэлт.

- 2020 онд Засгийн газрын 11-11-аас 339, 1800-1200 оператораас 26, утсаар, биеэр 32, болон дээд байгууллагаас эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой өргөдөл, талархал, гомдол, санал, хүсэлт нийт 416 ирсэн байна.

Гомдол өмнөх оноос нэмэгдсэн нь 2019 онд ирсэн гомдлын зарим тохиолдлыг дотоод хяналтад оруулсантай холбоотой.

Ирсэн талархлыг бүртгэн, байгууллагын цахим сайтад байршуулан алдаршуулсан. Хүсэлт, гомдлыг судалж шалгаж, үзсэний дараа, ар гэр болон гомдол гаргагчтай утсаар, биеэр харилцан ярилцаж, зөвлөгөө зөвлөмж болон мэдээлэл солилцож гомдол, хүсэлт 100% эергээр шийдэгдсэн.

Төрлөөр нь:

- Гомдол-47 (11.2%)
- Талархал-363 (87.2%)
- Хүсэлт -5 (1.2%)
- Санал-1 (0.24%)

Алдаа, тохиолдлын нэр, чиглэл:

- Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой алдаа, стандарт удирдамж хангаагүй, тохиолдол-21
- Хариуцлага, сахилга, ёс зүй, харилцаа, хандлагатэй холбоотой-19
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний дагуу ажилласан-7

1. Гомдлын дагуу хэрэгжүүлсэн ажил:

- Хурлаар протоколоор сануулсан-30
- Удирдлагын зөвлөлийн хурлаар оруулсан-3
- Эмч нарын ярианд анхааруулсан- 94 удаа

Гомдлын шалтгаанд дүн шинжилгээ хийж, шинээр санаачилж хийсэн ажлууд:

Ирсэн гомдол саналыг шалгаж хянан, мэдлэг мэргэжлээ дээшлүүлэх, хурлаар сануулах, удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэх зэрэг арга хэмжээг авсан.

- Ёс зүй, харьцаа хандлагыг сайжруулахаар Баянзүрх салбараас 2 удаагийн 1 цагийн цахим сургалтыг давхардсан тоогоор 99 эмч сувилагч нарт зохион явуулсан.
- Хүүхдийн тусламж үйлчилгээг сайжруулах 2 сарын аян зохиосон
- “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй төлөвшил, хариуцлагыг сайжруулья” 3 сарын аян зохиож шилжин явах цом аялуулсан.
- Шинээр ажилд орсон 59 эмч нарт амилуулах суурь тусламжийн сургалт явуулж, түгээмэл үйлдлийн стандарт, жор бичилт, тоног төхөөрөмж, ХӨЦМ, хүүхдийн эрэмбэлэн ангилалт яаралтай тусламж болон насанд хүрэгчдийн өвчлөлийн эмнэл зүйн тохиолдлуудаар 2-3 дахин давтан шалгалт авч ажилд оруулсан.
- Харин талархлыг 387 эмч, 19 сувилагч, 321 жолоочид түргэн шуурхай ирж тусламж үзүүлж, эмнэлэг хүргэсэнд, үйлчлүүлэгчийн амь насыг аварсанд, угаарын хийн хордлогын үед цаг алдалгүй тусламж үзүүлсэнд, гэрт нь хүндрэлгүй эх барьж авсанд, зөвлөн тусалсан зэрэгт талархсан талархлууд байна.
- Харин эмнэлэг үйлчилгээнд 2019 онд 149 талархал ирсэн бол 2020 оны мөн үед 363болж 2.5 дахин өссөн сайн үзүүлэлттэй, ололт амжилттай ажиллаж байна.

## 9.1.5. ТАВДУГААР БҮЛЭГ - БУСАД МЭДЭЭЛЭЛ: ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГУУДАЙ ХАМТРАН АЖИЛСАН ТАЛААР:



Байгууллагын цахим хуудасны мэдээ мэдээллийг шинэчлэх байгууллагын А/50 журмын дагуу тухайн цаг үеийн шаардлагад нийцсэн, шинэ мэдээллийг нийтэлж ажилласан. Мэдээллийн бичгийн алдаа, найруулгыг шалгаж оруулдаг ба Arial фонттой, юникодоор хөрвүүлэн, үсгийн хэмжээг 10 болгож цахим хуудасны стандартын дагуу оруулдаг.

Цахим хуудсанд байх шаардлагатай мэдээ мэдээлэл стандарт, шалгуур үзүүлэлтийн дагуу багтсан. Байгууллагын ил тод байдлын мэдээ мэдээлэл, иргэд үйлчлүүлэгчдэд хандсан нийгмийн эрүүл мэндийн мэдээ, мэдээлэл, байгууллагын дотоодод болж буй мэдээлэл, чанарын булан, гадаад харилцаа, дуудлагын статистик мэдээлэл, сургалт сурталчилгаа, эрүүл мэнд, анхан шатны тусламжийн зөвлөгөө, сэрэмжлүүлэг, хууль эрх зүйн зөвлөмж бичих болон байгууллага, үйл ажиллагаагаа сурталчлах зорилгоор өөрийн байгууллагын танилцуулга, бүтэц зохион байгуулалт, үүсэл хөгжил гэх мэт мэдээ мэдээллээр баяжуулан ажиллаж байна.



Цахим хуудсанд COVID-19-ийн цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой “COVID-19 – Коронавирусээс урьдчилан сэргийлцгээе” булан нээж, тус буланд

мэдээ, мэдээлэл, зөвлөмж зөвлөгөө байршуулан ажиллаж байна. Мөн цахим хуудсаар дамжуулан 36 удаагийн давтамжтай амны хаалт зүүх, гарын ариун цэвэр сахиж, бусад эрүүл мэндийн зөвлөгөө хүргэсэн.

**Цахим хуудасны хандалтын тоо:** 2020 оны жилийн эцэсийн байдлаар 426932 зочин хандсан байна. 2019 онд 350652 байсан. Өмнөх онтой харьцуулбал 17,8%-иар хандалтын тоо өссөн байна.

Цахим хуудасны хандалтыг ихэсгэх зорилгоор шинэ мэдээ мэдээллийг тогтмол оруулж байх, мөн байгууллагын фейсбүүк хуудсаар дамжуулан мэдээлж байна.

- Байгууллагын Facebook хуудсаар нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл, байгууллагын мэдээлэл, статистик мэдээлэл, зөвлөгөө, талархал, олон нийтийн ажил гэх мэт мэдээлэл оруулан ажиллаж байна.

Одоогийн байдлаар 15776 Like хүрсэн байна.

Байгууллагын цахим хуудсыг иргэдэд сурталчлах зорилгоор дуудлагын эмч нарт тараах материал боршур зэргийг өгч дуудлага өгсөн айлд өгсөн. Мөн Facebook-ээр мэдээ мэдээлэл байршуулан сурталчилж ажилласан. Facebook-т сүүлийн үед их хандалттай байгаа Mr.Do пэйжийнадминтай хамтарч “Түргэн



тусламжийн автомашинд зам тавьж өгцгөө” сэдэвт видео шторк хамтран хийж маш олон хүний хандалт авсан.

- Цагаан сарын үеэр хордлого, гэмтэл, түлэгдэлтийн чиглэлээр сэрэмжлүүлэг сэдвээр Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга С.Ариунболд C1, NTV, UBS, Эх орон тус тус ярилцлага зөвлөгөө өгсөн.
- “Томуу, томуу төст өвчний халдвараас сэргийлье” зөвлөмж болон томуу, томуу төст өвчний үед ажилласан тухай мэдээллийг тогтмол хүргэхмэдээллийг ХӨСҮТ-д [Eop@nccd.gov.mn](mailto:Eop@nccd.gov.mn) болон MJL-радио мэдээлэл чанарын албанаас тогтмол өгч ажилласан.
- MGL-Дэлхийн Монгол радиод “Гамшгийн бэлэн байдлыг хангах үүргэвчинд байх хүн нэг бүрийн бүрдэл”, “Чихрийн шижин өвчнөөс урьдчилан сэргийлэх”, “Хачигт халдвараас сэргийлье”, “Бөөрний архаг үрэвсэл үүсэх шалтгаан, хүүхдийн живхний хэрэглээ”, “Өсвөр насны охидын жирэмслэлт, БЗХӨ-ийн хор уршиг”, “Өсвөр насны охидын жирэмслэлт, БЗХӨ-ийн хор уршиг”, Тархины цус харвалт түүнээс сэргийлэх, хүүхдийн дуудлагын авахгүй байгаа талаар иргэний тавьсан асуултад эрэмбэлэн ангилах, түүнд үзүүлэх тусламж”, “Тамхины хор уршиг”, “Хоолны хордлого, түүнээс сэргийлэх”, “Наршилтаас урьдчилан сэргийлэх”, “Гэдэсний халдвараас сэргийлэх”, “Үер усны аюулаас сэргийлэх”, “Сурагчдын зуны урт хугацааны амралт эхэлсэнтэй холбоотой хүүхдээ анхаарах”, зэрэг сэдвүүдээр тус төвийн хүүхдийн чанарын менежер З.Энхцэцэг, “Архи тамхины хэрэглээ, түүний хор уршиг сэдвээр байгууллагын эмч А.Нарантуяа, “Зүрхний шигдээс өвчний талаар” чанарын менежер М.Цэрэнчимэд нар нийт 13 удаа мэдээлэл хүргэсэн.



- Угаарын хийн хордлоготой холбоотой мэдээллийг тухай бүрт нь “viber”-р мэдээлж ажилласан.
- НЭМГазартай хамтран “Угаарын хийн хордлогын үед авах арга хэмжээний зөвлөмж”-г боловсруулж холбогдох албад, нэгжүүдэд хүргэн, TV5, C1, ROYAL TV-р иргэдэд угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх зөвлөмжийг өгсөн.

Тус төвийн их эмч Э.Одгэрэл, жолооч Т.Гүнтэвсүрэн нар ажил үүргээ гүйцэтгэх хугацаандаа гал түймрийн аюулаас 7 хүний амь насыг аварч үүнтэй холбоотой гал түймрийн аюулаас сэргийлэх, бага насны хүүхдүүдийг хараа хяналтгүй орхихгүй байх талаарх мэдээллийг TV5, C1, TV9, MNB, ROYAL TV болон бусад мэдээллийн хэрэгслүүдээр цацаж иргэдэд хүргэсэн.

Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга С.Ариунболд [eguug.mn](http://eguug.mn) сайтад Угаарын хийн хордлого сэдвээр мэдээлэл хийв.



## САНХҮҮ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ:

Одоо 2020 оны төсөв 9,547.5 таяу төгрөгөөр батлагдан зориулалтын дагуу доорх зардлуудад хуваарилагдан зарцуулав.

Эрүүл мэндийн тухай хуулиар эмнэлгийн яаралтай болон түргэн тусламжийг МУ-ын иргэнд төр хариуцах болсон тул үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө тусгагдаагүй 100 хувь улсын төвлөрсөн төсвөөс санхүүжиж байна. Үүнд:

Байгууллагын үйл ажиллагааны онцлогоос шалтгаалж:

- Төсвийн зардалын цалин хөлс, өдий өдрийн нэмэгдэл, зардалын өөрчлөлт, нэг удаагийн тэтгэмж, төсвийн өндөр НДШ-д төсвийн 81.1 хувийг,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, харуул хамгаалалтын гэрээт ажлын зардалд 4.2 хувийг,
- Түлш шатахуун, аж ахуйн хангамж, интернэт шуудан холбоо, бичиг хэрэг, маягт хэвлэлт, хог тээвэрлэлт, ариутгал цэвэрлэгээнд 11.5 хувийг,
- Ажилчдын ажлын өвөл, зуны хувцас хийлгэхэд 0.3 хувийг,
- Эм, ороох боох материал, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур зэрэгт 1.8 хувийг,
- Эд хогшил, урсгал засвар, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс авахад 0.6 хувийг,
- Тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг хангах үзлэг, даатгал, татвар, бусад төлбөрт 0.6 хувийг эзэлж
- Эрүүл мэндийн ажилчдын ажлын үр дүнг урамшуулахаар төсөвт 185.5 сая төгрөгөөр өөрчлөлт орж нэмэгдсэн.

### БАТЛАГДСАН ТӨСВИЙН ХУВААРИЛАЛТ (сая төгрөгөөр, хувиар)



Батлагдсан төсөвт урамшууллын 10 хувийн нэмэгдэл нэмэгдсэнтэй холбогдуулан цалин, НД-ын шимтгэлийн зардалд өөрчлөлт орж 185.5 сая төгрөгөөр нэмэгдсэн.

ТӨСВИЙН ӨӨРЧЛӨЛТ	2020	2020.05.01	Өөрчлөлт
<b>Түргэн тусламжийн төв</b>	<b>9,361,968.9</b>	<b>9,547,515.7</b>	<b>185,546.8</b>
БАРАА, ЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,353,848.9	9,539,395.7	185,546.8
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	<b>6,643,849.2</b>	<b>6,807,326.7</b>	<b>163,477.5</b>
Индсэн цалин	3,509,557.5	3,429,557.5	-80,000.0
Нэмэгдэл	2,297,080.6	2,377,080.6	80,000.0
Унаа хоолны хөнгөлөлт	486,255.0	486,255.0	0.0
Урамшуулал	350,956.1	514,433.6	163,477.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	896,919.8	918,989.1	22,069.3
Бусад бараа, үйлчилгээний зардлууд	1,821,199.9	1,821,199.9	0.0
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖИЛЭХ ЭХ ИЙСВЭР</b>	<b>9,361,968.9</b>	<b>9,547,515.7</b>	<b>185,546.8</b>

2020 оны 11 сард зардлын бүлэг хоорондын зохицуулах саналыг төлөвлөн хүргүүлж өр төлбөр үүсэх магадлалтай, Ковид-19 цар тахлаас шалтгаалсан бэлэн байдлыг /эм, эмийн хэрэгсэл, шатахуун/ тасалдуулалгүй хангах төсвийн сахилга батыг сайжруулан ажиллахаар хүлээгдэж байна.

#### ➤ САНХҮҮГИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

1. “Шилэн дансны тухай” хууль, холбогдох журмын дагуу байгууллагын вэбсайт, самбарт мэдээллүүдийг ил тодоор мэдээлсэн.

Үүнд:

а/ Санхүүгийн ил тодын байдлын самбарыг байгууллагын угтах хэсэгт байршуулж, мөн байгууллагын веб сайтад мэдээлбэл зохих үндсэн мэдээллүүд болон нэмэлт мэдээллийг дараах байдлаар мэдээлж байна.

Батлагдсан төсөв 1 удаа, төсвийн өөрчлөлт 1 удаа

- Төсвийн сар бүрийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан – 12 удаа /зөвхөн самбарт/
- 2019 оны бүтэн жил санхүүгийн баланс, тайлан – 1 удаа
- Аудитын дүгнэлт иж бүрэн – 1 удаа
- Аудитын хэрэгжилтийн явцын тайлан -1 удаа
- Хөрөнгө оруулалтын тайлан – 2 удаа
- Бусад мэдээлэл санхүүгийн эх үүсвэрийг зардлын бүлэг хооронд өр төлбөр барагдуулахаар гаргасан санал шийдвэрлэсэн ажлуудыг нэмэгдүүлэн ил тодоор мэдээлэв.

б/ “Шилэн дансанд байршуулбал зохих тайлан, мэдээ, файлуудыг 170 мэдээллийг дараах байдлаар толилуулсан:

- Бүтэн жилээр өмнөх болон тухайн оны 12 тайлан, мэдээлэл оруулахаас 7-г PDF файл хэлбэрээр, 5-г зохих маягтаар 12 удаа
- Хагас жилээр тухайн оны 4 мэдээллийг зохих маягтаар 4 удаа
- Улирлаар өмнөх болон тухайн оны 1 мэдээллийг зохих маягтаар 4 удаа
- Сараар байршуулах өмнөх болон тухайн оны 3 мэдээллийг 36 удаа мэдээллийг зохих маягт, нэмэлт PDF хэлбэрээр
- Сараар мэдээлэх хэсэгт “Ковид-19” цар тахлын мөнгөн хандив, бараа материалын хандивын 2 тайлан 08 сард шинээр тайлагнахаар суугдан 1-7 сарын 14 удаа, 8-11 сарын 4 удаа нийт 18 мэдээлэл
- Тухай бүр тайлагнах өмнөх болон тухайн оны 8 мэдээллийг 96 удаа маягтаар болон холбогдох материалыг PDF хэлбэрээр хавсарган толилуулсан.

в/. Урсгал төсвийн хөрөнгөөр худалдан авах ажиллагааны тухай холбогдох хуулийн дагуу босго үнээс давсан худалдан авалтыг зохион байгуулах 6 төсөл, арга хэмжээг төлөвлөн худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөнд 2 төсөл, арга хэмжээг сар сардаа батлагдсан төсвийн хуваарийн дагуу шаардлагатай хэрэгцээгээр татан авалт хийхээр цуцлан өөрчлөлт оруулж [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим системээр 4 төсөл, арга хэмжээг нээлттэй, ил тодоор зарлан сонгон шалгаруулалтыг шат дараатайгаар зохион явуулсан.

Уг тендерт “Автомашинь шатах тослох материал, сэлбэг хэрэгсэл нийлүүлэх” 6 багцтай, “Ариутгал цэвэрлэгээ, хангамжийн материал”, “Харуул, хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх” гэсэн нийт 383.0 сая төгрөгийн 3 тендерийг нээлттэйгээр, “Автомашинь даатгалын үйлчилгээ” 18.0 сая төгрөгийн 1 тендерийг харьцуулалтын аргаар цахимаар шат дараалалтайгаар явуулж “Нормын хувцас, зөөлөн эдлэл”, “Багаж, техник хэрэгсэл, тохижилт” гэсэн 2 харьцуулалтын тендерийг тухай бүр сардаа шууд худалдан авалтаар зохион байгуулсан. Уг тендерийн үр дүнд төсөвт өртгөөс 16.3 сая төгрөгөөр багаар хэмнэлт, үр ашигтай гэрээ хийгдсэн.

# ᠨᠠᠭᠤᠯᠤᠰᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰᠤᠨ, ᠤᠷᠰᠠᠭᠠᠯᠯᠤᠰᠤᠰᠤᠨ

## 1. 2020 онд тавилга, эд хогшил

Огноо	Нэр	Н.Б.Үнэ	Х.Н	Тоо	Дүн	Худалдан авагч
2020.03.30	Тавиур	240.0	ш	5	1,200.0	Бөжэ ХХК
2020.04.15	Бичгийн төмөр шүүгээ-2020	470.0	ш	6	2,820.0	ХАШХАН ХХК
2020.12.02	Сандал /оффис/	99.0	ш	15	1,485.0	Солонго-Тамир ХХК
<b>ДҮН</b>					<b>5,505.0</b>	


## 2. Тоног төхөөрөмж

№	Тоног төхөөрөмж төрөл	Тоног төхөөрөмжийн нэр	Марк загвар	Тоо хэмжээ	Нэгж үнэ /төгрөг/	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр		Ашиглалтад хүлээн авсан огноо
						Улсын төсөв	Хандив тусламж	
1.3.1	Сэхээ амьдрүүлэх, яаралтай тусламж, эрчимт эмчилгээ	Дифеблятор	Defi monitor	1	36,000.0		36,000.0	2020-05-27
1.3.2		Хяналтын монитор	Dott Medical	1	2,500.0		2,500.0	2020-05-27
1.3.3		Амьсгалын аппарат	Ambulanc/shenzhen/	1	7,500.0		7,500.0	2020-05-27
1.3.4		Зүрхний бичлэгийн аппарат	Shanghai	1	2,500.0		2,500.0	2020-05-27
1.3.5		Туслах багаж хэрэгсэл /7ш/ багц		1	4,380.0		4,380.0	2020-05-27
1.15.1	Бусад	Сөрөг даралтат түргэн тусламжийн автомашин	Форд Транзит	1	124,366.0		124,366.0	2020-05-27
1.15.2		Түргэн тусламжийн автомашин	Камаз	1			Балансаас баланст	1905-06-25
1.15.3		Түргэн тусламжийн автомашин	Ниссан урбан	23			НЗД-ын захирамж гараагүй тул үнэлэх боломжгүй	2020-10-02
1.15.4		Олон төрлийн хий хэмжигч	Beijing	1	2,750.0		2,750.0	2020-03-23
1.15.5		Оксиметрийн багаж	Masimo	1	19,035.7		19,035.7	
1.15.6		Агаар дахь хорт хийн агууламж тодорхойлогч	Gastes Toxi	1	15,000.0		15,000.0	
1.15.7		Дугуй задлах аппарат	Дугуй задлах аппарат	1	3,300.0	3,300.0		2020.04.29
1.15.8		Сүлжээний рүтэр	D- Link	1	561.0	561.0		2020-09-02
1.15.9		Цахилгаан суурин хөрөө	380В	1	870.0	870.0		2020-10-23
1.15.10		Ариутгал хийх манангийн шүршигч аппарат	220В	1	1,300.0	1,300.0		2020-11-20
<b>ДҮН /Тоног төхөөрөмж 1.3+1.15/</b>						<b>6,031.0</b>	<b>214,031.7</b>	

## 3. 2020 онд батлагдсан урсгал төсөв, хандив тусламжийн хөрөнгөөр хийгдсэн засварын ажлуудыг 49.1 сая төгрөгөөр санхүүжүүлсэн :

1. Автобаазын интернетийг шилэн кабелийн шугмыг СБД-ийн 6 дугаар хорооны 31Б байрны дээвэр дээрээс 200 метр агаараар татсан. Уг холболтын нэг удаагийн ажилд 1,699.1 мянган төгрөг төсвөөс зарцуулж Ар Анд Түнш мэргэжлийн компаниар холбуулан төв болон салбар төвүүдтэй цахимаар шуурхай холбогдон ажиллах нөхцөлийг бүрдүүлж

жилд 330.0 мянган төгрөгийн тусдаа төлдөг төлбөрийн болон ажлын шуурхай бус алдагдлыг арилгаж ажлын бүтээмжийг нэмэгдүүлсэн.



2. Тус төвийн 4 барилга байгууламжуудын дээврээс 2016 оноос эхлэн цас бороо орох бүрд давхруудын өрөөнүүдийн таазнаас ус гоожиж, гадны гадаргуу ханын нуралт үүссэн, хана мөөгөнцөртөж барилгын чанарт болон ажиллагсдын эрүүл мэндэд муугаар нөлөөлж тэргүүлэх төсөвчинөөр нийт 415.9 сая төгрөгийн төсөвт зардлыг гаргуулан жил бүрийн төсвийн төлөвлөлтийн төслийн саналд үнийн өсөлтийн хувийг нэмэгдүүлэн тусган хүргүүлсэн.

Дээврийн засвар хийгдэхгүйн улмаас үүсэж болох галын болон эрүүл ахуйн бусад эрсдлийг арилгах нэн тулгамдсан асуудлыг дотоод боломжоо ашиглан байгууллагын түүхт 90 жилийн ойн ажлын хүрээнд өөрсдийн ажилчдын санаачилгаар бүрдүүлсэн хандив, тусламжийн орлогуудаас 32,471.0 мянган төгрөгийн материалыг авч, уг ажлаар олон жил гүйцэтгэгчээр ажиллаж буй хувь хүнтэй хамтран ажиллаж засвар хийлгэсэн.

Салбар, төв	Төсөвт өртөг /сая.₮/ /дээврийн талбайн хэмжээ/	Засвар үйлчилгээ хийсэн өртөг /сая ₮/	Барилгын тухай хууль болон “Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага” MNS 6392:2013 стандартын хэрэгжилтийг хангаж ажиллах холбогдох дүгнэлтүүд
Авто бааз	259.3 /1670 м <sup>2</sup> /	19.7	НМХГ-ын 2018.07.04 ны өдрийн 02-07-092/862 “Барилгын дээврийн ашиглалт, төлөв байдлын тухай” дүгнэлт
Сонгино хайрхан салбар	43.3 /288 м <sup>2</sup> /	3.5	НМХГ-ын 2017.01.18 ний өдрийн №02-03-287/19 тоот “Зөрчил арилгуулах тухай” албан шаардлага, 2019.07.02 ны №12-07-094/1013 “Барилгын дээврийн төлөв, байдлын тухай” дүгнэлт
Баянзүрх салбар	43.3 /288 м <sup>2</sup> /	3.7	НМХГ-ын 2019.07.26 ны өдрийн 02-07-395/1154 “Барилгын ашиглалтын төлөв байдлын тухай” дүгнэлт
Төв /103/	70.0 /482 м <sup>2</sup> /	5.5	Барилгын тухай хууль болон “Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага” MNS 6392:2013 стандартын хэрэгжилтийг хангуулах
<b>ДҮН</b>	<b>415.9 /2728 м<sup>2</sup>/</b>	<b>32.5</b>	

Төсөвт өртөгийн 7.8 хувь буюу 32.5 сая төгрөгөөр дээврийн засварын нийтдээ 2728 м2 талбайд бүхэлдээ барьцалдуудагчтай хар цаасыг битүү дэвсэн засварласан.

Уг зарцуулсан зардал нь 1/8 жилийн туршид ашиглалтад хүчинтэй байх бөгөөд ямар нэгэн нэмэгдэл зардлууд нэмж тусгагдаагүй.

**БАРИЛГУУДЫН ДЭЭВРИЙН ЗАСВАР ХИЙГДЭХЭЭС ӨМНӨХ БОЛОН ЗАСВАРЛАСНЫ  
ДАРААХ БАЙДЛЫН ЗУРАГ**

<b>ӨМНӨХ БАЙДАЛ</b>	<b>ДАРААХ БАЙДАЛ / ЗАСВАРЫН ЯВЦ</b>
<b>АВТОБААЗ</b>	
  	    
<b>СОНГИНОХАЙРХАН САЛБАР</b>	
 	 



**БАЯНЗҮРХ САЛБАР**



**ТӨВ /103/**



3. Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/01 дугаар захирамжаар 2020 оныг “Нэг хот-Нэг стандарт” зорилтот жил болгон зарласан уг ажлын хүрээнд бүх 5 салбар, төвүүдийн гадна хаягийг мэргэжлийн байгууллагаар стандартын дагуу 1,089.0 мянган төгрөгөөр, шинээр ашиглалтад орсон Чингэлтэйн салбарын гадна дээд талд 1,699.5 мянган төгрөгөөр гэрлэн чимэглэлтэй лого нийт 2,788.5 мянган төгрөгөөр тус тус хийлгэж байршуулсан.



4. Ахуйн хог хаягдлыг эмх цэгцтэй, байгууллагын орчны өнгө үзэмж алдагдуулахгүй, бүх нийтийн эрүүл ахуйн шаардлагыг хангах үүднээс хогийн пункерыг өөрсдийн ажилчдын хүчээр Чингэлтэйн салбарт 592.0 мянган төгрөгийн, Хан-Уул салбарт 489.1 мянган төгрөгийн **нийт 1,072.1 мянган төгрөгийн** материал авч хийсэн.



5. Барилга, байгууламжийн өнгө үзэмжийг сэргээх, барилгын ашиглалтыг сайжруулах чиглэлээр:

- Төвийн дээврийн ус алдалтаас зарим өрөөнүүдийн тааз, хана халцарч муудсан тул дотор засалд 2,467.0 мянган төгрөгийн материал, 1,700.0 мянган төгрөгийн ажлын хөлс нийт 4,167.0 мянган төгрөг,





- Төвийн гадна хаалганы цас, бороонд норж гажилт үүссэн /солихоор үнэ судлахад 12.0 сая төгрөгийн үнийн судалгаа хийгдсэн тул төсөв хүрэхгүй засахаар шийдвэрлэсэн/ тул өөрсдийн ажилчдын хүчээр 698.4 мянган төгрөгийн мод, лак зэрэг материал авч засварласан,



- Авто баазын хашааны гадна, дотор тал, зам талбайн боржур, засварын цехийн ханыг өөрсдийн ажилчдаар 239.1 мянган төгрөгийн будаг, шохойны материал мөн ажилчдын чийрэгжүүлэлтийн өрөөний дотор засалд 526.0 мянган төгрөгийн гипсэн хавтан, эмульс авч засаж нийт 765.1 мянган төгрөгөөр өнгө үзэмжийг сэргээсэн,

Өмнө нь /Дээврээс ус алдсан/

Зассаны дараа /таазыг доошлуулав/



- Автобааз, Чингэлтэйн салбарын эмч, жолооч бусад ажилтаны хувцас угаалгын өрөөнд 371.5 мянган төгрөгөөр хатаагч хийх материал авч өөрийн ажилтанаар хийлгэсэн,
- Хан-Уул салбарын дээврийн хэсэг хуйларсан төмрийн урсгал засварт 295.0 мянган төгрөгөөр материал авч өөрсдийн ажилчдаар засварлуулсан, Дээрхи ажлуудад 6,297.0 мянган төгрөгийг батлагдсан урсгал болон бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлаас санхүүжүүлсэн.
- 6. Байгууллагын өвөлжилтийн бэлэн байдлыг хангах бэлтгэл ажлын хүрээнд инженерийн шугам сүлжээнд хийгдсэн ажлууд:
- Хан-Уул салбарын халаалтын бойлуурт халуун усны мотор 2 ээлжээр сэлгэн ажиллуулахаар 2\*350.0=700.0 м.₮, Баян-зүрх салбарт мөн адил мотор 1 ш 220.0 м.₮, 1ш 350.0 м.₮, узелийн автомат клапан 1ш 550.0 м.₮ нийт 1,820.0 мянган төгрөг,

- Бүх салбар төвүүд /ХУС, СХС, БЗС, ЧС, Автобааз, Төв-103/-ийн дулааны системийн холбох, хэмжих хэрэгсэл бусад эд ангиудыг шинэчилж солиход 1,024.5 мянган төгрөг, худгуудын таг, дулаалга хийхэд 271.2 мянган төгрөг нийт 1,295.7 мянган төгрөг,
- Төв барилгын гадна дулааны шугам 2020 оны 01 сард газрын гүнд хагарч хөлдүү газрыг хурдан шуурхай хугацаанд эксковатор хөлслөн ухаж шугмын труба, бусад засварын дагалдах материал авч ажлын хөлс нийтдээ 1,032.9 мянган төгрөгөөр засварласан,



- Автобазын засварын цехийн 00-ын ерөөний агааржуулалтын шугмыг шинээр 328.5 мянган төгрөгний хоолой, мотор, сэнс авч системийг шинэчилсэн,
- Чингэлтэй салбарын цахилгаан генератор /халаалт төвийн шугамд холбогдоогүй/-ын аккумулятор 2ш\*185.0=390.0 мянган төгрөгөөр авч өвөлжилтийн бэлэн байдлыг хангаж нийт 4,867.1 мянган төгрөгийг урсгал зардлаас санхүүжүүлсэн.

➤ ЦАГ ҮЕИЙН ШИНЖТЭЙ “КОВИД-19” ЦАР ТАХЛЫН ҮЕД:

- Урсгал төсвөөс доорхи шатахуун, халдваргүйтэл, хангамжийн материалыг төсвөөс 48,704.9 мянган төгрөгөнд бэлтгэсэн. Үүнд:
  1. Эмнэлгийн тусламжийн багийг бэлэн байдалд байлган ажиллуулж 2020.03.16-11.19 хооронд тусгай үүргийн онгоц, вагон тосч иргэдийг тээвэрлэхэд 1,523.4 литр 3,341.3 төгрөгийн шатахуун зарцуулсан.
  2. Ариутгал цэвэрлэгээ, халдвар хамгаалалд 13 нэр төрлийн 121191 тоо хэмжээтэй /гар ариутгагч гель 220ш, ариутгалын бодис жавилон 220 фл, нэг удаагийн комбинзон 86ш, нэг удаагийн малгай 35800ш, маскны сав 125ш, нүдний шил 66ш, нэг удаагийн маск 44000ш, N95 маск 600ш, даавуун маск 1500ш, порцын маск 50ш, бактер устгагчтай саван 50ш, тахлын хувцасны уут 71ш, санитол тогтоогч 41ш, нэг удаагийн улавч 38000ш, нэг удаагийн халат 50ш, хамгаалалтын уут /тоног төхөөрөмж/ 92ш/ 36,402.4 мянган төгрөгийн зардлыг төсвөөс бэлтгэсэн.
  3. Хурал, цуглааны арга хэмжээг салбар төвүүд онлайнаар зохион байгуулахад камер 6ш, микрофон 5ш, спикер 6ш, сүлжээ уртасгагч 6ш 762.7 мянган төгрөгийн техник зүйлс бэлтгэсэн.
  4. Байгууллагын гамшгийн төлөвлөгөөнд тусгагдсан хоол, хүнсний нөөцийг 11 нэр төрлөөр 6433 тоо хэмжээтэй 8,198.5 мянган төгрөгөнд орлогод тусган бэлэн байдлыг хангасан.
- Үнэ төлбөргүй ирсэн үнэлгээтэй болон үнэлгээгүй хөрөнгийг 67,766.8 мянган төгрөгөөр үнэлж доорхи байдлаар орлогод тусгав. Үүнд:
  1. Ковид-19 цар тахалд гаднаас үнэ төлбөргүйгээр 19 нэр төрлийн 48806 тоо ширхэгтэй нийт 63,406.8 мянган төгрөгийн /зарим үнэлгээгүй ирсэн хандивын зүйлсийг тухайн үеийн үнэ ханшаар үнэлэв/ хамгаалах хэрэгсэл, ариутгалын уусмал, бодис, витамин бэлдмэл, спирт денатурат, оношлуур, халуун хэмжигч, томуугийн вакцин зэрэг эм, эмнэлгийн хэрэгсэл, халдваргүйтлийг тайланд тусгав.

2. 2020.08.26 нд сөрөг даралтат түргэн тусламжийн төвийн атомшинд дагалдан 5 нэр төрлийн 6 ширхэг 4,360.0 мянган төгрөг /дамнуурга, зөөврийн кислородны баллон, редуктор, яаралтай тусламжийн цүнх/ -ийн үнэ төлбөргүй орлогод тусгав.

➤ АЖИЛЧДЫН НИЙГМИЙН АСУУДЛУУД, ÄÏÒÏÏÄÇÎÖËÍÁÄÈÃÓÓËÈÒ

1. Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх үдәәääàì òúìöúúí, ñííðò, áóñàä àúí, àðää òúíæúú, нуя òääääèéí òúòäúíæ, øääíàè, óðàìøóóèää, àõìää °íä°ð íàñòàìä çççèñýí òçíäúòäúéèéí çàðääè, àæèè÷äúí çð äçíäèéí óðàìøóóèääèúí çàðääèä

Үүнд:

✓ Õççòäèèä үдөөèä òàìääàèäò °ä°ðò ажилчдын 329 хүүхдэд 300 бэлэг Наран моль

компаниас үнэ төлбөргүй бэлэглэж 129 хүүхдэд бэлэг, бусад уралдаан тэмцээнүүдэд шагнал олгосон нийтдээ 5,624.4 йүган ò°äð°ä,

✓ Аõìää, °íä°ð íàñòàìäóóää 2 удаа 208-211 òçíäúòäúé çççèèх 38,840.0 йүгaa ò°äð°ä,

✓ Дээд байгууллагуудаас авсан 7 хүнд дагалдах шагналд 310.0 мянган төгрөг олгосон, 61 хүнд 3450.0 мянган төгрөг олгохоор нэг удаагийн урамшууллын төсөв хүлээгдсэн,

✓ Àæèè÷äää óèèðèúí àæèúí çð äçí, дээд байгууллагаас гарсан шийдвэрийн óðàìøóóèääèä 400-420 ажилчдад 376,995.3 йүгaa ò°äð°ä бодож олгосон ба 4 улирлын ажил дүгнэлтээр 137,438.3 мянган төгрөгийн урамшууллын төсвийн хүлээгдсэн гүйцэтгэлтэй нийт 514,433.6 мянган төгрөг,

✓ Нэг удаагийн болон цалинтай тэнцэх тэтгэмж 17 хүнд 10,476.4 мянган төгрөг,

✓ Өндөр настан 1 хүнд замын зардалд 84.0 мянган төгрөг, нийт 432,330.1 мянган төгрөгийг зарцуулсан.

2. Áäòìàøèúí ççèúä, ñíøèíäíí, даатгал, татварт òàìðóóèè ääòìàøèúí áúéúí àæèèèä áçðýí òàìääì àæèèèäv. Óä àæèèèä:

- тээврийн хэрэгслийн татварт 4,706.1 йүган ò°äð°ä,

- үзлэг оношилгоонд 2,508.0 мянган төгрөг,

- тээврийн хэрэгслийн даатгалд 21,823.7 мянган төгрөг, НИЙТ 29,037.8 мянган төгрөг зарцуулав.

3. Ажилчдын хоол, хүнсийг хөнгөлөлтийн талаар: 1 удаад материалын үнэ өртгөөр тооцон 2 порц хоолыг байгууллагаас 4500 төгрөгөөр олгож өдөр, орой 24 цагт ээлжийн ажилчдыг халуун хоол, ундаар тасалдуулалгүй хангасан.

4. Ажилчдын хувцас хангамж, зөөлөн эдлэл бэлтгэх талаар: Эмч, жолооч нарын ажлын өвлийн 68 ш, эмч жолоочийн зуны хувцас 47ш, Герман улсаас ирж ажиллах ажилтанд бэлтгэсэн хавар, намрын хувцас 13ш, тогооч нарын 13 хос хувцас, хормогч 2ш, тахлын хувцас 10 ш, засварын ажилчдын комбинзон 9ш, дотуур цамц 8ш, ханцуйвч 9ш, хамгаалалтын малгай 9 ш, хамгаалах хэрэгслүүд 9 хос, усны гутал 5, ажлын гутал 14ш,

аваарын цамц 2ш, бохирын хувцас 2ш, усны хувцас 1 хос нийт 19,972.5 мянган төгрөгөөр хийлгэсэн

➤ **ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТ:**

1. Нийслэл дэх Төрийн аудитын газраас хуваарилсан “Цэгц төв богд” аудитын 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар өгсөн 4 зөвлөмж, 1 албан шаардлагыг хэрэгжүүлэн явцын дүн дунджаар 90.1 хувьтай хэрэгжүүлж байна.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг “Нью Эстимэйтор Аудит” ХХК-тай зөвлөхийн үйлчилгээний гэрээгээр 2020.01.02-2020.04.13-ны хооронд хийж гүйцэтгүүлэн тус төвийн захирлын 2020.04.15-ны өдрийн А/21 дугаар тушаалаар 2020 оны тайлант хугацааны эхнээс мөрдөж ажиллахаар баталгаажуулсан.

3. 37 нэр төрлийн 150,166.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг цаашид ашиглахгүй гэж үзэн НӨАУГ-ын 2020.04.02 А/136, 2020.03.30 4/603, 2020.05.14 А/665 дугаар шийдвэрээр данс бүртгэлээс хассан.

4. Гамшгийн төлөвлөгөөнд тусгагдсан бэлэн байдлын хангамж, материалыг төсөвтөө зохицуулан татан авалтыг хийж санхүүгийн тайланд тусгав.

Төсвийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр жилийн эцэст үүсэж болох зардлуудыг зардлын бүлэг хоорондын зохицуулалтаар санал гарган шийдвэрлүүлэн өр төлбө

ргүй ажил лахаар төлөвлөж байна.	<b>Төхөөрөмжийн нэр</b>	<b>Тоо ширхэг</b>	<b>Нийт үнэ</b>
----------------------------------	-------------------------	-------------------	-----------------


**МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИ**

Нийслэлийн засаг даргын тамгын газар, нийслэлийн мэдээлэл технологийн газраас нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй ERP системийн сургалт явуулсан. Тус сургаалтанд хамрагдаж байгууллагын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж тусган ажилласан.

Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа эрүүл мэндийн байгууллагуудын “Хэвлэл мэдээллийн менежмент-5” хурал оролцлоо.



Байгууллагад ашиглагдаж байгаа нийт программ хангамж:



1. EMERGENCY INFORMATION NETWORK /EIN/ ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ДУУДЛАГА ХҮЛЭЭН АВАХ НЭГДСЭН СИСТЕМ

Уг системийг “Холбоо, хяналт, мэдээллийн нэгдсэн сүлжээ” төсөл хэрэгжсэнээр 2010 оноос нэвтрүүлэн ажиллаж байна. Мэдээлэл шуурхай удирдлагын төвтэй шилэн кабелиар холбогдон дуудлага дамжуулан ажилладаг.


2. PHARMACY - ЭМИЙН САНГИЙН БҮРТГЭЛИЙН ПРОГРАММ

Уг программыг Санхүүгийн тооцоолох групптэй хамтран нэвтрүүлсэн ба Төв, БЗД, СХД, ХУД-ийн салбаруудад тус тус нэвтрүүлж, эмийн орлого зарлага, зарцуулалтыг хянаж байна.



Вэб камер	6	
Сүлжээний замчлагч	5	
Чанга яригч, Микрофон	6/6	
Бусад техник хэрэгсэл	10	1,892,000
Интернэт зардал	11.783.100	
Телефон картын зардал	3.500.000	23,945,000


### 3. EDOC – АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН НЭГДСЭН ПРОГРАММ.



Энэхүү албан хэрэг хөтлөлтийн системийг байгууллагын удирдлага болон хариуцлагатай ажилчид ашиглаж байна. Захиргааны бүх ажилчдад тус системд нэвтрэх эрх нээсэн.

Алдаа, дутагдал: - Энэхүү системийн гар утасны хувилбар ажиллахгүй байх тохиолдол байна.

### 4. ERP – ННЗБ-УУДЫН ДОТООД УДИРДЛАГЫН СИСТЕМ.



Энэхүү цогц системийг байгууллагадаа нэвтрүүлэн, ажилчдад хэрэглэгчийн эрх үүсгэн ажиллаж байна.

2018.11.01-ний өдөр уг системийн сургалт болсон ба мэдээлэл технологийн инженер, хүний нөөцийн ажилтан, бичиг хэргийн ажилтан нар сургалтад суусан.

ERP системийн захиргааны албан хаагчийн бүртгэл:

### 5. ЦАХИМ ГАРЫН ҮСГИЙН “MONPASS” ПРОГРАММ




### 6. БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДАС ХӨГЖҮҮЛЭЛТИЙН “Joomla” НЭЭЛТТЭЙ ЭХИЙН ПРОГРАММ



Тус программыг ашиглан байгууллагын цахим хуудсыг бүтээсэн ба мэдээ мэдээллээр байршуулан ажиллаж байна

### 7. “ARCHIVE eDOC” – АРХИВЫН ПРОГРАММ



Байгууллагын албан хаагчдаас үүсч буй цахим баримтыг тус программд архивлан эмх цэгцтэй хадгалдаг ба өдөр тутам ашиглаж байна.

Нэрс	Албан тушаал
Акерке	Хүний нөөц, сургалтын албаны дарга
Алтанзагас	Хяналт шинжилгээ, үнэлгээний албаны дарга
Ариунболд	Дэд захирал
Баярсайхан	Статистикийн их эмч
Алтангэрэл	Мэдээллийн технологийн инженер
Мөнхцэцэг	Чанар, халдвар хамгааллын албаны дарга
Нарантуяа.А	Байгууллагын их эмч
Орхонсүрэн	Ерөнхий инженер
Отгонтэнгэр	Ахлах нягтлан
Оюунзул	Эмийн сангийн эрхлэгч
Оюунсүвд	Ашиглалтын инженер
Сарантуяа	Халдвар судлаач
Пүрэвдаш	Захирал
Танацэцэг	Сувилахуйн албаны дарга
Энхжаргал	Бичиг хэргийн ажилтан
Эрдэнэцэцэг	Архивын эрхлэгч
Эрхэмбаатар	Аж ахуйн албаны дарга

боломжтой дэд хэсгүүдээс бүрддэг программ юм.

### 8. “ACOLOUS” – НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ПРОГРАММ



Байгууллагын нягтлан бодогчид өдөр тутмын үйл ажиллагааны анхан шатны мэдээллийг бүртгэх, санхүүгийн мэдээ, тайлан гаргахад зориулагдсан, хамтдаа болон тус тусдаа бие даан ажиллах




## 9. “PAYROLL” – ЦАЛИНГИЙН ПРОГРАММ

## 10. ХЭВЛЭЛИЙН ЭХ БЭЛТГЭЛ, ЭВЛҮҮЛЭГ, БОЛОН БУСАД ХЭРЭГЛЭЭНИЙ ПРОГРАММ ХАНГАМЖУУДЫГ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД АШИГЛАЖ БАЙНА.

- Adobe Master Collection
- Microsoft Office 2010
- Windows Server, Linux server, Windows OS
- After Effect
- Navicat 12 for MySQL – серверийн үйл ажиллагааг хянах программ
- Kaspersky - Хорт кодын эсрэг программ
- Бусад м

## 11. “GPS” – АВТО МАШИНЫ ХЯНАЛТЫН ЦОГЦ СИСТЕМ

Нийслэлийн Засаг даргын А/88 дугаар захирамжийн дагуу нийслэлийн түргэн тусламжийн төвийн автомашинуудад хяналтын GPS систем нэвтрүүлэх зорилгоор Нийслэлийн эрүүл мэндийн газраас зарласан тендерт VanqTech ХХК сонгогдож нийт 75 сая төгрөгийн үнэтэй “GPS хяналтын цогц системийг” нэвтрүүллээ. Уг байршил тодорхойлох систем нь Google Map-ийн газрын зураг дээр харуулдаг ба E1N /Emergency Information Network/ программтай холбогдож ажилладаг.



Нийт 85 автомашинд “Meitrack T366” загварын хяналтын GPS суурилуулсан ба мэдээллийг үүрэн холбооны сүлжээгээр хяналтын сервер лүү дамжуулан төв болон салбаруудад хяналт тавин ажиллаж байна.

GPS программыг нэвтрүүлснээр дотоод хяналт сайжирч, жолоочийн тооцоо, эмнэлэг үйлчилгээнд үйлчлэх автомашинуудын шуурхай байдал нэмэгдсэн.


12. Мөн засвар үйлчилгээ хийлгэсэн дэлгэрэнгүй тайлан, автомашины хувийн хэрэгт хөтлөгдөх жолоочийн авсан шатахуун, явсан км, үйлчилсэн дуудлагын тоо, хийгдсэн бүхий л засвар үйлчилгээнүүд зэрэг жолооч болон автомашины дэлгэрэнгүй бүртгэлийг хялбараар гаргах боломжтой болсон юм.
13. 2 удаагийн сургалт зохион байгуулж байгууллагын эмч ажилчдыг хамруулсан. Мөн тухай бүрд ажилчдад ажлын байран дахь заавар, зөвлөгөө, сургалт болон эмч нарт карт бичилтийн программд сургалт хийж байна. Мөн байгууллагын хэмжээнд COVID-19-тэй холбоотойгоор бүх сургалтыг онлайн хэлбэрээр хийж байна.
14. Дотоод, гадаад сүлжээний тасралтгүй байдал:

Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн бүх салбар, төв, авто бааз нэгдсэн нэг шилэн кабелийн сүлжээнд холбогдсон. Ингэснээр мэдээллийн аюулгүй байдал, нэгдсэн дотоод

сүлжээгээр мэдээ мэдээлэл солилцох, хурал сургалт зохион байгуулах, мэдээллийн урсгал сайжирсан.



## НИЙСЛЭЛИЙН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ТӨВ СҮЛЖЭЭНИЙ ЗУРАГЛАЛ



- НТТТ-ийн хэмжээнд төв, авто бааз, 4 салбар бүгд дотоод сүлжээ болон гадаад интернэтийн сүлжээнд холбогдсон. Байгууллагын дотоод сүлжээ байнга ашиглаж өөр хоорондоо сүлжээг ашиглан мэдээлэл, файл дамжуулан ашигладаг. Нийт дотоод сүлжээнд холбогдсон 125 төвд 28, Автобаазад 18, Баянзүрх салбарт 12, СХД салбарт 8, Хан-Уул салбарт 5, Чингэлтэй салбарт 7 байна.
- Компьютер тоног, төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээний чанар: Байгууллагын тоног төхөөрөмж, компьютер, сканер, принтер, бусад төхөөрөмжийг ашиглах журам боловсруулсан ба түүний дагуу хэвийн ашиглаж байна. Мөн засвар үйлчилгээг цаг бүрд нь хийдэг ба, солих шаардлагатай болсон төхөөрөмжийн шинээр авч суурилуулан засаж сэлбэдэг. Засвар үйлчилгээний тэмдэглэл карт хөтөлдөг ба ашиглалтын хугацаа, элэгдлийг тооцож төлөвлөдөг.

Үүнд:

Байгууллагын хэрэглэгчийн компьютерт хийгдсэн үзлэг, оношилгоо, засварын тоо, чанар

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмж, компьютер, хэвлэх төхөөрөмжид эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд түргэн шуурхай засварладаг ба засвар авах боломжгүй тохиолдолд шинээр сольж суурилуулдаг.

-Тухайн жилд тогны хэлбэлзлээс болж DELL Optiplex 3020 загварын 1ш компьютерын эх хавтан, 2ш тэжээлийн блок шатсан ба шинээр авч суурилуулан хэвийн ажиллагааг хангаж ажилласан. Үзлэг оношилгоог 7 хоног бүр хийдэг ба, үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа бүх компьютерүүдэд вирусийн эсрэг “NOD32” 1 жилийн лицензтэй программ суулгасан.




- Интернэт
  - Үүнд:
    1. Нийлүүлэгч компани – Unitel ХХК
    2. Интернэтийн хурд - 10мб
    3. Сард төлж байгаа зардал – Төв, авто бааз, 4 салбар - 11783100
    4. Интернэт тасралтын байдал, тоо, шалтгаан – Интернэт тасрах тохиолдол бага.
    5. Компьютер тоног, төхөөрөмжийн ашиглалт:





Байгууллагын тоног төхөөрөмж, компьютер, сервер, сканер, принтер, болон бусад төхөөрөмжийг ашиглах журам боловсруулсан ба түүний дагуу хэвийн ашиглаж байна. Эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд цаг тухай бүрд шуурхай засварлан ажиллаж байна.

Мөн тоос шороо болсон процессоруудыг задлан цэвэрлэлээ. Ингэснээр процессорын ашиглалтын хугацаа уртсаж, эдэлгээнд сайн нөлөөтэй байдаг.



/Өмнөх/



/дараах/

- Байгууллагын хэмжээнд төв, авто бааз, 4 салбарыг шилэн кабелийн нэгдсэн сүлжээнд холбосон нь маш том амжилт юм. Энэ жилд авто бааз, чингэлтэй салбарыг шилэн кабелийн сүлжээнд холбосон. Ингэснээр байршил харгалзахгүйгээр нэг сүлжээнд файл солилцох, хурал, сургалтыг дотоод гадаад сүлжээний орчинд саадгүй явуулах боломж бүрдэж байна. Мөн дуудлага хүлээн авах, мэдээлэл солилцох, дотоод холбоонд дэвшил гарсан.



Авто баазын шилэн кабель холболт



Чингэлтэй салбарын шилэн кабель холболт

Байгууллагын хэмжээнд бүх салбарын нэгдсэн сүлжээнд холбосноор автобааз, салбар тус бүрд төлж байсан интернэтийн зардлыг хэмжиж байна. Одоо зөвхөн төвд авч байгаа гадаад интернэтийн урсгалаар бүр салбар, автобааз интернэтээ авч байна.

- Сүлжээнд гарсан гэмтлийг түргэн шуурхай засварласан байдал:

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж байгаа гадаад болон дотоод сүлжээний гэмтлийг цаг тухай бүрд шуурхай засварлан ажилладаг. Түргэн тусламжийн төв нь 24 цагийн үйл

ажиллагаатай тусгай төрөлжсөн байгууллага бөгөөд шилэн кабелиар дамжуулан дуудлага хүлээн авч салбар Мэдээлэл шуурхай удирдлагын төвтэй хамтран ажилладаг.

- Хяналтын камерын талаар:

Монгол Улсын эрүүл мэндийн тухай хуулийн 16-р зүйл, үйлчлүүлэгч болон ажилтан албан хаагчдын аюулгүй байдлыг хангах, эмч эмнэлгийн мэргэжилтний хариуцлагыг өндөржүүлэх зорилгоор 2019 оны 10 сарын 14-нд НТТТ-ийн захирлын А/49 тоот тушаалаар байгууллагын “Хяналтын камерын ашиглалтын журам” батлуулсан.

- Хяналтын камерын ерөнхий үзүүлэлт:

Үзүүлэлт, загвар: MS-2210C/H

Дотор аналог камер:


Нягтрал: 800TVL

Линз: 4 мм

Харах өнцөг: 90 градус харна

Шөнийн харалт: 30метр

Видео шахалтын формат: H.265 санах ойд бичлэг нь бага зай эзлэнэ



Гадна камер:

Модел: DS-2CD1211-I5

Гадаа IP камер-МНК

Нягтрал- 2 мегapixel

Харах өнцөг: 90 градус

Шөнийнтусгал: 40метр



- Байгууллагын цахим хуудасны мэдээ мэдээллийг шинэчлэх журмын дагуу тухайн цаг үеийн шаардлагад нийцсэн, шинэ мэдээллийг нийтэлж ажилласан. Мэдээллийн бичгийн алдаа, найруулгыг шалгаж оруулдаг ба Агіал фонттой, юникодоор хөрвүүлэн, үсгийн хэмжээг 10 болгож цахим хуудасны стандартын дагуу оруулдаг.

The collage features several elements: a website header for 'ТУРГЭН ТУСЛАМЖИЙН ТӨВ' (Emergency Medical Service Center) with a 103 helpline; a 'КОРОНАВИРУС (COVID-19) ХАЛДВАРААС СЭРГИЙЛЭ!' (Recovery from COVID-19 infection) graphic; a 'МЭНДЧИЛЭЭ' (Mental Health) section; a 'ВИДЕО ЗӨВЛӨГӨӨ' (Video Lecture) section; a 'ХУУЛЬ ЭРХ' (Law and Order) section; a '24 АЖЛАХ' (24-hour service) graphic; a 'НЭЭЛТЭЙ АЖЛЫН БАЙР' (Press Conference Room) graphic; a 'МАНЯЙ ЦАХИМ ХУУДСАНД ТАВТАЙ МӨРИЛЧ УУ.' (Our friendly staff) graphic; a 'КОРОНАВИРУС ХАЛДВАР (COVID-19)-ЫН СЭРГҮЙЛЭЛТ, ХЯНАЛТ БА ЭМНЭЛ ЗҮЙН МЕНЕЖМЕНТ' (COVID-19 recovery, monitoring and hospital management) graphic; a 'НТТТ-ИЙН ХУРААНГАЙН ИРГЭДИЙГ ХҮЛЭЭН АВАХ ЦАГМИН ХУВААРЬ' (Schedule for patient reception at the Emergency Department) graphic; a 'ХАЛДВАРААС СЭРГИЙЛЭХ АМНЫ ХААЛТЫГ ЗӨВ ХЭРЭГЛЭ!' (Proper use of face masks for infection recovery) infographic; a 'НТТТӨВД "COVID-19"-ИЙН ҮЕД АШИГЛАХ "СӨРӨГ ДАРАМГАТ ЯВАРТАЙ ТУСЛАМЖ"-ИЙН НОН ШААРДАГАТАЙ ТОНОЛГОДСОН ЭМНЭЛГИЙН АВТОМАЦИН ХҮЛЭЭЛЭН ӨГЛӨӨ.' (Automated infection control system at NTHH for COVID-19); and a photo of an ambulance.

Цахим хуудсанд байх шаардлагатай мэдээ мэдээлэл стандарт, шалгуур үзүүлэлтийн дагуу багтсан. Байгууллагын ил тод байдлын мэдээ мэдээлэл, иргэд үйлчлүүлэгчдэд хандсан нийгмийн эрүүл мэндийн мэдээ, мэдээлэл, байгууллагын дотоодод болж буй мэдээлэл, чанарын булан, гадаад харилцаа, дуудлагын статистик мэдээлэл, сургалт сурталчилгаа, эрүүл мэнд, анхан шатны тусламжийн зөвлөгөө, сэрэмжлүүлэг, хууль эрх зүйн зөвлөмж бичих болон байгууллага, үйл ажиллагаагаа сурталчлах зорилгоор өөрийн байгууллагын танилцуулга, бүтэц зохион байгуулалт, үүсэл хөгжил гэх мэт мэдээ мэдээллээр баяжуулан ажиллаж байна.

## КОРОНАВИРУСТ (COVID-19) Халдвараас сэргийлье!


ажиллаж байна. Мөн цахим хуудсаар дамжуулан 84 удаагийн давтамжтай амны хаалт зүүх, гарын ариун цэвэр сахиж, бусад эрүүл мэндийн зөвлөгөө хүргэсэн.

Цахим хуудасны хандалтын тоо 2020 оны жилийн эцэсийн байдлаар 426932 зочин хандсан байна. 2019 онд 350652 байсан. Өмнөх онтой харьцуулбал 17,8%-иар хандалтын тоо өссөн байна.

Цахим хуудасны хандалтыг ихэсгэх зорилгоор шинэ мэдээ мэдээллийг тогтмол оруулж байх, мөн байгууллагын фэйсбүүк хуудсаар дамжуулан мэдээллэж байна.

- Байгууллагын Facebook хуудсаар нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл, байгууллагын мэдээлэл, статистик мэдээлэл, зөвлөгөө, талархал, олон нийтийн ажил гэх мэт мэдээлэл оруулан ажиллаж байна.

Одоогийн байдлаар 15776Like хүрсэн байна.



### About

Нийслэлийн Түргэн Тусламжийн Төв-103

14,802 people like this

15,518 people follow this

<http://www.103.ub.gov.mn/>

Send Message

Community

Edit Details

- Ил тод байдлыг шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан ба цахим хуудсанд байх шаардлагатай мэдээ, мэдээлэл багтсан.

-Цахим хуудсанд эрх зүйн булантай ба үүнд байгууллага болон бусад холбогдох хууль тогтоомжууд нийтлэгдсэн.

Байгууллагын зүгээс мэдээллийн технологийн үйл ажиллагааг дэмжиж ажилладаг. Цаашид байгууллагын техник тоног төхөөрөмжийг шинэчлэх, вэб сайтыг үйл ажиллагааг сайжруулах болон байгууллагын программ хангамж, техник хангамжийг сайжруулах.

- Сургалтад хамрагдах

- Мэдээлэл технологийн шинэлэг техник технологийг нэвтрүүлэх.

-Төв болон салбаруудад камер нэмж суурилуулахаар төлөвлөн ажиллаж байна

Байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай албан ёсны эрхтэй антивирусын эсрэг программ хангамж худалдан авсан байдал:



Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа нийт компьютерүүдэд 32ш вирусийн эсрэг “Nod32” 1 жилийн лицензтэй програм суулгасан.

Ингэснээр гадаад сүлжээний болон зөөврийн төхөөрөмжийн вирусээс сэргийлж байна.

Мэдээллийн аюулгүй байдал болон бусад эрсдэлийг харгалзаж ажилчдын хэрэгцээт файл болон зураг дүрс



зэргийг CD, DVD-д бичиж архивладаг. Мөн хатуу дискт хуулж хадгалдаг.

- Интернэтийн сошиал сувгийг хаасан байдал:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 138 дугаар тогтоолыг тус тус үндэслэн:


Байгууллын мэдээллийн нэгдсэн сүлжээний аюулгүй байдлыг хангаж цахим халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах зорилгоор байгууллагын ажилтан албан хаагчдын ажлын хэрэгцээний компьютерын интернэтийн сүлжээнээс олон нийтийн сүлжээний /Facebook, Twitter, Instagram, Youtube/ -ний сайтуудад нэвтрэх эрхэнд хязгаарлалт хийсэн.

Нууцлал:

- Байгууллагын сервер компьютерын нууц үгийг өөрчилж, системийн шинэчлэлт хийсэн. Мөн гадаад интернэтийн сүлжээг хааж тохиргоо хийж, дотоод сүлжээгээр ажиллаж байна.
- Байгууллагын нийт алба хаагчдын компьютерын нууц үгийг шинээр сольж өгөв.




Авто машины хяналтын GPS цогц систем суурилуулсан.



Сервер лүү хандаж автомашины байршлыг хянаж байна.

Dell PowerEdge R430 – загварын Сервер суурилуулсан.



Цахим хуудас болон сошиал Facebook орчинд мэдээ мэдээлэл нийтэлсэн байдал:



“Би амны хаалтаа тогтмол зүүдэг”, “Маскаа зүүцгээ”, “Маскаа зүүе, Гараа угаая” Facebook-ийн профайл зургийн хүрээг солих аяныг байгууллагын хэмжээнд зохион байгуулж, тус зургийн хүрээг 10-аас доошгүй найзаа челленжид дуудах аян өрнүүлэн амны хаалтыг тогтмол зүүхийг цахим орчноор олон нийтэд уриалсан.

“Facebook Frame” – систем ашиглаж хүмүүс өөрийн профайл зургийг тус хүрээгээр солих аяны хүрээнд:





/Facebook орчинд амын хаалтаа зүүхийг уриалсан хүмүүсийн профайл зургаа сольсон байдал./

### ОЛОЛТ АМЖИЛТ

- COVID-19-ийн эсрэг дотоод нөөц бололцоогоо ашиглан байгууллагын эмч, ажилчдын 1450 ширхэг амны хаалт оёсон.

“Шинэ коронавирус”-ийн дэгдэлтийн үед Эрүүл мэндийн сайдын 2020 оны 01 дүгээр сарын 24 ны өдрийн А/32 тоот тушаал, Нийслэлийн засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 27 ны өдрийн А/108 тоот захирамж, Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн 01 тоот албан даалгаврын дагуу байгууллагын нэг удаагийн амны хаалтны нөөц 2020 оны 02 дугаар сарын 02 ны өдөр тарагдаж дуусах нөхцөл байдлыг харгалзан үзээд болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд 2020 оны 01 дүгээр сарын 31-ны өдрөөс 02 дугаар сарын 07-ны өдрүүдэд дотоод нөөц бололцоогоо ашиглан нийт эмч, сувилагч, жолооч, эмнэлгийн ажилчдын амны хаалтын хэрэгцээг нэмэлтээр хангах, амны хаалтны хомсдолоос урьдчилан сэргийлэх, халдвараас хамгаалах зорилгоор нийт 1450 амны хаалт оёж эмнэлгийн ажилчдын аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Амны хаалт оёх үйл ажиллагаанд ажлын ачааллыг харгалзан үзээд зөвхөн эмийн сангийн эмийн санч, сувилагч нийт 15 ажилтныгажлын цагаар нэмэлтээр ажиллуулсан болно. Материалын өртөг 426,900 төгрөг буюу нэг маск 295 төгрөгөөр хийгдсэн. Энэ үйл ажиллагаанд байгууллагын Удирдлагын зөвлөл, Эмийн зохицуулах хороо, Сувилахуйн алба хамтран ажилласан.



Энэ үйл ажиллагааг дэмжиж ирж танилцсан байгууллагууд:

- “Өргөө” амаржих газар
- Наркологийн эмнэлэг
- АӨСҮТ
- МИАТ
- Эмийн холбоо ТББ

- “Дөрвөн бэрх” ТББ /Солонгост амьдарч буй Монгол иргэд/



Үйл ажиллагааг сурталчилсан байгууллагууд:

- НТТТ вэб сайт, Facebook хуудас
- НЭМГ вэб сайт
- Facebook - Эрүүл мэндийн ажилтнуудын нэгдсэн групп
- MNC телевиз
- “Global Press Journal” олон улсын мэдээллийн сайт



Ороох боох материалыг ариутгалд явуулахын өмнө гараар он сар огноо тавьдаг байсныг огноо дарагч тамгаар тавьснаар дахин засварлах боломжгүй болон ажлыг хөнгөвчилсэн.



5 сарын 12, 21, 27-ний өдрүүдэд Налайх, Багахангай, Багануур, Туул тосгоноос Яаралтай Тусламжийн эмч, сувилагч нар ирж манай байгууллагын болон сувилахуйн албаны үйл ажиллагаатай танилцан харилцан туршлага солилцож, шинээр эмнэлэг үйлчилгээнд хэрэглэгдэж байгаа бүтээлүүдтэй танилцан цаашид хамтран ажиллахаар болсон.



ШГТЭ-ээс зохион байгуулсан “Сувилагч мэргэжилтний хөгжил 2020” сэдэвт үндэсний хэмжээний 6 дахь удаагийн сургалт семинар анх удаа цахим хэлбэрээр зохион байгуулагдсан ба энэ сургалтад манай байгууллагын 16 сувилагч тусгай мэргэжилтэн амжилттай хамрагдсан.



2020 оны 06 дугаар сарын 09-ны өдөр зохион байгуулагдсан Монгол Улсын Ерөнхий сайд эмнэлгийн ажилчидтай уулзсан улсын хэмжээний нэгдсэн уулзалтад Сонгинохайрхан салбарын дуудлагын сувилагч Г.Болормаа **12773** сувилагч тусгай мэргэжилтний төлөөлөл, дуу хоолой нь болж үг хэлсэн.



- **COVID-19 Халдвар цар тахлын үеийн харилцан ажиллагаа, хариу арга хэмжээ дадлага сургуулилт 05 сарын 06-08-ны хооронд явагдсан.**

Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн Гамшгийн штаб тус дадлага сургуулилтын үеэр цар тахлын мэдээ, цагийн байдлын мэдээнд шуурхай хариу мэдэгдэж, хэрэгжүүлсэн арга хэмжээ, саналуудаа нэгтгэн Нийслэлийн Онцгой комисс болон Эрүүл мэндийн нэгдсэн системд цаг тутамд хүргүүлэн ажилласан.



- Байгууллагын хэмжээнд /төв, автобааз, БЗД, СХД, ХУД, ЧД-4 дүүргийн салбар/ өдөр бүр **“ОНЛАЙН ХУРАЛ”** зохион байгуулж байна.

COVID-19 нөхцөл байдлын үед хэсэгчилсэн өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбоотойгоор өдөр тутам ажилчдын хурал, сургалтыг онлайнгаар хийж байна. Тус хурлаар түргэн тусламжийн төвд ирсэн дуудлагын тоо, угаарын хийн хордлого, жирэмсэн болон хүүхдийн яаралтай дуудлага, коронавирусийн сэжигтэй дуудлаганы талаар салбар тус бүрээс мэдээлэл авч ажиллаж байна. Онлайн хуралд НТТТ-ийн төв, авто бааз, Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй, Хан-Уул дүүрэг дэх салбарууд бүрэн хамрагдаж байна.



- **COVID-19-ийн үед ажиллах сөрөг даралтат автомашинтай боллоо.**

Нийслэлийн Түргэн тусламжийн төвд “COVID-19”-ийн үед ашиглах "Сөрөг даралтат яаралтай тусламж"-ийн нэн шаардлагатай тоноглогдсон эмнэлгийн автомашин хүлээлгэн өглөө.

БНХАУ, ӨМӨЗО-ны засгийн ордон, Монголын Улаан загалмайн нийгэмлэг нь Нийслэлийн Түргэн тусламжийн төвд коронавирусын цар тахалын үед ашиглах нэн шаардлагатай эмнэлгийн зориулалттай “Сөрөг даралтат түргэн тусламжийн автомашин”-ыг гардуулан өглөө.

Энэхүү автомашин нь коронавирусын цар тахалын халдварын дэгдэлтийн үед ашиглахад зориулагдсан бөгөөд энгийн түргэн тусламжийн автомашинтай харьцуулахад өөр, COVID-19-ийн халдвартай өвчтөнийг зөөж тээвэрлэх болон машины доторх орчинг бүрэн халдваргүйжүүлэх зориулалттай, амьсгалын аппарат, бусад тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон сөрөг даралтат яаралтай тусламжийн автомашин юм.

Тус автомашин гардуулах арга хэмжээнд Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд, МУЗН-ийн ерөнхийлөгч Н.Энхболд, Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл, БНХАУ-аас Монгол улсад суух бүрэн эрхт элчин сайд Шин Хаймин, Нийслэлийн Засаг даргын Хүний хөгжил, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч Ш.Анхмаа, Монголын Улаан загалмайн нийгэмлэгийн ерөнхий нарийн бичгийн дарга Н.Болормаа, НТТТ-ийн захирал Ц.Пүрэвдаш болон бусад албаны хүмүүс оролцлоо.



- **Тусгай үүргийн онгоц тослоо.**

Дэлхий даяар тархсан цар тахлаас үүдэн манай улс олон улсын нислэг, галт тэрэгний хөдөлгөөнийг түр зогсоосон. Дээрх шийдвэртэй холбогдуулан хэд хэдэн орноос эх орондоо ирэх хүсэлтэй хамгийн гол нь хүндэтгэх шалтгаантай иргэдээ тусгай үүргийн онгоцоор авчирч, тусгаарлаад байгаа билээ. Нийслэлийн Түргэн тусламжийн төв уг үйл ажиллагаанд оролцож тусгай үүргийн онгоцоор ирсэн иргэдийг тусгаарлах байр болон эмнэлэгт хүргэн өгч байна.





- Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан байгууллагынхаа нийт ажилчдын хүүхдүүдийн дунд "БИД КОРОНАВИРУСИЙН ХАЛДВАРААС ГЭР БҮЛЭЭ ХАМГААЛЖ ЧАДНА" сэдэвт "ГАР ЗУРАГ, ЗОХИОН БИЧЛЭГ"-ийн уралдаан зарласан билээ.

Тус тэмцээнийг COVID-19-тэй холбоотойгоор онлайн хэлбэрээр шалгарууллаа. Нийт бүтээлүүдээс шилдэг бүтээлүүдийг шалгаруулж байр эзлүүлэн Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.



- **Байгууллагын хэмжээнд бүх салбар, авто бааз, төв бүгд шилэн кабелийн нэгдсэн нэг сүлжээнд холбогдлоо.**

Мэдээллийн урсгалыг нэг сүлжээнд оруулах, мэдээлэл солилцох үйл ажиллагааг сайжруулах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилгоор автобааз, чингэлтэй салбарыг шилэн кабелийн сүлжээнд холбож дуусгалаа.



Байгууллагын хэмжээнд төв, авто бааз, 4 салбарыг шилэн кабелийн нэгдсэн сүлжээнд холбосон нь маш том амжилт юм. Ингэснээр байршил харгалзахгүйгээр нэг сүлжээнд файл солилцох, хурал, сургалтыг дотоод гадаад сүлжээний орчинд саадгүй явуулах боломж бүрдэж байна. Мөн дуудлага хүлээн авах, мэдээлэл солилцох, дотоод холбоонд дэвшил гарсан.



Авто баазын шилэн кабель холболт



Чингэлтэй салбарын шилэн кабель холболт

Байгууллагын хэмжээнд бүх салбарын нэгдсэн сүлжээнд холбосноор автобааз, салбар тус бүрт төлж байсан интернэтийн зардлыг хэмжиж байна. Одоо зөвхөн төвд авч байгаа гадаад интернэтийн урсгалаар бүр салбар, автобааз интернэтээ авч байна.

- **Орчны цэвэрлэгээ үйлчилгээ тохижилт**

Нийслэлийн Түргэн тусламжийн төв нь Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Уриалга гаргах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай” А/168 тоот захирамжийн дагуу өөрийн өмч, эзэмшил, ашиглалтад байгаа газар болон орчны 50 метр хүртэлх газрын хог хаягдлыг цэвэрлэх, зайлуулах, ногоон байгууламж арчилгааг хийх заалтуудын дагуу төв болон 5 салбар тус бүрдээ өөрийн эзэмшлийн орчны 50 м талбайд хог хаягдлын цэвэрлэгээ болон дотооддоо их цэвэрлэгээг 14 хоног тутамдаа тогтмол хийж, тайлан мэдээг НЭМГ-т цахим хэлбэрээр хүргүүлэн ажиллаж байна.



1. Монгол Улсын Еерөнхийлөгчийн зарлигаар жил бүрийн тав болон аравдугаар сарын хоёр дахь долоо хоногийн бямба гаригийг "Бүх нийтийн мод тарих үндэсний өдөр" хэмээн зарласан билээ.

Энэхүү ажлын хүрээнд НТТТ-н I ээлжийн хамт олон Чингэлтэй салбартаа 2 нэр төрлийн мод тарьж, зүлэг суулгалаа.

Үүнд

- ✓ Шинэстэй 6 ширхэг
- ✓ Хайлаас 12 ширхэг



Мөн Сонгинохайрхан салбар зөв өсөлт хөгжилтийг дэмжин ургалтыг сайжруулах зорилгоор салбарын модонд таналт тайралт хийсэн. Үүний үр дүнд мод хэлбэржиж, ургалт сайжирч байна.



- ХӨСҮТ болон Азийн Хөгжлийн Банктай хамтран **“КОРОНОВИРУСТ ХАЛДВАРЫН (COVID-19) СЭРГИЙЛЭЛТ, ХЯНАЛТ БА ЭМНЭЛ ЗҮЙН МЕНЕЖМЕНТ”** сэдэвт сургалт зохион байгууллаа. Сургалтыг ХӨСҮТ-н ЭТҮХХ-н тандалт судалгааны албаны тасгийн дарга Ж.Нямсүрэн, эмч Б.Соёлмаа хийлээ.

Сургалтад төв болон салбар нэгжийн эмч, сувилагч, эмийн сангийн ажилтан нийт 75 хүн хамрагдлаа. Сургалтад хамрагдсан ажилчдад 1 багц цагийн гэрчилгээ олголоо.



- **Нийслэлийн засаг дарга эмнэлгийн тусламж, үйлчилгээг шуурхай үзүүлсэн нттг-ийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг шагнаж урамшууллаа.**



Нийслэлийн Засаг даргын 2019 оны 12-р сарын 26-ны өдрийн А/1374 дүгээр захирамжийн дагуу агаарын бохирдлыг бууруулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр сайжруулсан шахмал түлшний зөв хэрэглээ, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, түүхий нүүрсний хяналт шалгалтыг өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин сайтар зохион байгуулж ажилласан нийслэлийн нутгийн

захиргааны байгууллага, дүүрэг, хороо, албан тушаалтныг шагнаж, мөнгөн урамшуулал олголоо.

Тухайлбал эмнэлгийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай, чанар хүртээмжтэй үзүүлсэн Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн зохицуулагч Д.Алдартүшиг, их эмч Б.Бат-Ирээдүй, В.Цэрэнхүү, жолооч Л.Батмөнх, Ж.Мөнхжаргал, Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төвийн тасгийн эрхлэгч Д.Оролзод, сувилагч Г.Гантогтох, Б.Чулуунцэцэг нарыг шагнаж урамшуулсан байна.

- **COVID-19-ийн үед автомашины ариутгал, халдваргүйтгэлийг хийж байна.**

Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэрийн дагуу гадны орнуудаас иргэдээ татан авах ажиллагаа зохион байгуулагдаж байна. Нийслэлийн Түргэн Тусламжийн төвийн шалгах механик В.Түвшиндэлгэрээр ахлуулсан ариутгал халдваргүйтгэлийн баг 6 хүний бүрэлдэхүүнтэйгээр тусгай үүргийн онгоцоор ирсэн зорчигчдыг тээвэрлэсэн автомашинууд болон сэжигтэй дуудлагад явсан автомашин бүрийг эцсийн халдваргүйжүүлэлтийг зохих журмын дагуу зохион байгуулан ажиллаж байна.



### 90 ЖИЛ БОЛОН СПОРТЫН АРГА ХЭМЖЭЭ, ГАВЬЯА ШАГНАЛ

Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн захирал Ц.Пүрэвдаш Монгол Улсын Эрүүлийг Хамгаалахын Гавьяат ажилтан цол хүртэв.

Нийслэлийн Түргэн Тусламжийн төвийн дэд захирал С.Ариунболд Хөдөлмөрийн Гавьяаны Улаан тугийн одон мөн тус төвийн статистикч эмч Д.Баярсайхан Хөдөлмөрийн Гавьяаны Улаан тугийн одонгоор энгэрээ мялааж төр түмэн олныхоо хайр хүндэтгэл хүртэж байна. Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харъяа байгууллагуудын спортын таван төрөлт тэмцээнд амжилттай оролцож багийн дүнгээр Нэрдүгээр байр эзэлж шилжин явах цомыг 2 дахь жилдээ хадгалаж үлдэв.



Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн түүхт 90 жилийн ойн баяр тэмдэглэн баярын хурал баярын концерт зохионбайгуулав



Нийслэлийн эрүүл



мэндийн 29 байгууллагаас 300 гаруй бүтээл, сайн туршлага оролцсоноос, шилдэг 22 бүтээлд НЭМГ гэрчилгээ олгосон. Үүнд:

Шинээр нэвтрүүлсэн үйлчилгээний технологийн чиглэлээр “Нийслэлийн түргэн тусламжийн төвийн Эмч, сувилагч, жолооч нарт мэргэжлийн ур чадварын үнэлгээ хийх удирдамж” бүтээлээр шилдэг бүтээлээр шалгарч, сайн туршлагын санд бүртгэж, гэрчилгээ олгосон.

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн Яаралтай тусламжийн эм, тарианы цүнх” бүтээлээр шилдэг бүтээлээр шалгарч, сайн туршлагын санд бүртгэж, гэрчилгээ олгож, амжилттай оролцлоо.

Мананцар үүсгэгч ариутгагч нь албаны байр болон дуудлагын авто машин ариутгаж цаг хугацаа хэмнэж өндөр түвшин ариутгана



ХЯНАСАН:  
ДАРГА  
Ц.ПҮРЭВДАШ

ТАЙЛАНГ  
ЭЭОДАРГА  
С.АРИУНБОЛД



НЭГТГЭСЭН:

ХҮНИЙ НӨӨЦ, СУРГАЛТЫН

АЛБАНЫ ДАРГА

АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

АШИГЛАЛТЫН ИНЖЕНЕР

ДҮН БҮРТГЭЛИЙН ЭМЧ

ХҮҮХДИЙН МЕНЕЖЕР

ЭМИЙН САНГИЙН ЭРХЛЭГЧ

СУВИЛАХУЙН АЛБАНЫ ДАРГА

ПРОГРАМИСТ

ХАЛДВАР СУДЛААЧ

ДАРГЫН ТУСЛАХ, БИЧИГ ХЭРГИЙН

АЖИЛТАН

С.АКЕРКЕ

Б.ОТГОНТЭНГЭР

З.ОРХОНСҮРЭН

С.ОЮУНСУВД

Д.БАЯРСАЙХАН

З.ЭНХЦЭЦЭГ

Э.ОЮУНЗУЛ

Б.ТАНАЦЭЦЭГ

С.АЛТАНГЭРЭЛ

Б.САРАНТУЯА

Д.МӨНХЗУЛ